



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

дэдл. 12. 22 № 31-1/172  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД



Д.ОЮУН-ЭРДЭНЭ

000234003299



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2013.07.06 № ХЗТ/1651  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>2/3</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлд:

“ХХII.ХЭЛЭЛЦСЭН нь: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.07.05 № 1/3796  
танай 2023.07.05-ны № 01/5083-Т

САНГИЙН САЙД  
Б.ЖАВХЛАН ТАНАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

1516031-9  
2023.07.05



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.07.05 № 01/5084

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

**Б.ЖАВХЛАН**

**9761001504**

БАТЛАВ.



БАТЛАВ.



## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын бүрэн эрхт байдал хэмээх Нэгдүгээр бүлгийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах”, Хүний эрх, эрх чөлөө хэмээх Хоёрдугаар бүлгийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.3-т “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж, уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүн өссөн байна.” гэж, мөн бодлогын баримт бичгийн хоёрдугаар дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.2-т “Хөрөнгө оруулагчдын кибер аюулгүй байдлыг хангах, технологид суурилсан хөрөнгийн зах зээлийг цогцлоох дэд бүтцийн шинэчлэл хийж, эрх зүйн орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 4 дэх чиглэлд “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах”, энэ хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 4.1-д “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж дэмжих” болон үүнтэй холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2020-2021 онд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан болно.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 43-т хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хөрөнгө оруулагчид ээлтэй орчныг бүрдүүлэх зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.7-д “Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.” гэж, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний 2.1-д “Хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчныг шинэчилж, зохицуулагч байгууллагын зохицуулалт, хяналтын чадавхыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгана”, 2.1.1-д “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгох” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгыг дэвшүүлсэн болно.

## 1.2. Практик шаардлага

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 1994 онд батлагдаж, 2002 оноос удаах шинэчилсэн найруулгыг мөрдөж байсан бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг 2013 онд шинэчлэн баталж, түүнээс хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Хөрөнгийн зах зээл дэх олон улсын болон дотоод орчны хурдацтай өөрчлөлтийн улмаас шинээр хөгжиж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг нэн даруй зохицуулж, зөв зохистой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн төрийн бодлогын шинэчлэлийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь компанийн бонд гаргахтай холбоотойгоор бусад хууль журамтай цогц уялдаа холбоотой биш, нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаа үр дүнтэй биш, биржийн бус зах зээлийг хязгаарласан, үнэт цаасны эрх бүртгэлийн систем болон арилжааны төлбөр тооцоог зохицуулж байгаа хууль журмын зохицуулалт тодорхой бус, хувьцаат компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт сул байгаа зэрэг нь цаашид зах зээлийг тэлэх, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд зарим хүндрэлүүдийг үүсгэж, хуулийн төслийг боловсруулах дараах шаардлагыг үүсгэж байна. Үүнд:

1. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн орчинд компанийн бондыг биржийн бус зах зээл дээр хаалттай хүрээнд арилжаалж, хөрөнгө босгох, үнэт цаас гаргах, баримтжуулах, холбогдох эрхийг бүртгэлд бүртгүүлэх талаарх зохицуулалт сул байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээл дээр “хаалттай хүрээнд худалдаалах бонд” гэж нэрлэгдээд байгаа санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн зээлийн гэрээний хэлбэртэй, тэдгээрийн эрх нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд эсвэл кастодианд бүртгэгддэггүй бөгөөд хоорондоо худалдах зориулалттай санхүүгийн хэрэгсэлд тооцогдохгүй байгаа тул энэ талаарх зохицуулалтыг тодорхой болгон сайжруулах;

2. Монголын хөрөнгийн бирж дээрх хөрвөх чадварын индекс 2020 оны жилийн эцсийн байдлаар 1.8 хувьтай байгаа нь хөгжингүй орнуудтай харьцуулахад үзүүлэлт маш сул байна. Мөн зах зээл дээрх бүтээгдэхүүний төрөл, чанар муу байгаагаас хөрөнгө оруулагчид багцын хөрөнгө оруулалт хийхэд хүндрэл үүсгэж байна. Цаашид зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх хүрээнд үүсмэл санхүүгийн

хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр нээлттэй болон хаалттайгаар арилжаалах харилцааг тодорхой болгох, банкны хадгаламжийн сертификатыг хөрөнгийн бирж дээр арилжаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг зохицуулалтыг бий болгож хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх;

3. Нийт 24 компани үнэт цаасны анхдагч зах зээл дээр олон нийтэд хувьцаагаа санал болгон үнэт цаас гаргах замаар нээлттэй хувьцаат компани болсон. Сүүлийн жилүүдэд компаниуд хувьцаат компани болох замаар олон нийтээс урт хугацаат хямд өртөгтэй санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийн засаглалаа сайжруулах зорилгоор нээлттэй хувьцаат компани болох сонирхол нэмэгдэх болсон. Гэсэн хэдий ч, олон нийтэд хувьцаа санал болгох хугацаа, шат дамжлага, зардал өндөр, анхдагч зах зээлийн зохион байгуулалт үр ашиггүй төдийгүй олон улсын жишгийн дагуу дээрх үйл ажиллагаа нь андеррайтерийн компаниар дамжуулан явагдахгүй байгаа зэрэг нь үнэт цаас гаргагч компаниудад сөргөөр нөлөөлж, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх буурах, чанартай, хөрвөх чадвартай бүтээгдэхүүний тоо нэмэгдэхгүй байх хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байгаа тул энэхүү үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, зардлыг бууруулах зохицуулалтыг бий болгох;

4. Монгол Улсын үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны горим нь төлбөр тооцооны олон улсын стандартыг 100 хувь хангаж чадахгүй байна. Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цаасыг худалдан авах төлбөрийг урьдчилж 100 хувь байршуулдаг байсныг 2020 оны 3 дугаар сарын 31-ны өдрөөс эхлэн халж олон улсын стандартын дагуу “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/T+2” горимыг нэвтрүүлсэн ч энэ талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд бүрэн тусгагдаагүй байна.

Түүнчлэн олон улсын төлбөр тооцооны дээрх стандарт нэвтэрсэнтэй холбоотойгоор үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал дансны зохицуулалтыг үнэт цаасны зах зээлийн тухай хуульд тодорхой болгон хуульчлах;

5. Хөрөнгийн зах зээлийн гол оролцогч болох үнэт цаасны компаниуд нь хөрөнгийн биржийн арилжаанд үнэт цаас зээлэх, зээлдүүлэх, богино хугацаат хувьцааны арилжаа болон биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг эрхлэх боломж хязгаарлагдмал байгаа нь эдгээр компаниудыг олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь саад болж байгаа тул энэ талын зохицуулалтыг сайжруулах, тодорхой болгох;

6. Урт хугацаат мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь эдийн засагт урт хугацаат төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хямд өртөг бүхий урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэрээр хангах боломжтой байдаг. Гэвч одоогийн хууль эрх зүйн орчин нь хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг хязгаарласан, зохицуулалтын ялгааг сайтар тусгаагүйгээс урт хугацаат мэргэжлийн хөрөнгө оруулагчид үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байна. Цаашид хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалтын сан, хувийн тэтгэврийн сан зэрэг урт хугацаат хөрөнгө оруулагчдыг дэмжих зохицуулалтын уян хатан орчныг бий болгох;

7. Глобал кастодиан банкууд 2017 оноос хойш дотоодын кастодиан банкнуудын үйл ажиллагааны үнэлгээ, дүгнэлтийг газар дээр болон зайнаас тогтмол хийж байгаа бөгөөд үнэлгээний явц, түүний хүрээнд ирүүлж буй асуулгуудаас харахад глобал



кастодиан банк Монгол Улсын зах зээлд орж ирэхэд хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц, эрсдэлийн удирдлагын зохицуулалтаас гадна дотоодын кастодиан банканд хадгалагдах хөрөнгийн өмчлөх эрхийн баталгаажуулалт, түүнд тавигдах хууль эрх зүйн шаардлага нь чухал үзүүлэлт болж байна. Энэ үзүүлэлт нь дотоодын кастодиан банкны харилцагчдын өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах этгээд тодорхой эсэх, харилцагчийн хөрөнгийг кастодианы хөрөнгөөс тусгаарлах тухай зохицуулалт байгаа эсэх зэргээр үнэлэгддэг ба одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид энэ талаарх зохицуулалт хоёрдмол утгатай, ойлгомжгүй байна. Иймд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өмчлөх эрх, бүртгэлийн системийг тодорхойлж, өмчлөх эрх баталгаажуулах эрх бүхий этгээдийг хуулиар тодорхой болгох, холбогдох бусад зохицуулалтыг бүрдүүлэх;

8. Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос 2019 онд хийсэн үнэт цаасны компанийн брокерын үйлчилгээний төлбөр, тулгамдаж буй асуудал сэдэвт судалгааны дүгнэлтээр Монголын хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудын хөрөнгө оруулагчдаас авдаг шимтгэл нь өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад Монголын хөрөнгийн биржийн шимтгэл 99.3% өндөр, үнэт цаасны компанийн шимтгэл 82% өндөр, зохицуулагч байгууллагын шимтгэл зарим Азийн орнуудтай (Тайланд, Энэтхэг, Бангладеш, Хятад) харьцуулахад 2-20 дахин өндөр, клирингийн үйлчилгээний шимтгэл 0.19-0.23%-аар тус тус өндөр байгаа нь тогтоогдсон. Энэхүү нөхцөл байдлыг үүсгэж буй гол шалтгаан нь үнэт цаасны компаниуд болон дэд бүтцийн байгууллагуудын техникийн болон программ хангамжийн системийн асуудал юм. Цаашид хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээг үр ашигтай, хэрэглэгчдэд ээлтэй болгох, зардал, цаг хугацаа хэмнэсэн технологийн дэвшлийг нэвтрүүлэх зохицуулалтын орчныг уян хатан болгох;

9. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д 2019 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй 196 хувьцаат компани байгаа ч эдгээр компаниудын 30 хувь нь мэдээллийн ил тод байдал, Монголын хөрөнгийн биржээс шаардсан тайлагналт, компанийн засаглалын шаардлагыг хангаж ажилладаг, үлдсэн 70 хувь нь тус шаардлагыг хангаж ажилладаггүй байна. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чухал зохицуулалт нь мэдээллийн ил тод байдал, компанийн засаглал, компанийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах явдал юм. Гэвч одоо үйлчилж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалт сул байгаа нь хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлийг сонгох итгэлгүй болоход нөлөөлдөг байна. Дээр дурдсанаас гадна хөрөнгө оруулагчдын эрх ашгийг зохих ёсоор хамгаалахад хувьцаат компаниудын эрх бүхий удирдлагаас гаргасан хувьцаа эзэмшигчдэд нөлөөлөх аливаа шийдвэрийг цаг алдалгүй хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, нэгдсэн стандартыг тогтоох, компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн урсгалыг тодорхой болгож үүнтэй холбоотой үнэт цаас гаргагч болон зах зээлийн оролцогч бусад байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох нь чухал болоод байна. Иймд, зохицуулагч байгууллагын зүгээс цаашид үнэт цаасны зах зээлийн хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэн хийх, мэдээллийн ил тод байдал, компанийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үр ашигтай болгох, хөрөнгө оруулагчдыг хохироохгүй байлгах зохицуулалтыг бий болгох;

10. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай уялдуулах ажлын хүрээнд 2019 онд хийгдсэн давхардал, хийдлийн судалгаагаар нийт 134 давхардал, хийдэл, зөрчил байна гэсэн дүгнэлт гаргасан. Хууль хоорондын уялдаа холбоог сайжруулаагүйгээс

хөрөнгийн зах зээлтэй холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж болзошгүй учир давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Дээрх хүндрэлүүд, эрх зүйн орчны тодорхой бус байдлаас шалтгаалж гадаадын хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцохоос зайлсхийдэг бөгөөд Монгол Улс 2017 онд олон улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинг хөгжлөөр нь ангилдаг "FTSE- Frontier market watch list" -ээс хасагдсан.

Нөгөөтээгүүр 2020 оны 1 дүгээр сараас эхлэн дэлхий нийтийг түгшээж буй Covid-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн дэлхийн орнуудын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, ирэх жилүүдэд ч эдийн засгийн хямрал үргэлжлэх нь тодорхой болоод байна. Манай орны хувьд дотооддоо эдийн засгийн ямар арга хэмжээ авах арга хэмжээнүүд авахаас гадна хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулах замаар эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зайлшгүй нөхцөл бүрдээд байгаа юм.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагыг үндэслэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1 дэх заалтын дагуу хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

1.Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлох бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулна;

2.Мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр бий болгох, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоох, хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлнэ;

3.Олон улсын жишгийн дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж үнэт цаас гаргах ажиллагааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулах замаар нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг хялбар болгох, зардал, өртгийг бууруулах, анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлгүй болгох, андеррайтерийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгана;

4.Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжааны дараа төлбөрт горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэх, үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал данстай холбогдох зохицуулалтыг нэмж тусгана;

5.Хөрөнгийн зах зээл дээр технологийн дэвшилд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг нэвтрүүлэх хүрээнд тэдгээрийг хязгаарлагдмал туршилтын орчинд туршихтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг бүртгэх, зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулагч байгууллагын эрхийг хуулийн хүрээнд нэмэгдүүлнэ;

6.Хөрөнгийн зах зээл дээрх кастодиан банкуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, номинал дансанд өмчлөх эрхийн бүртгэлийн баталгаажуулалт, харилцагчийн хөрөнгийг хадгалах, хамгаалахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгоно;

7.Хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг тодорхой болгох замаар зах зээл дээрх төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хооронд үүсэж байгаа чиг үүргийн давхардлыг арилгана;

8.Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохицуулалтын дүрэм, журмыг нэгтгэх, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгана;

9.Хувьцаат компаниудын гаргасан шийдвэрийн дагуу хийгдэх компанийн үйл ажиллагааны мэдээллийн урсгалыг тодорхой болгож, хувьцаа эзэмшигчдийг тэдгээрийн шийдвэрт нөлөө бүхий мэдээллээр цаг тухай бүр хангах зохицуулалтыг тусгана;

10.Хөрөнгийн зах зээлтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль хоорондын уялдаа холбоог сайжруулж, давхардал, зөрчил, хийдлийг арилгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах эерэг үр дүн гарна:

1.Хөрөнгийн зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулж, урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах үйл явц хялбар болно;

2.Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг олон улсын зарчим, стандартын дагуу хөтлөн явуулах нөхцөл бүрдэнэ;

3.Хөрөнгийн зах зээлийг тэлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэн хадгалж, улмаар татварын орлого нэмэгдэнэ;

4.Олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээ, бизнес загварыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, компаниудын үр ашиг нэмэгдэнэ;

5.Хөрөнгийн зах зээлд дотоодын кастодианаар дамжин оролцох олон улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хамгаалах олон улсын жишигт нийцсэн хууль эрх зүйн орчин бий болж, улмаар үүнтэй холбоотой дотоодын хөрөнгийн зах зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын эрх, үүрэг тодорхой болон гаднын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

6.Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, улмаар санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдэнэ;

7.Хууль хоорондын уялдаа холбоо сайжирч, хуулийн давхардал хийдэл арилан Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчин боловсронгуй болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал.**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төслийг дагалдуулан Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Компанийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Нотариатын тухай, Зар сурталчилгааны тухай зэрэг хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Аж ахуйн нэгжийн албан татвараас хөнгөлөх тухай, Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслийг боловсруулна.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгагдсан.

Тогтоолын хэрэгжилтийг бодлогын баримт бичгүүдийн холбогдох зорилтуудтай уялдуулан хангах зорилгоор Сангийн сайдын 2019 оны 227 дугаар тушаалаар байгуулагдсан Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд, зах зээлийн оролцогчдын төлөөлөл болох Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүрэлдэхүүнээс бүрдсэн Ажлын хэсэг хамтран Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2020 оноос эхлэн боловсрууллаа.

Үнэт цаасны тухай анхны хууль нь иргэдэд өмчийн хуваарилалтыг оновчтой хийх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 1994 онд батлагдаж, улмаар зах зээлийг зохицуулж, хяналт тавих Үнэт цаасны хороо байгуулагдаж, хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд үүсэх үндэс суурь тавигдсан.

Үүнээс хойш компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаа амжилттай хийгдэж, зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд үүсэж эхэлсэнтэй холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2002 онд, үүний дараа дэлхийн санхүүгийн хямралтай холбоотойгоор Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO) -аас гаргасан зарчим, зөвлөмжид тулгуурлан 2013 онд тус тус шинэчлэгдэж батлагдан, мөрдөгдөж байна.

Хөрөнгийн зах зээл дэх олон улсын болон дотоод орчны хурдацтай өөрчлөлтийн улмаас шинээр хөгжиж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг нэн даруй зохицуулж, зөв зохистой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн төрийн бодлогын шинэчлэлийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн компанийн бонд гаргахтай холбоотой зохицуулалтыг сайжруулах, нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг зардал, шат дамжлага багатай болгох, үнэт цаасны арижааны дараах төлбөр тооцоог зохицуулж буй хууль, журмын зохицуулалтыг олон улсын зарчимтай нийцүүлэх шаардлагатай байгаа болон хувьцаат компаниудын засаглал, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт сул байгаа зэрэг нь цаашид зах зээлийг тэлэх, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд зарим хүндрэлүүдийг үүсгэж, хуулийн төслийг боловсруулах шаардлагыг үүсгэж байна.

Эдгээр хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах ерөнхий шинэчлэлүүдийг агуулсан байхаар төлөвлөн боловсрууллаа.

1. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлох бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулна.

2. Мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр бий болгох, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоох, хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлнэ.

3. Олон улсын жишгийн дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж үнэт цаас гаргах ажиллагааг андеррайтерын компаниар дамжуулан зохион байгуулах замаар нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг хялбар болгох, зардал, өртгийг бууруулах, анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлгүй болгох, андеррайтерын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүний тоог өсгөнө.

4. Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжааны дараа төлбөрт горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэх, үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал данстай холбогдох зохицуулалтуудыг нэмж тусгана.

5. Хөрөнгийн зах зээл дээр технологийн дэвшилд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, энэ хүрээнд зохицуулалтын туршилтын орчин үүсгэх эрх зүйн орчныг нээлттэй болгохтой уялдуулан зохицуулагч байгууллагын эрхийг хуулийн хүрээнд нэмэгдүүлнэ.

6. Хөрөнгийн зах зээл дээрх кастодиан банкнуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, номинал дансанд өмчлөх эрхийн бүртгэлийн баталгаажуулалт, харилцагчийн хөрөнгийг хадгалах, хамгаалахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгоно.

7. Хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг тодорхой болгон тогтоох замаар зах зээл дээрх төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хооронд үүсэж буй чиг үүргийн давхардлыг арилгана.

8. Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохицуулалтын дүрэм журмыг нэгтгэх, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгана.

9. Хувьцаат компаниудын гаргасан шийдвэрийн дагуу хийгдэх компанийн үйл ажиллагааны мэдээллийн урсгалыг тодорхой болгож, хувьцаа эзэмшигчдийг тэдгээрийн шийдвэрт нөлөө бүхий мэдээллээр цаг тухай бүр хангах нөхцөл бүрдэнэ.

10. Хөрөнгийн зах зээлтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль хоорондын уялдаа холбоог сайжруулж, шаардлагатай зарим давхардал, зөрчил, хийдлийг арилгана.

Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль, эрх зүйн орчныг цогцоор нь сайжруулах хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн зохицуулалтыг сайжруулан нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулсан бөгөөд хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, татварын орчныг сайжруулах зорилгоор Компанийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын

албан татварын тухай хууль болон холбогдох зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим татварын хөнгөлөлт үзүүлэхээр дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулах явцад Ажлын хэсгийн хэлэлцүүлгийг 3 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, яамд болон бусад холбогдох байгууллагуудын саналыг нийт 3 удаа албан бичгээр авсан.

Хуулийн төсөлд нийтдээ 300 гаруй санал холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, зах зээлийн мэргэжлийн оролцогчид, хөрөнгө оруулагчдаас бичгээр болон хэлэлцүүлгийн явцад ирсэн ба эдгээр саналын 90 орчим хувийг хүлээн авч хуулийн төсөлд тусгаснаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 30 хувьд өөрчлөлт орохоор байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах эерэг үр дүн гарна:

1. Хөрөнгийн зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулж, урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах үйл явц хялбар болно.

2. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг олон улсын зарчим, стандартын дагуу хөтлөн явуулах нөхцөл бүрдэнэ.

3. Хөрөнгийн зах зээлийг тэлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэн хадгалж, улмаар татварын орлого нэмэгдэнэ.

4. Олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, компаниудын үр ашиг нэмэгдэнэ.

5. Хөрөнгийн зах зээлд дотоодын кастодианаар дамжин оролцох олон улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хамгаалах олон улсын жишигт нийцсэн хууль эрх зүйн орчин бий болж, улмаар үүнтэй холбоотой дотоодын хөрөнгийн зах зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын эрх, үүрэг тодорхой болон гаднын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

6. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, улмаар санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдэнэ.

7. Хууль хоорондын уялдаа холбоо сайжирч, хуулийн давхардал хийдэл арилан Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчин боловсронгуй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.34-4.1.39 дэх заалт:**

“4.1.34.“форвард гэрээ” гэж талуудад тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг урьдчилан тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах үүргийг үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

4.1.35.“своп гэрээ” гэж талуудад хоёр өөр санхүүгийн хэрэгслээс үүсэх ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн үүргийг тогтоосон хугацаанд солилцох үүргийг үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

4.1.36.“хаалттай хүрээнд худалдах” гэж үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр 50-аас дээшгүй тооны этгээдэд урьдчилан тохиролцон, эсхүл шууд санал болгон худалдахыг;

4.1.37.“хувьцааны хамтын санхүүжилт” гэж гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч энэ хуулийн 50<sup>1</sup>.1-д заасан этгээдээр дамжуулан өөрсдийн бизнесийн төсөл, хөтөлбөрөө хөрөнгө оруулагчид танилцуулж, хувьцаагаа санал болгох замаар санхүүжилт татах үйл ажиллагааг;

4.1.38.“номиналь данс” гэж харилцагчийн мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг нэгтгэн бүртгэх, төлбөр гүйцэтгэх болон хадгалах зориулалт бүхий дансыг;

4.1.39.“олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл” гэж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олон улсын санхүүгийн байгууллагаас Монгол Улсын үнэт цаасны зах зээлд гаргах өрийн хэрэгслийг.”

**2/5 дугаар зүйлийн 5.1.11, 5.1.12 дахь заалт:**

“5.1.11.энэ хуульд заасан үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат;

5.1.12.олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл.”

**3/10 дугаар зүйлийн 10.15.7-10.15.9 дэх заалт:**



“10.15.7.гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад нийтэд санал болгон үнэт цаасаа гаргах;

10.15.8.үнэт цаасны зах зээлд банкнаас хадгаламжийн сертификат гаргах;

10.15.9.олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл гаргах.”

**4/16<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“16<sup>1</sup> дүгээр зүйл.Олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл**

16<sup>1</sup>.1.Олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр энэ хуульд нийцүүлэн гаргаж болно.

16<sup>1</sup>.2.Энэ хуулийн 16<sup>1</sup>.1-д заасны дагуу гаргах өрийн хэрэгслийг бүртгэх, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журмыг Хороо батална.”

**5/19<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“19<sup>1</sup> дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих**

19<sup>1</sup>.1.Банк нь хадгаламжийн сертификатыг үнэт цаас хэлбэрээр үнэт цаасны зах зээлд арилжихаар нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд худалдаж болно.

19<sup>1</sup>.2.Энэ хуулийн 19<sup>1</sup>.1-д заасан үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификат нь мөнгөн хадгаламжийн гэрээгээр зохицуулагдахгүй.

19<sup>1</sup>.3.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх болон банканд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журмыг Төв банк / Монголбанк/-ны саналыг харгалзан Хороо батална.

19<sup>1</sup>.4.Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификатын үнийн дүн, нөхцөл, төрөл, төвлөрлийн үзүүлэлтэд тавигдах хязгаарлалтыг тогтоох, тайлагнах, хяналт тавихтай холбоотой журмыг Хорооны саналыг харгалзан Төв банк /Монголбанк/ батална.

19<sup>1</sup>.5.Банк нь хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны зөвшөөрөл авна.”

**6/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:**

“20.4.Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргагч болон олон улсын санхүүгийн байгууллагад энэ хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.6, 20.1.8, 20.1.10 дахь заалт хамаарахгүй.

20.5.Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх тогтмол болон тухай бүр ирүүлэх мэдээлэл, түүний ил тод байдлын журмыг Хороо батална.”

**7/24 дүгээр зүйлийн 24.1.19 дэх заалт:**

“24.1.19.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа.”

**8/24 дүгээр зүйлийн 24.10-24.13 дахь хэсэг:**

“24.10.Нийтэд санал болгосноос бусад тохиолдолд зохицуулалттай этгээдийн хувьцааг худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхэд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

24.10.1.хэлцэл хийж буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны байх;

24.10.2.худалдан авагч, барьцаалагч нь энэ хуулийн 27.2.5-д заасан шаардлагыг хангасан байх;

24.10.3.хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулсан байх;

24.10.4.хувьцааг тэргүүн ээлжид худалдан авахтай холбоотой Компанийн тухай хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлсэн байх.

24.11.Салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн зохицуулалттай этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

24.11.1.сүүлийн хоёр улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байх;

24.11.2.салбар, төлөөлөгчийн газар нь байнгын үйл ажиллагаа явуулах ажлын байртай, тухайн салбар, төлөөлөгчийн газарт тогтмол ажиллах ажилтантай байх;

24.11.3.салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

24.11.4.салбар, төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журмыг баталсан байх.

24.12.Энэ хуулийн 24.1.1-24.1.14-т заасан зохицуулалттай этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бичиг баримтыг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

24.13.Энэ хуулийн 24.12-т заасан шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг, тайлбар гаргуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр сунгаж болно.”

**9/25 дугаар зүйлийн 25.1.12 дахь заалт:**

"25.1.12.үйл ажиллагаатай холбогдох цахим сүлжээ, системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангах."

**10/27 дугаар зүйлийн 27.2.8- 27.2.12 дахь заалт:**

"27.2.8.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан талаарх нотлох баримт;

27.2.9.хувьцаа эзэмшигч (хувьцаат компанийн хувьд нийт хувьцааны таваас дээш хувийг эзэмшигч), төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан болон мэргэжилтэн нь дараах шалгуурыг хангасан байна:

27.2.9.1.Эрүүгийн хуульд заасан авлигын, эдийн засгийн болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргийн нэгд эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

27.2.9.2.зээл, батлан даалт, баталгааны гэрээний аль нэгд гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй;

27.2.9.3.сүүлийн таван жилд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байсан үнэт цаасны зах зээлд оролцогчийн тусгай зөвшөөрөл зөрчлийн улмаас хүчингүй болж байгаагүй байх;

27.2.9.4.гүйцэтгэх удирдлага, эсхүл мэргэжилтэн нь өөр зохицуулалттай этгээдийн тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй байх;

27.2.9.5.тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбоотой журамд заасан бусад шаардлагыг хангасан байх.

27.2.10.үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай, түүнийг хэрэгжүүлэх хараат бус дотоод хяналтын ажилтантай байх;

27.2.11.гадаад мэргэжилтнүүдийн тоо нийт ажилтны 30 хувиас хэтрэхгүй иргэд байх;

27.2.12.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх."

**11/27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг:**

"27.6.Энэ хуулийн 24.1.6-24.1.9, 24.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

27.6.1.үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалттай байх;

27.6.2.үндсэн үйл ажиллагааг эрхлэх чиглэлийн болон мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

27.6.3.үйл ажиллагаанд ашиглах программ хангамж мэдээллийн нууцлал, мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангасан байх;

27.6.4.бусад дэд бүтцийн байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх;

27.6.5.дотоод мэдээлэл эзэмшигчдийн, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх.”

**12/33 дугаар зүйлийн 33.2.4 дэх заалт:**

“33.2.4.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тухайд Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан тусгай программ хангамжтай байх.”

**13/33 дугаар зүйлийн 33.7.4, 33.7.5 дахь заалт:**

“33.7.4.хороонд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлээгүй;

33.7.5.энэ хуулийн 33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур, нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон.”

**14/33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсэг:**

“33.10.Энэ хуулийн 24.1.19-д заасан зохицуулалттай үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.”

**15/36 дугаар зүйлийн 36.17, 36.18 дахь хэсэг:**

“36.17.Брокер үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн номиналь данс эзэмшихэд тавигдах нөхцөл шаардлага, тухайн дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

36.18.Брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

36.18.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, клирингийн байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;

36.18.2.брокерийн үйл ажиллагаа эрхлэх хоёроос доошгүй мэргэжилтэнтэй байх;

36.18.3.нягтлан бодох бүртгэлийн зааварт нийцсэн шаардлагатай мэдээлэл, харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн бүртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг хадгалах, мэдээлэл өгөхтэй

холбоотой Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан тусгай программ хангамжтай байх.”

**16/37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг:**

“37.8.Дилерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

37.8.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

37.8.2.үнэт цаасны брокерын үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд эрхэлсэн байх;

37.8.3.дилерийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх.”

**17/39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг:**

“39.3.Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

39.3.1.хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх;

39.3.2.хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээ, хэлцлийг боловсруулж, хянах хуулийн мэргэжилтэнтэй, эсхүл үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээс энэ чиглэлээр тогтмол үйлчилгээ авахаар гэрээ байгуулсан байх;

39.3.3.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх.”

**18/40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг:**

“40.7.Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

40.7.1.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх;

40.7.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

40.7.3.эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн аль нэгд гүйцэтгэх удирдлага, эсхүл бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

40.7.4.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь гадаадын, эсхүл өөрийн орны санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлж байсан туршлагатай байх.”

#### **19/41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсэг:**

"41.7.Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

41.7.1.үнэт цаасны үнэлгээ, үнийн тооцооллыг хийх, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах гурваас доошгүй мэргэжилтэнтэй байх;

41.7.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

41.7.3.үнэт цаас гаргагч этгээдтэй байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөл нь дараах зүйлийг тусгасан байх:

41.7.3.1.гэрээ хүчинтэй байх хугацаа;

41.7.3.2.талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

41.7.3.3.нийтэд санал болгож буй үнэт цаасны захиалгын хугацаа;

41.7.3.4.үнэт цаасны захиалгыг авах, хуваарилах арга аргачлал;

41.7.3.5.үнэт цаасны үнийг тогтворжуулах хугацаа, арга хэлбэр;

41.7.3.6.үйлчилгээний хураамжийн хэмжээ.

41.7.4.үнэт цаасны зах зээлд брокерын, эсхүл дилерийн үйл ажиллагааг хоёр жилийн хугацаанд эрхэлж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас гишүүнчлэлийн үүрэг хангалттай биелүүлсэн талаарх дүгнэлт гаргуулсан, Хорооны баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байх."

#### **20/42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсэг:**

"42.19.Хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хувьцаат компани хэлбэртэй банкны хувьцаа эзэмшигчийн тархалтын мэдээллийг Төв банк /Монголбанк/-аас шаардсан тохиолдолд мэдээллийн эзнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй."

#### **21/45 дугаар зүйлийн 45.10, 45.11 дэх хэсэг:**

"45.10.Номиналь эзэмшигчээс бусад харилцагчийн үнэт цаасыг тухайн харилцагчийн нэр дээр бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.

45.11.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцоно."

#### **22/46 дугаар зүйлийн 46.7-46.10 дахь хэсэг:**

"46.7.Кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь харилцагчийн нэрийн өмнөөс түүний зөвшөөрлөөр үнэт цаасны төлбөр, шилжүүлэг гүйцэтгэж болно.

46.8.Кастодианы харилцагч нь гадаад улсад кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй номиналь эзэмшигч, эсхүл итгэмжлэгдсэн өмчлөгч байх тохиолдолд бенефициар өмчлөгчийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу таньж мэдэж, бүртгэнэ.

46.9.Энэ хуулийн 46.8-д заасан кастодианы харилцагч нь Хороо, үйлчилгээ үзүүлж буй кастодианы эрхэлж байгаа этгээдийн шаардлагаар бенефициар өмчлөгчдийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

46.10.Кастодианы үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

46.10.1.тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага бол Компанийн тухай хуульд заасан шаардлага хангасан төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

46.10.2.мэргэжилтнүүд нь банк, санхүү, хөрөнгийн зах зээл дээр ажиллаж байсан туршлагатай, үнэт цаасны зах зээл дээр ажиллах эрх авсан, гурваас дээш жил ажилласан зургаа болон түүнээс дээш мэргэжилтэнтэй байх;

46.10.3.Төв банк /Монголбанк/, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, бусад мэргэжлийн оролцогч болон харилцагчтай мэдээлэл солилцох, төлбөр тооцоо гүйцэтгэх тоног төхөөрөмж, техник, программ хангамжийг бүрдүүлсэн байх;

46.10.4.кастодианы үйл ажиллагаа явуулах сүлжээ, программ хангамжид гэмтэл, саатал гарсан, давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүнд хадгалсан мэдээллийн бааз, бусад өгөгдлийг давхар хадгалах, сэргээх системтэй байх;

46.10.5.нийтэд холбогдох мэдээлэл хүргэх өөрийн тогтмол ажилладаг цахим хуудаатай байх;

46.10.6.тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь банк бол дараах шаардлагыг хангасан байна:

46.10.6.1.кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгаар, бие даасан нэгжтэй байх;

46.10.6.2.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж нь харилцагчид үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангасан дэд бүтэцтэй байх;

46.10.6.3.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн бүртгэл, тайлан, тооцоо болон албан бичиг хэрэг хөтлөлт нь банкны үндсэн болон бусад үйл ажиллагааны

бүртгэл, тайлан, тооцоо, албан бичиг хэргээс тусдаа хөтлөгдөх нөхцөл боломжоор хангасан, эдгээр мэдээлэлд зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжид ажиллаж буй ажилтан нэвтрэх боломжтой байх;

46.10.6.4.банкны үйл ажиллагааг гурван жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн байх;

46.10.6.5.гурваас доошгүй гишүүнээс бүрдсэн төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд тэдгээрийн нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх.”

**23/47 дугаар зүйлийн 47.8, 47.9 дэх хэсэг:**

“47.8.Нээлттэй хувьцаат компани болох урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах зорилгоор хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэж, хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож, тэдгээрийн хооронд арилжиж болно.

47.9.Энэ хуулийн 47.8-д заасан харилцааг зохицуулсан нарийвчилсан журмыг Хороо батална.”

**24/50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг:**

“50.5.Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

50.5.1.хувьцаа эзэмшигч нь дараах этгээд байна:

50.5.1.1.банк, санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллага;

50.5.1.2.сүүлийн таван жилд жилийн аудитлагдсан тайлангаар үйл ажиллагааны борлуулалтын орлого нь нэг тэрбум төгрөгөөс доошгүй, Монгол Улсад бүртгэлтэй компани;

50.5.1.3.зэрэглэл тогтоох үйл ажиллагааг гурваас доошгүй жил эрхэлж буй гадаад улсын зэрэглэл тогтоох байгууллага;

50.5.1.4.компанийн нийт гаргасан хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй иргэн.

50.5.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх;

50.5.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах дүрэм, журам, аргачлал, тэмдэглэгээ, тайлангийн загварыг баталсан байна:

50.5.3.1.зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загвар;



50.5.3.2. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам болон ёс зүйн дүрэм;

50.5.3.3. үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам;

50.5.3.4. тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журам;

50.5.3.5. шинжээчтэй байгуулах гэрээний үндсэн загвар;

50.5.3.6. арга, аргачлал, үзүүлэлт, тэмдэглэгээ, тодорхойлолтын тухай танилцуулга.

50.5.4. олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудастай байх;

50.5.5. зэрэглэл тогтоох хороо таваас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүн хуульд заасан мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх;

50.5.6. зэрэглэл тогтоох чиглэлээр ажилласан ажлын туршлагатай хоёроос доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх, эсхүл эдийн засаг, санхүүгийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын чиглэлээр таваас доошгүй жил ажилласан дөрвөөс доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх."

**25/50<sup>1</sup> дүгээр зүйл:**

**"50<sup>1</sup> дүгээр зүйл. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа**

50<sup>1</sup>.1. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай программ хангамжаар дамжуулан гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчийн хооронд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулах зорилготой байна.

50<sup>1</sup>.2. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны үндсэн орлого нь гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчид тусгай программ хангамж ашиглуулснаас авах шимтгэлээс бүрдэнэ.

50<sup>1</sup>.3. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо тогтооно.

50<sup>1</sup>.4. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 11.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамаарахгүй.

50<sup>1</sup>.5. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавигдах гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ, хөрөнгө оруулалт татах хугацаа болон иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, хөрөнгө оруулах хөрөнгийн дээд хэмжээ, хязгаарлалтыг Хороо тогтооно."

**26/51 дүгээр зүйлийн 51.1.6 дахь заалт:**

“51.1.6.хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг.”

**27/51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг:**

“51.4.Энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх хүсэлт гаргаж болно:

51.4.1.Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирал дараалан хангаж ажилласан байх;

51.4.2.Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар сайн болон хангалттай үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байх.”

**28/63 дугаар зүйлийн 63.1.20-63.1.24 дэх заалт:**

“63.1.20.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журмыг тогтоож, үйлчилгээ үзүүлэгч этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;

63.1.21.хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой журмыг батлах;

63.1.22.үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон журмыг батлах;

63.1.23.үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэл, өв залгамжлалаар шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг батлах;

63.1.24.хуульд заасан бусад.”

**29/78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсэг:**

“78.3.Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох үйлдлээс сэргийлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.”

**30/80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг:**

“80.6.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.”

**31/88<sup>2</sup> дугаар зүйл:**

**“88<sup>2</sup>.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг**

88<sup>2</sup>.1.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.

88<sup>2</sup>.2.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

88<sup>2</sup>.2.1.холбогдох мэргэжлийн байгууллагаас ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн дүгнэлт гарсан байх;

88<sup>2</sup>.2.2.үнэт цаас үйлдвэрлэхэд ашиглагддаг шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй байх;

88<sup>2</sup>.2.3.үнэт цаас үйлдвэрлэхтэй холбоотой аюулгүй ажиллагаа, нууцлалыг хангасан байх.

88<sup>2</sup>.3.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

88<sup>2</sup>.3.1.ерөнхий танилцуулга, үүсгэн байгуулах баримт бичиг;

88<sup>2</sup>.3.2.үнэт цаас үйлдвэрлэхтэй холбоотой тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааг ханган ажиллах хүний нөөцийн мэдээлэл;

88<sup>2</sup>.3.3.үнэт цаас үйлдвэрлэх горимыг тогтоосон журам, илүүдэл болон алдаатай үнэт цаасны устгал, түүний бүртгэлд тавих хяналт, байгууллагын дотоод хяналтад мөрдөгддөг дүрэм, журмын хуулбар."

**2 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "нийслэл," гэсний дараа "олон улсын санхүүгийн байгууллага," гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.13 дахь заалтын "хөрөнгө" гэсний өмнө "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан" гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийн "24.1.17" гэсний дараа ", 24.1.19" гэж, мөн зүйлийн 33.6.2 дахь заалтын "33.3" гэсний дараа ", 33.10" гэж, 36 дугаар зүйлийн 36.8 дахь хэсгийн "дансанд" гэсний дараа ", эсхүл номиналь дансанд" гэж, мөн зүйлийн 36.11 дэх хэсгийн "харилцагчийн нэр дээр" гэсний дараа ", эсхүл мөнгөн хөрөнгийн номиналь" гэж, 41 дүгээр зүйлийн 41.4.1 дэх заалтын "бэлтгэх," гэсний дараа "үнэт цаас гаргагч түүний санал болгох үнэт цаасны талаар магадлан шинжилгээ хийх," гэж, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийн "бүртгэлийн" гэсний өмнө "тухайлсан" гэж, 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалтын "дилерийн" гэсний дараа ", үнэт цаасны итгэмжлэн удирдах" гэж, 63 дугаар зүйлийн 63.1.6, 63.1.10 дахь заалтын "хасах" гэсний дараа ", түүнтэй холбоотой нарийвчилсан журмыг тогтоох" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:**

"3.1.Энэ хуулиар үнэт цаасыг нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд гаргах, арилжих, бүртгэх, клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна."

**2/4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.4 дэх заалт:**

"4.1.1."үнэт цаасны зах зээл" гэж үнэт цаасыг бүртгүүлэх, гаргах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зах зээлийн харилцааг;

4.1.2.“биржийн зах зээл” гэж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн үнэт цаасыг арилжихтай холбогдсон харилцааг;

4.1.3.“биржийн бус зах зээл” гэж энэ хуулийн 4.1.19-д заасан этгээд хууль тогтоомжоор хориглоогүй, өөрийн өмчлөлийн болон өмчлөгчөөс эрх олгосон хөрөнгөөр санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг;

4.1.4.“үнэт цаасны анхдагч зах зээл” гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа хөрөнгө оруулагчид нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд худалдахтай холбогдсон харилцааг;”

**3/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:**

“4.1.7.“үүсмэл санхүүгийн хэрэгсэл /дериватив/” гэж опцион гэрээ, фьючерсийн гэрээ, форвард гэрээ, своп гэрээ болон Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг;”

**4/4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт:**

“4.1.13.“хадгаламжийн бичиг гаргагч /депозитор/” гэж Монгол Улсын болон гадаад улсын үнэт цаасны хадгаламжийн /кастодиан/ үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг;”

**5/4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалт:**

“4.1.19.“мэргэжлийн хөрөнгө оруулагч” гэж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, андеррайтер, дилер, үнэт цаасны итгэмжлэн удирдах, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зэрэг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж тогтоосон бусад этгээдийг;”

**6/4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь заалт:**

“4.1.27.“үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хөрөнгийн биржийн бүртгэл” гэж тухайн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын биржийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг;”

**7/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсэг:**

“9.3.Урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар нэмж гаргахдаа хялбаршуулсан журмаар Хороонд бүртгүүлэх ба түүнтэй холбогдсон журмыг Хороо батална.

9.4.Урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол энэ талаар

Хороонд мэдээлэл хүргүүлэх ба олон нийтэд өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.”

**8/9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэг:**

“9.13.Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас энэ хуулийн 9.6-д заасны дагуу нийтэд санал болгон гаргах үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэсэн, нийтэд санал болгох болон үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг бүртгэсэн байгууллага хариуцахгүй.”

**9/12 дугаар зүйлийн 12.5-12.7 дахь хэсэг:**

“12.5.Энэ хуулийн 12.4-т заасан тайланд үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр арилжих бэлтгэл хангагдсан тухай үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолтыг хавсаргасан байна.

12.6.Хороо үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах ба зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно.

12.7.Хороо доор дурдсан нөхцөлийн аль нэг нь бүрэн хангагдсан бол үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсон гэж үзнэ:

12.7.1.үнэт цаасыг тогтоосон үнээр гаргаж байгаа тохиолдолд санал болгосон бүх үнэт цаас худалдагдсан буюу татан төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;

12.7.2.үнэт цаасыг захиалгын бүртгэлийн аргаар санал болгосон тохиолдолд төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;

12.7.3.үнэт цаасыг санал болгосны дараа түүний худалдаагүй үлдсэн хэсгийг андеррайтер нь худалдан авч энэ хуулийн 12.7.1 эсхүл 12.7.2-т заасан нөхцөлийг бүрдүүлсэн.”

**10/16 дугаар зүйл:**

**“16 дугаар зүйл.Компанийн өрийн хэрэгсэл**

16.1.Компанийн өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр энэ хуульд нийцүүлэн гаргана.

16.2.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх журмыг Хороо батална.

16.3.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь дараах нөхцөлийн аль нэгийг хангасан байна:

16.3.1.үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаатай байх;

16.3.2.санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр зэрэглэл тогтоолгосон байх.

16.4.Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан компани тодорхой үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.

16.5.Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдах тохиолдолд эхний гаргах өрийн хэрэгсэл нь энэ хуулийн 10.1-д заасан хугацаанд гарсан байна.

16.6.Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-д заасан болон бусад этгээд нь компанийн өрийн хэрэгслийг эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээллийг тухай бүр шаардах, барьцаа, баталгааны гэрээг байгуулах, түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг итгэмжлэлгүйгээр эдэлнэ.”

#### **11/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:**

“17.3.Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад нийтэд санал болгон үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэнэ.”

#### **12/19 дүгээр зүйл:**

##### **“19 дүгээр зүйл.Үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих**

19.1.Үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр гаргах, арилжих, оролцогчид тавих нөхцөл, шаардлагыг тогтоох ерөнхий журмыг Хороо батална.

19.2.Биржийн зах зээл дээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэгсэл, стандарт гэрээний нөхцөл, түүнийг арилжих журмыг тухайн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага батална.

19.3.Биржийн бус зах зээл дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжихдаа олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, стандартыг баримтална.”

#### **13/20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт:**

“20.1.6.санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд, мөн жилийн эцсийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;”

#### **14/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:**

“21.2.Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон, хууль бус үйл

ажиллагаа явуулсан гэж үзвэл Хороо үнэт цаас гаргагчид учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шаардах, тухайн шийдвэр болон түүнийг үндэслэн хийсэн хэлцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг итгэмжлэлгүйгээр эдэлж болно.”

**15/29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт:**

“29.1.2.хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, клиринг, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага зэрэг эрх бүхий өөрийгөө зохицуулах байгууллагаас гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий бол;”

**16/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:**

“33.3.Энэ хуулийн 24.1.15-24.1.17-д заасан зохицуулалттай үйл ажиллагааны төрөл тус бүрд тавих нөхцөл, шаардлагыг энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага, Хуульчдын холбоо, хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн саналыг харгалзан Хороо тогтооно.”

**17/35 дугаар зүйлийн 35.8, 35.9 дэх хэсэг:**

“35.8.Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь Хорооны төлөөлөл байна.

35.9.Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулахтай холбогдсон журмыг энэ хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо батална.”

**18/36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсэг:**

“36.14.Брокерын нэр дээрх харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь данснаас бусдын өмнө брокерын хүлээсэн үүргийг гүйцэтгэхгүй ба эрх бүхий этгээдээс брокерын дансыг битүүмжлэх тохиолдолд харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь дансыг давхар битүүмжлэхийг хориглоно.”

**19/36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсэг:**

“36.16.Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлөөр эрхлэх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

36.16.1.Хорооноос тогтоосон хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

36.16.2.Хорооноос тогтоосон тусгай нөхцөл шаардлагыг хангасан үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн программтай байх ба программ нь дараах нөхцөлийг хангасан байна:

36.16.2.1.гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн болон кастодиан, брокерын компанийн дүрэм, журамд нийцүүлэн харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;

36.16.2.2.харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;

36.16.3.харилцагчийн данс хариуцсан мэргэжилтэнтэй байх ба уг мэргэжилтэн нь үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй байх;

36.16.4.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерын үйл ажиллагааны журамтай байх;

36.16.5.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэхэд баримтлах бодлого, бизнесийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тооцоололтой байх."

#### **20/41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг:**

"41.1.Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох, захиалга авах, хуваарилах, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ."

#### **21/43, 44 дүгээр зүйл:**

#### **"43 дугаар зүйл.Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа**

43.1.Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа (цаашид "клирингийн үйл ажиллагаа" гэх) гэж клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд (цаашид "клирингийн төв" гэх)-ээс хэрэгжүүлэх доор дурдсан үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:

43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцлийг хуваан худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч тал буюу дундын зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

43.1.2.үнэт цаасны арилжааны хэлцлийн эсрэг тал болсонтой холбоотой эрх үүргийг хэрэгжүүлэх;

43.1.3.үнэт цаасны арилжааны баталгаажсан болон арилжааны бус хэлцлийн дагуу үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэхтэй холбоотой арилжаанд оролцогч талуудын хүлээх үүргийг хэлцэл тус бүрээр эсхүл цэвэршүүлсэн дүнгээр тодорхойлох;

43.1.4.үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөр тооцооны байгууллагад илгээх;

43.1.5.үнэт цаасны арилжааны хэлцэлд оролцогч талууд үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан үүсэх талуудын болон системийн эрсдэлийг удирдах.



43.2.Клирингийн төв нь клирингийн үйл ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.

43.3.Клирингийн төв гишүүнчлэлтэй (цаашид "клирингийн гишүүн" гэх) байх бөгөөд клирингийн төвийн тусгай зөвшөөрлийн шалгуурыг Хорооны журмаар, клирингийн төвийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн төвийн журмаар тус тус зохицуулна.

43.4.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас барьцаа шаардах, барьцаа хөрөнгийг өөрийн дансанд байршуулах, баталгаажсан хэлцэлтэй холбоотой гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.5.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор үнэт цаасны компани өөрийн харилцагчаас захиалгын үнийн дүнгийн тодорхой хувиар барьцаа байршуулахыг шаардах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.6.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааны системийн эрсдэлийг удирдах зорилгоор клирингийн төв нь төлбөрийн баталгааны сан байгуулах, төлбөрийн баталгааны сангийн үйл ажиллагааны журам гаргах, удирдан зохион байгуулах үүрэгтэй. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн төв, клирингийн гишүүний төлбөрийн баталгааны санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.

43.7.Шүүхээс үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын баталгаажсан хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцсон тохиолдолд тухайн баталгаажсан хэлцлийн клиринг, төлбөр тооцоог хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал, шимтгэл, баталгаажсан хэлцлийн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

43.8.Үнэт цаасны арилжааны баталгаажсан хэлцэлтэй холбоотой төлбөрийн үүрэг бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд тухайн хэлцлийн клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, клирингийн төв, төлбөр гүйцэтгэх байгууллагын энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг зогсоохгүй.

43.9.Клирингийн төв нь тухайн мэдээллийг нийтэд нээлттэй болгох талаар Хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас бичгээр шаардсан, эсхүл хууль хяналтын байгууллагын шаардлага, шүүхийн шийдвэр гарснаас бусад тохиолдолд өөрийн гишүүн, түүний харилцагчийн талаарх өөрт байгаа бүх мэдээллийн нууцлалыг хадгална.

43.10.Клирингийн үйл ажиллагааны журмыг Хороо батална.

43.11.Төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан клирингийн гишүүний хөрөнгийг холбогдох хуулийн дагуу хуваарилахдаа тэргүүн ээлжид үнэт цаасны төлбөрийн үүргийг барагдуулна.

#### **44 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа**

44.1. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий хуулийн этгээдээс хэрэгжүүлэх доор дурдсан үйл ажиллагааг ойлгоно:

44.1.1. холбогдох байгууллагаас ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах;

44.1.2. үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг хэлцэл тус бүрээр, эсхүл цэвэршүүлсэн дүнгээр нэгэн зэрэг гүйцэтгэх;

44.1.3. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарвал тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох;

44.1.4. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээний тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх.

44.2. Үнэт цаасны төлбөр тооцоог тухайн арилжаа явагдсанаас хойш ажлын гурван өдөрт багтаан гүйцэтгэнэ.

44.3. Үнэт цаасны шилжүүлэг хийгдсэнээр үнэт цаасны өмчлөх эрх шилжсэнд тооцно."

#### **22/45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг:**

"45.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаас хадгалуулагчийн өмчлөл дэх үнэт цаасны ногдол ашиг болон үнэт цаас худалдсаны төлбөрийг банкин дахь харилцагчийн мэдүүлсэн дансанд шилжүүлнэ."

#### **23/45 дугаар зүйлийн 45.9 дэх хэсэг:**

"45.9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь нийтэд болон хаалттай хүрээнд худалдахаар санал болгосон үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн санд бүртгэнэ."

#### **24/48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг:**

"48.2. Клирингийн үйл ажиллагааг тухайн арилжааг зохион байгуулж байгаа байгууллагаас өөр байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд уг байгууллагыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хөрөнгийн биржийн арилжаанд оролцсон гэж үзэхгүй."

#### **25/54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг:**

"54.1. Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ."

#### **26/63 дугаар зүйлийн 63.1.19 дэх заалт:**

"63.1.19.энэ хуулийн 9.3-т заасан үнэт цаасыг бүртгэх;"

**4 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын "хугацаа дуусмагц" гэснийг "нөхцөлийн дагуу" гэж, мөн зүйлийн 4.1.11 дэх заалтын "гэрээний талуудад үүсгэх гэрээ буюу" гэснийг "үүсгэдэг" гэж, мөн зүйлийн 4.1.21 дэх заалтын "мэдээллийн" гэснийг "нийгмийн цахим сүлжээ, мэдээлэх" гэж, 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтын "Аймаг" гэснийг "Засгийн газар, аймаг" гэж, мөн зүйлийн 5.2.2 дахь заалтын "зохицуулалттай" гэснийг "үнэт цаасны" гэж, мөн зүйлийн 5.2.4 дэх заалтын "банкнаас гаргасан" гэснийг "энэ хуулийн 5.1.11-т зааснаас бусад" гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн ", эсхүл" гэснийг "болон" гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх заалтын, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн зүйлийн 17.1 дэх хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.6.2, 42.6.3 дахь заалтын "хөрөнгийн биржид" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад" гэж, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн гарчгийн "Хөрөнгийн биржид" гэснийг "Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад" гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Компанийн" гэснийг "Үнэт цаас гаргагчийн" гэж, мөн зүйлийн 9.16 дахь хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн "хөрөнгийн биржийн" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын" гэж, 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийн "Санхүүгийн зохицуулах хороонд" гэснийг "Хороонд" гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн, мөн зүйлийн 10.5.9 дэх заалтын "арилжих" гэснийг "худалдах" гэж, 10 дугаар зүйлийн 10.9.9 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 56.2.8 дахь заалтын "хөрөнгийн биржээс" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "зохицуулалттай этгээдтэй" гэснийг "андеррайтертэй" гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн "арилжсан" гэснийг "худалдсан" гэж, мөн зүйлийн 12.8 дахь хэсгийн "зах зээлийн арилжааг" гэснийг "зах зээлд худалдах ажиллагааг" гэж, мөн зүйлийн 12.9 дэх хэсгийн "арилжаанаас" гэснийг "анхдагч зах зээлээс" гэж, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн, мөн зүйлийн 49.1.4 дэх заалтын, 55 дугаар зүйлийн 55.1.4 дэх заалтын, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийн "хөрөнгийн бирж" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага" гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын "арилжааны тооцооны" гэснийг "клирингийн" гэж, мөн зүйлийн 24.1.8 дахь хэсгийн "арилжааны төлбөрийн" гэснийг "төлбөр тооцооны" гэж, мөн зүйлийн 24.7 дахь хэсгийн "24.1.14" гэснийг "-24.1.5, 24.1.14" гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн "Зохицуулалттай" гэснийг "Энэ хуулийн 24.1.1-24.1.14-д заасан зохицуулалттай" гэж, мөн зүйлийн 35.5 дахь хэсгийн "шалгаруулалтыг" гэснийг "шалгаруулалт, мэргэжилтэнд зориулсан үргэлжилсэн сургалтыг" гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн "стандарт нөхцөл, гэрээ байгуулах журмыг" гэснийг "нөхцөл, түүнд тавигдах шаардлагыг" гэж, мөн зүйлийн 36.15 дахь хэсгийн "олгосноос" гэснийг "олгох, харилцагчийн болон брокерийн номиналь данс хоорондын шилжүүлгээс" гэж, 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн "оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч" гэснийг "оруулагч" гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн "болон" гэснийг "хөтлөх эрхтэй ба" гэж, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн "цаасыг" гэснийг "цаасны тухайлсан бүртгэл хөтөлж," гэж, 47 дугаар зүйлийн 47 дугаар зүйлийн 47.2, 47.3, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 49.2, 49.3 дахь хэсгийн, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн

“Хөрөнгийн бирж” гэснийг “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж, 47 дугаар зүйлийн 47.4.2 дахь заалтын, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн, 51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “тооцооны” гэснийг “клирингийн” гэж, 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийн, 48 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 48.1 дэх хэсгийн, 49 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын “Хөрөнгийн биржийн” гэснийг “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын” гэж, 54 дүгээр зүйлийн гарчгийн “Аудитийн” гэснийг “Аудитын” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.11 дэх заалтын “батлах зөвшөөрөл олгох” гэснийг “батламжлах, түүнтэй холбоотой нарийвчилсан журмыг тогтоох” гэж, 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийн, 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн “бүртгүүлснээр” гэснийг “батламжлуулснаар” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “гэрээний зүйл болох” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “энэ хуулийн 9.2-т зааснаас бусад” гэснийг, мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтын “Компанийн” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2.3 дахь заалтын, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтын “болон эргэлтийн” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “гурван жилийн хугацаагаар” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.4.6 дахь заалтын “өөрийн харилцагчид” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28, 4.1.32, 4.1.33 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5.16 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 20.. оны .. сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:**

“6.5.Энэ хуулийн 4.1.3-д заасан хөрөнгө оруулалтын сан нь зөвхөн хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх бөгөөд тухайлсан сангийн төрөлгүй байна.”

**2/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3.Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацааг Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 10.1-д заасан хугацаагаар нэг удаа сунгаж болно.”

**3/14 дүгээр зүйлийн 14.16, 14.17 дахь хэсэг:**

“14.16.Хороо энэ хуулийн 14.4-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэж ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

14.17.Энэ хуулийн 14.16-д заасны дагуу Хороо хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд нь санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

**4/14<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“14<sup>1</sup> дүгээр зүйл.Хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах**

14<sup>1</sup>.1.Хувийн хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд гэрээний үндсэн дээр байгуулж болно.

14<sup>1</sup>.2.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхгүй байна.

14<sup>1</sup>.3.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна:

14<sup>1</sup>.3.1.нэгж эрх эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага;

14<sup>1</sup>.3.2.нэгж эрх гаргах, худалдах, худалдан авах, арилжих зохицуулалт;

14<sup>1</sup>.3.3.нэгж эрхийн үнэ тогтоох, цэвэр хөрөнгийн үнэлгээний тооцоолол;

14<sup>1</sup>.3.4.кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлага;

14<sup>1</sup>.3.5.сангийн үйл ажиллагааг сурталчлахад тавих хязгаарлалт;

14<sup>1</sup>.3.6.бусад.

14<sup>1</sup>.4.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч нь санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр сангийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

14<sup>1</sup>.5.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, үйл ажиллагаа, гэрээнд тавигдах шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.”

**5/19 дүгээр зүйлийн 19.14 дэх хэсэг:**

“19.14.Хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор сангийн нэгж эрхийн танилцуулгыг холбогдох баримт бичгийн хамт Хороонд бүртгүүлэхээр ирүүлэх бөгөөд хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш Хороо ажлын 20 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэж ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.”

**6/21 дүгээр зүйлийн 21.2.10 дахь заалт:**

“21.2.10.сангийн нэгж эрхийг зээлээр олгох.”

**7/26 дугаар зүйлийн 26.1.13, 26.1.14 дэх заалт:**

“26.1.13.хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;

26.1.14.хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан бусад санхүүгийн хэрэгсэл.”

**8/30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалт:**

“30.1.7.хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсны улмаас тухайн сан цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.”

**9/39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалт:**

“39.4.5.сангийн цэвэр активын үнэлгээг кастодиан гүйцэтгэсэн тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани давхар хяналт тавих.”

## **10/39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэг:**

“39.8.Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх зааврыг Хороо нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.”

## **11/44<sup>1</sup> дүгээр зүйл:**

### **“44<sup>1</sup> дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага**

44<sup>1</sup>.1.Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.1.1.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

44<sup>1</sup>.1.2.энэ хуульд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

44<sup>1</sup>.1.3.энэ хуулийн 44.5-д заасан хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбоотой журамд заасан шаардлагыг хангасан байх;

44<sup>1</sup>.1.4.сангийн хөрөнгөөр арилжаа хийх, брокерт захиалга өгөх, брокерын баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх Хорооноос тогтоосон тусгай нөхцөл шаардлагыг хангасан программ хангамжтай байх.

44<sup>1</sup>.2.Энэ хуулийн 44<sup>1</sup>.1.1-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

44<sup>1</sup>.3.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.3.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани гурваас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

44<sup>1</sup>.3.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.3.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

44<sup>1</sup>.3.2.2.банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн байх;

44<sup>1</sup>.3.2.3.тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитын компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх;

44<sup>1</sup>.3.2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.”

**12/46 дугаар зүйлийн 46.1.10-46.1.12 дахь заалт:**

“46.1.10.сангийн удирдлага нь хувийн ашиг сонирхлын үүднээс сангийн хөрөнгийг зарцуулах, удирдлагын зардлыг үндэслэлгүй хэтрүүлэх;

46.1.11.сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийг төвлөрүүлэх;

46.1.12.сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, сангийн гишүүдийн хурлын зардал, хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ болон гүйцэтгэлийн урамшууллаас бусад төлбөр, хураамжийг сангийн хөрөнгөөс гаргах.”

**13/55 дугаар зүйлийн 55.1.11-55.1.13 дахь заалт:**

“55.1.11.биржээр арилжаалагддаг сангийн төрөлтэй хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг батлах;

55.1.12.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мэдээлэх журмыг батлах;

55.1.13.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг батлах.”

**2 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “компани” гэсний дараа “, эсхүл Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “бүртгэлийн” гэсний дараа “болон хөрөнгө оруулалтын сангийн төрөл, түүний үйл ажиллагааны онцлогтой холбоотой нарийвчилсан” гэж, мөн зүйлийн 14.7.2 дахь заалтын “хөрөнгийн” гэсний дараа “доод” гэж, мөн зүйлийн 14.13 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “хуулийн этгээдийн хэлбэртэй” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “эрхлэх” гэсний дараа “, сангийн хөрөнгийг зарцуулах” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “эрхийн” гэсний дараа “өмчлөх эрхийг” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтын “нээлттэй” гэсний өмнө “Монгол Улсын болон гадаад улсын” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Тухайн” гэсний дараа “хамтын”, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “шалгуурыг” гэсний дараа “хамтын” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалт:**

“4.1.1.“хөрөнгө оруулалтын сан” гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлэх санг;



4.1.2.“хамтын хөрөнгө оруулалтын сан” гэж нэгж эрхээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгон хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын санг;”

**2/4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт:**

“4.1.11.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;”

**3/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:**

“6.2.Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дараах төрөлтэй байна:

6.2.1.нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг нээлттэй;

6.2.2.үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй хаалттай;

6.2.3.үүсгэн байгуулагчаас сангийн нэгж эрхээ зохицуулалттай этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслээр солих замаар сангийн активаа бүрдүүлдэг, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр нэгж эрх нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг /цаашид “биржээр арилжаалагддаг сан” гэх/;”

**4/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:**

“7.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.”

**5/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд үүсгэн байгуулна.”

**6/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:**

“16.1.Хөрөнгө оруулалтын сан нь сангийн төрөл, хэлбэрээс үл хамааран дараах зүйлийг тусгасан дүрэмтэй байна:

16.1.1.сангийн нэр, төрөл, хэлбэр болон түүнийг тодорхойлсон, товчилсон ялгах тэмдэглэгээ;

16.1.2.сангийн зарласан болон гаргасан нэгж эрхийн тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

16.1.3.хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээрийн бүрэн эрх;

16.1.4.сангийн гишүүдийн хурал болон нэгж эрх эзэмшигчийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт;

16.1.5.сангийн хөрөнгө оруулалтын бодлого, үйл ажиллагааны чиглэл;

16.1.6.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн нэр, регистрийн дугаар;

16.1.7.кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар;

16.1.8.хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа;

16.1.9.хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээ;

16.1.10.хувийн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгө оруулалтыг санхүүгийн хэрэгслээр оруулж болох эсэх, оруулах бол тухайн хэрэгслийг үнэлэх зарчим, аргачлалын тухай;

16.1.11.хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа дуусгавар болж хөрөнгийг хөрөнгө оруулагчдад бүрэн хуваарилж дууссан тохиолдолд татан буугдах тухай болон татан буулгах ажиллагааны журам;

16.1.12.бусад."

**7/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:**

"19.3.Хамтын хөрөнгө оруулалтын сангийн тухайд сангийн нэгж эрхийн танилцуулга, түүнийг хөрөнгө оруулагчид танилцуулах, сангийн нэгж эрхийг худалдах ажиллагааны журмыг Хороо батална."

**8/19 дүгээр зүйлийн 19.13.3 дахь заалт:**

"19.13.3.нээлттэй төрлийн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийт гаргасан нэгж эрхийн гуравны хоёр буюу түүнээс дээш хэмжээний нэгж эрхийг тухайн санд буцаан худалдсан;"

**9/21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалт:**

"21.2.3.сангийн хөрөнгө оруулагчид ашиг олох болон нэгж эрхээ тодорхой үнэ ханшаар эргүүлэн авах амлалт, баталгаа гаргах, мөнгөн хөрөнгөөр зээл олгох, хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээс хамаарч хууль болон Хорооноос тогтоосон хязгаараас хэтрүүлэн бусдаас зээл авах;"

**10/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:**

“22.1.Хөрөнгө оруулалтын сангийн гишүүний бүртгэлийг тухайн санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани хөтлөх үүрэгтэй ба энэхүү үүргээ кастодианаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.”

**11/22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг:**

“22.4.Нэгж эрхийн номиналь эзэмшигч нь гишүүний бүртгэлд бенефициар өмчлөгчийн нэрийг давхар тусгана.”

**12/24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг:**

“24.1.Хамтын хөрөнгө оруулалтын сан энэ хуулийн 26.1.1-26.1.3, 26.1.5-26.1.8-д заасан болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.”

**13/44 дүгээр зүйлийн 44.7.1 дэх заалт:**

“44.7.1.үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ;”

**14/45 дугаар зүйлийн 45.3.2 дахь заалт:**

“45.3.2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.10, 24.1.15-24.1.17-д заасан үйл ажиллагаа эрхлэгч болон түүний холбогдох этгээд нь хүсэлт гаргагч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болох нь тогтоогдсон;”

**15/48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг:**

“48.1.Кастодиан нь хууль болон хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр тооцоо гүйцэтгэх, хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг эрхэлнэ.”

**4 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “хөрөнгөөр” гэснийг “хөрөнгө болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслээр” гэж, 14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтэд” гэснийг “хөрөнгө оруулагчид” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж” гэснийг “хөрөнгө оруулалт хийж” гэж, мөн зүйлийн 19.11.7 дахь заалтын “Хорооноос тогтоосон” гэснийг “Энэ хуулийн 19.3-т заасан Хорооноос баталсан журамд заасан” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “хөрөнгө оруулах гэрээний үндсэн дээр” гэснийг “хаалттай хүрээнд” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “сан” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол сангийн гишүүдийн хурал/” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “зохицуулалттай” гэснийг “Монгол Улсын болон гадаад улсын үнэт цаасны” гэж, мөн зүйлийн 26.1.6 дахь заалтын “зохицуулалттай” гэснийг “үнэт цаасны” гэж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хөрөнгө” гэснийг “Хамтын хөрөнгө” гэж, 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “татгалзаж болно” гэснийг “татгалзана” гэж, мөн зүйлийн 45.3.1 дэх заалтын “хөрөнгө оруулалтын

менежментийн компанийн” гэснийг “хүсэлт гаргагч хуулийн этгээдийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх хэсгийн “Компанийн тухай хуульд нийцүүлэн баталсан” гэснийг, 19 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 19.1 дэх хэсгийн “нийтээс” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.6 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.3.3 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 20.. оны .. сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.17 дахь хэсэг нэмсүгэй.

“46.17.Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг уг журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “гаргасан” гэсний дараа “барьцаа,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Компанийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсэг:**

“3.9.Хөрөнгө оруулалтын сан нь тусгай зориулалтын компани хэлбэртэй байна. Уг хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохицуулалт хамаарахгүй.”

**2/46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэг:**

“46.14.Хувьцаат компанийн хувьд ногдол ашиг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.”

**3/86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэг:**

“86.1.Компанийн хувьцаа эзэмшигч нь дангаараа эсхүл бусад хувьцаа эзэмшигчидтэй хамтран компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.”

**4 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

**1/18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг:**

“18.13.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг энэ хуулийн 18.3-т заасны дагуу тодорхойлно.

18.14.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг тодорхойлох, тайлагнах, суутган тооцох, төсөвт төлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална.”

**2/24 дүгээр зүйлийн 24.1<sup>1</sup> дэх хэсэг:**

“24.1<sup>1</sup>.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд ногдуулж, суутгана.”

**2 дугаар зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын “18.6.8-д” гэснийг “18.6.8, 18.6.13-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг ... оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

#### **1/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:**

“20.4.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу тодорхойлно.

20.5.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, тайлагнах, суутган тооцох, төсөвт төлөхөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.14-т заасан журмыг баримтална.”

#### **2/25 дугаар зүйлийн 25.1<sup>1</sup> дэх заалт:**

“25.1<sup>1</sup>. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд ногдуулж, суутгана.”

**2 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.5 болон 25.1.6 дахь заалтын “20.1-д” гэснийг “20.1, 20.4-д” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг ... оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"22.5. Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг энэ хуулийн 3.1-т заасан үйл ажиллагаа тус бүрийн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиар зохицуулна."

**2 дугаар зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын "мэргэжлийн" гэснийг "зохицуулалттай" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

**1/11.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 12.21 дэх заалт:**

“12.21. Компани, олон улсын санхүүгийн байгууллага нь хуульд зааснаас бусад зах зээлд, буюу бусад арга, хэрэгслийг ашиглаж өрийн хэрэгсэл гаргасан;”

**2/11.26 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Хөрөнгө оруулалтын менежментийн компани хуульд заасан нийтлэг үүргээ хэрэгжүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 12.2, 12.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд нэмж гаргахдаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлээгүй;

12.3.урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлээгүй;”

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.9 дэх заалтын, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.18, 12.19 дэх заалтын, мөн зүйлийн 13 дахь хэсгийн 13.10 дахь заалтын “хөрөнгийн бирж” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн 7.1 дэх заалтын, мөн зүйлийн 15 дахь хэсгийн 15.2 дахь заалтын “хөрөнгийн бирж,” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага,” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн “Хөрөнгийн бирж” гэснийг “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.7 дахь заалтын, мөн зүйлийн 13 дахь хэсгийн 13.1, 13.2 дахь заалтын “хөрөнгийн биржид” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.20 дахь заалтын “хөрөнгийн биржийн” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын” гэж, 12 дахь хэсгийн “12.21” гэснийг “12.22” гэж, мөн зүйлийн 14 дэх

хэсгийн "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжид" гэснийг "хуульд" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.5, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.5 дахь заалт нэмсүгэй.

"1.5. Үнэт цаасны арилжааг түр зогсоох, үнэт цаас тусгаарлах."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсгийн "арга хэмжээг авахдаа" гэсний дараа "үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаа, төлбөрийн үүргийг тасалдуулах," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.3.6 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“15.5.3.6.үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд болон мэргэжлийн холбоо;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын "мэргэжлийн байгууллага" гэснийг "зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийн "мэргэжлийн байгууллагын" гэснийг "зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн" гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн "мэргэжлийн байгууллагаас" гэснийг "зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нотариатын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“46.1.8.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагдах замаар өмчлөх эрх шилжихээс бусад тохиолдолд хувьцаа, үнэт цаасыг бусдын өмчлөлд шилжүүлэх гэрээ;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг “зохицуулалттай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС  
ХӨНГӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл болон Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ борлуулсны орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг 2023-2026 онд 90 хувиар, 2027-2030 онд 50 хувиар тус тус хөнгөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөнгөлөлтөд ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлого хамаарахгүй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2031 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС  
ХӨНГӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл болон Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ борлуулсны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2023-2026 онд 90 хувиар, 2027-2030 онд 50 хувиар тус тус хөнгөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөнгөлөлтөд ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлого хамаарахгүй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2031 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

---

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

### **1/4 дүгээр зүйлийн 4.1.34-4.1.39 дэх заалт:**

“4.1.34.“форвард гэрээ” гэж талуудад тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг урьдчилан тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах үүргийг үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн хууль нь зөвхөн биржийн зах зээлийн зохицуулалтыг агуулсан бөгөөд биржийн бус зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх зохицуулалт огт тусаагүй байсан.

Зах зээл хөгжихийн хэрээр хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж зах зээлээр арилжаалах үүднээс ҮЦЗЗТХ-ийн 4.1.7 “үүсмэл санхүүгийн хэрэгсэл” гэсэн тодорхойлолтод биржийн бус зах зээл дээр түлхүү арилжаалагддаг форвард, своп бүтээгдэхүүнийг нэмсэнтэй холбогдуулан нэр томъёоны тодорхойлолтыг нэмж оруулсан.

4.1.35.“своп гэрээ” гэж талуудад хоёр өөр санхүүгийн хэрэгслээс үүсэх ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн үүргийг тогтоосон хугацаанд солилцох үүргийг үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн хууль нь зөвхөн биржийн зах зээлийн зохицуулалтыг агуулсан бөгөөд биржийн бус зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх зохицуулалт огт тусаагүй байсан.

Зах зээл хөгжихийн хэрээр хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж зах зээлээр арилжаалах үүднээс ҮЦЗЗТХ-ийн 4.1.7 “үүсмэл санхүүгийн хэрэгсэл” гэсэн тодорхойлолтод биржийн бус зах зээл дээр түлхүү арилжаалагддаг форвард, своп бүтээгдэхүүнийг нэмсэнтэй холбогдуулан нэр томъёоны тодорхойлолтыг нэмж оруулсан.

4.1.36.“хаалттай хүрээнд худалдах” гэж үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр 50-аас дээшгүй тооны этгээдэд урьдчилан тохиролцон, эсхүл шууд санал болгон худалдахыг;

**Тайлбар:** Олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасыг хаалттай хүрээнд эрсдэлээ өөрсдөө тооцоолох, тухайн эрсдэлээ өөрөө даах чадвар бүхий хөрөнгө оруулагч нарын хүрээнд санал болгох практик түгээмэл байдаг. Энэхүү туршлага Монгол улсад мөн сүүлийн жилүүдэд өргөн хэрэглэгдэх болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор нийтэд санал болгох болон хаалттай хүрээнд санал болгох үйл ажиллагааг ялгаатайгаар тодорхойлж байгаа болно.

4.1.37.“хувьцааны хамтын санхүүжилт” гэж гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч энэ хуулийн 50<sup>1</sup>.1-д заасан этгээдээр дамжуулан өөрсдийн бизнесийн төсөл, хөтөлбөрөө хөрөнгө оруулагчид танилцуулж, хувьцаагаа санал болгох замаар санхүүжилт татах үйл ажиллагааг;

**Тайлбар:** Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьцаа, зээлийн хамтын санхүүжилтын шинэ хэлбэрүүд үүсч бий болсон байна. Үнэт цаасны олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн тайланд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хамтын санхүүжилт нь техник технологийн дэвшил болон 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкуудын бизнесийн зээлийн хэмжээ буурсантай холбогдуулан сүүлийн үед ихээхэн эрчимтэй хөгжиж буй салбар

Энэхүү салбар нь 2025 гэхэд хөгжиж буй орнуудын хувьд \$90-96 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлнэ хэмээн Дэлхийн банк судалгаа гаргасан. Хамтын санхүүжилт нь ихээхэн эрсдэл дагуулдаг боловч энэ нь хөгжсөн улс орнуудын хувьд жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангах нэг арга хэрэгсэлд тооцогддог тул энэхүү үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчинг бий болгохоор зорьж байгаа нь ажиглагдаж байна. Манай улсын хувьд энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх нь жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгох томоохон давуу талтай боловч иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын талаар мэдлэг хомс, мэдээллийн ил тод байдлыг хангах байдал дутагдалтай зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ үйл ажиллагааг буруугаар ашиглах, залилах зэрэг эрсдэл бий болж болзошгүй тул хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөхгүйгээр энэхүү салбарыг дэмжих зохицуулалтын орчинг бий болгох шаардлагатай байна.

4.1.38. "номиналь данс" гэж харилцагчийн мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг нэгтгэн бүртгэх, төлбөр гүйцэтгэх болон хадгалах зориулалт бүхий дансыг;

**Тайлбар:** Үнэт цаасны клирингийн гишүүн байгууллагууд үүсэнтэй холбогдуулан клирингийн гишүүн Үнэт цаасны компаниуд өөрсдийн харилцагчдын төлбөр тооцооны эрсдэлийг хүлээх, төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээх болсон. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаасны компаниуд Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв болон Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв дээр өөрсдийн номиналь данс үүсгэн харилцагчдаа бүртгэх болсон тул уг нэр томъёоны тодорхойлолтыг оруулах болсон.

4.1.39. "олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл" гэж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олон улсын санхүүгийн байгууллагаас Монгол Улсын үнэт цаасны зах зээлд гаргах өрийн хэрэгслийг."

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн байгууллагууд нь сүүлийн жилүүдэд хөгжиж буй зах зээлийн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтын тухайн улсад оруулах, тухайн өрийн хэрэгслээр дамжуулан босгосон санхүүгийн эх үүсвэрийг тухайн орны дотоодын хувийн хэвшлийн томоохон төсөл хөтөлбөр, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай урт хугацааны

санхүүжилтийг олгоход зарцуулж, үүгээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, валютын урсгалыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан, тэдгээрийн portfolio investment буюу багцын хөрөнгө оруулалтад Монгол Улсын Засгийн газрын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл нэмэгдэх боломжийг олгох нь чухал юм. Энэхүү олон санхүүгийн байгууллагууд нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Фитч болон Эс энд Пи байгууллагуудаас “AAA” зэрэглэлтэй буюу эрсдэлгүй хөрөнгө оруулалтын үнэлгээтэй байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагууд (Ж: АХБ, ОУСК...) Монголын хөрөнгийн зах зээл дээр төгрөгийн бонд гаргах, гаргасан тохиолдолд босгосон санхүүгийн эх үүсвэрийг Монголын аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийг урт хугацаатай, бага зардлаар санхүүжүүлэх зорилготой байгаа юм.

Гэсэн хэдий ч одоогоор Монгол Улсын хууль эрх зүйн орчин, ялангуяа санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийн холбогдох хуулиудад энэ талаарх зохицуулалт байхгүй байгаа тул эдгээр байгууллагууд өрийн хэрэгсэл гаргах боломжгүй хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.

Иймд олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг ҮЦЗЗХТ-ийн 5.1 дэх хэсэгт “5.1.12.олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл” гэсэн заалтыг нэмж тусгасантай холбогдуулан нэр томъёоны тодорхойлолтыг оруулах болсон.

#### **2/5 дугаар зүйлийн 5.1.11, 5.1.12 дахь заалт:**

“5.1.11.энэ хуульд заасан үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат;

**Тайлбар:** Хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөрөнгийн зах зээл дээр арилжаалах үүднээс банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг нэмж оруулсан.

Хадгаламжийн сертификат гэдэг нь хөрөнгийн эх үүсвэр татах зорилгоор арилжааны банк, хадгаламж зээлийн байгууллага (thrift insitution), зээлийн холбоо зэрэг санхүүгийн байгууллагаас санал болгож буй нэрлэсэн үнэтэй, тодорхой хугацаа өнгөрсний дараа эргэн татагдах, тогтмол хүүтэй үнэт цаас юм. Бусад улс орнуудын туршлагаас харахад хадгаламжийн сертификат нь (i) уламжлалт, (ii) буцаан дуудах боломжтой, (iii) түргэн хөрвөх, (iv) өсөн нэмэгдүүлэх, (v) купонгүй, (vi) брокерын зэрэг төрлүүдтэй байдаг байна. Манай арилжааны банкууд уламжлалт хадгаламжийн сертификатыг гаргадаг бөгөөд бусад төрлийн сертификатыг хараахан нэвтрүүлээгүй байна.

Монголын банкууд зөвхөн уламжлалт хадгаламжийн сертификат нэвтрүүлсэн байна. Энэ нь хугацаатай хадгаламжаас илүү өндөр хүүтэй байхаас гадна бусад хугацаатай хадгаламжаас ялгагдах гол онцлог нь өвлүүлэх,

гэрээслэх, бэлэглэх, худалдах зэргээр хязгаарлагдмал хүрээнд шилжүүлэх боломжтой.

Монгол Улсын хувьд хадгаламжийн сертификатыг анх 2002 онд Голомт банк нэвтрүүлсэн байдаг. Өнөөдрийн байдлаар хадгаламжийн сертификатыг Голомт, Худалдаа Хөгжлийн банк, ХААН банкууд гаргаж байна. Банкуудаас санал болгож буй хадгаламжийн сертификат нь хөрвөх чадвар сул байгаа тул хөрөнгө оруулагчид ижил хэмжээний хүү амлаж буй "тусгай нөхцөл" бүхий харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг сонгож байна.

Монгол Улсад хадгаламжийн сертификатыг арилжаалах хоёрдогч зах зээл хөгжөөгүй бөгөөд хадгаламжийн сертификатын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалтгүй байна. Ихэнх улс оронд үндэсний санхүүгийн хяналтын байгууллага нь хадгаламжийн сертификатын арилжааг хянаж зохицуулах бүрэн эрхтэй байдаг байна. Зохицуулалтын журмын хувьд зарим улс оронд хадгаламжийн сертификатын талаарх тусгайлсан хууль тогтоомж байдаг бол заримд нь үнэт цаасны гэрээ хэлэлцээрийн ерөнхий зарчмаар арилжаалагддаг байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад банкнаас гаргасан хадгаламжийн сертификатыг хамруулах байдлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, ҮЦТХТ дээр бүртгэлтэй, брокероор дамжин Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг хадгаламжийн сертификатыг бий болгох боломжтой.

Ийнхүү хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болсноор банкны салбараас эх үүсвэр гэнэт татагдах эрсдэл буурах, банкуудын тусгай нөхцөлтэй харилцах, хадгаламжийн хүү буурах, банкны эх үүсвэрийн зардал буурах, улмаар зээлийн хүү буурахад эергээр нөлөөлөх юм.

#### 5.1.12. олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл."

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн байгууллагууд нь сүүлийн жилүүдэд хөгжиж буй зах зээлийн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтын тухайн улсад оруулах, тухайн өрийн хэрэгслээр дамжуулан босгосон санхүүгийн эх үүсвэрийг тухайн орны дотоодын хувийн хэвшлийн томоохон төсөл хөтөлбөр, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай урт хугацааны санхүүжилтийг олгоход зарцуулж, үүгээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, валютын урсгалыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан, тэдгээрийн portfolio investment буюу багцын хөрөнгө оруулалтад Монгол Улсын Засгийн газрын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл нэмэгдэх боломжийг олгох нь чухал юм. Энэхүү олон санхүүгийн байгууллагууд нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Фитч болон Эс энд Пи байгууллагуудаас "AAA" зэрэглэлтэй буюу эрсдэлгүй хөрөнгө оруулалтын үнэлгээтэй байдаг.



Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагууд (Ж: АХБ, ОУСК...) Монголын хөрөнгийн зах зээл дээр төгрөгийн бонд гаргах, гаргасан тохиолдолд босгосон санхүүгийн эх үүсвэрийг Монголын аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийг урт хугацаатай, бага зардлаар санхүүжүүлэх зорилготой байгаа юм.

Гэсэн хэдий ч одоогоор Монгол Улсын хууль эрх зүйн орчин, ялангуяа санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийн холбогдох хуулиудад энэ талаарх зохицуулалт байхгүй байгаа тул эдгээр байгууллагууд өрийн хэрэгсэл гаргах боломжгүй хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.

Иймд олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон нэмж тусгасан.

### **3/10 дугаар зүйлийн 10.15.7-10.15.9 дэх заалт:**

"10.15.7.гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад нийтэд санал болгон үнэт цаасаа гаргах;

**Тайлбар:** Давхар бүртгэл гэдэг нь тухайн компанийн хувьцааг анх бүртгэл хийлгэсэн хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалахаас гадна (i) нэмэлт хөрөнгө босгох, (ii) хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх болон (iii) олон улсад компанийн үйл ажиллагааг таниулах зорилгоор гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх үйл ажиллагаа юм.

Давхар бүртгэлийг шууд бүртгэл хийлгэх (direct listing) эсвэл хадгаламжийн бичиг гаргах замаар хийх боломжтой байдаг. Давхар бүртгэл хийлгэхийн тулд компани нь тухайн хоёр биржийн бүртгэлийн шалгуурыг зэрэг хангасан байх шаардлагатай.

Хоёрдогч бүртгэл хийж буй биржийн шалгуур үзүүлэлт анхдагч биржийн шалгуур үзүүлэлтээс өөр байж болох ч, хоёрдогч бүртгэл хийж буй биржийн зүгээс бүртгэлийн шалгуураа уян хатан байдлаар тогтоож, шийдвэр гаргах нь элбэг байдаг. Учир нь компани хоёрдогч бүртгэл хийлгэхээсээ өмнө аль нэг биржийн бүртгэлийн шалгуурыг хангаж, хувьцаагаа зах зээл дээр арилжаалж байгаа нь хоёрдогч бүртгэлийн үйл явцыг илүү хялбаршуулдаг байна.

Гэхдээ анхдагч бүртгэлийг ямар орны хөрөнгийн бирж дээр хийлгэснээс шалтгаалан хоёрдогч бүртгэл хийж буй бирж ялгаатай зохицуулалт хийдэг. Хоёр бирж хоорондоо энэ чиглэлээр хамтран ажиллах гэрээ болон санамж бичиг байгуулсан бол давхар бүртгэлийн үйл явц илүү хялбар болно.

Иймд Гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа нийтэд санал болгон гаргахдаа үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхийг шаардахгүй болгон зохицуулалтыг уян хатан, үнэт цаас гаргагчийн зардал, шат дамжлагыг бууруулж байгаа зохицуулалтыг хийсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн өсөлтийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүд банкны зээлийн санхүүжилтээс гадна хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар урт хугацааны

санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлэхийг дэмжиж, олон улсын санхүүгийн зах зээлийн интеграцид нэгдэх чиглэлээр томоохон бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь 2020 онд үнэт цаасны давхар бүртгэлийн журмаар гадаадын болон дотоодын хөрөнгийн бирж хооронд үнэт цаасаа чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах зохицуулалтын орчинг бүрдүүлсэн явдал юм. Гадаад улсын хөгжингүй зах зээлд бүртгэлтэй үнэт цаасыг дотоодын биржээр дамжуулан арилжаалж, зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийн үнэлгээг өсгөж, хөрвөх чадварыг дээшлүүлэхэд чухал нөлөө болно.

10.15.8. үнэт цаасны зах зээлд банкнаас хадгаламжийн сертификат гаргах;

**Тайлбар:** УИХ-аас хэрэгжүүлсэн банкны салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын системийн 5 банк нь олон нийтийн компани болсон. Түүнчлэн Банк нь дэлхий дээрх хамгийн хатуу хяналт шалгалтад байдаг санхүүгийн байгууллага бөгөөд арилжааны банкууд нь Монголбанкны хяналт шалгалт, зохицуулалтад хамаардаг, мөн үнэт цаасны зах зээлд хадгаламжийн сертификат гаргахаар шийдвэрлэсэн бол холбогдох зөвшөөрлийг Монголбанкнаас авах, тогтмол хяналт зохицуулалтад байх шаардлагатай тул үнэт цаасны зах зээлд гаргах арилжаалах хадгаламжийн сертификатын танилцуулгыг бэлтгэхийг шаардахгүй.

10.15.9. олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл гаргах.”

**Тайлбар:** Олон санхүүгийн байгууллагууд нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Фитч болон Эс энд Пи байгууллагуудаас “AAA” зэрэглэлтэй буюу эрсдэлгүй хөрөнгө оруулалтын үнэлгээтэй байдаг бөгөөд олон улсын Засгийн газруудын нэгдэн орсон байгууллага тул тэдгээрийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдал, тайлан, зорилго зорилт нь олон улсад тогтмол мэдээлдэг нээлттэй байгууллагууд билээ.

Иймд олон улсын санхүүгийн байгууллага нь Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр өрийн хэрэгсэл гаргахдаа үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх шаардлагагүй.

4/16<sup>1</sup> дүгээр зүйл:

“16<sup>1</sup> дүгээр зүйл. Олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл

16<sup>1</sup>.1. Олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр энэ хуульд нийцүүлэн гаргаж болно.

16<sup>1</sup>.2. Энэ хуулийн 16<sup>1</sup>.1-д заасны дагуу гаргах өрийн хэрэгслийг бүртгэх, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журмыг Хороо батална.”

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн байгууллагууд нь сүүлийн жилүүдэд хөгжиж буй зах зээлийн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтын тухайн улсад оруулах, тухайн өрийн хэрэгслээр дамжуулан босгосон санхүүгийн эх үүсвэрийг тухайн орны дотоодын хувийн хэвшлийн томоохон төсөл хөтөлбөр, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай урт хугацааны санхүүжилтийг олгоход зарцуулж, үүгээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, валютын урсгалыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан, тэдгээрийн portfolio investment буюу багцын хөрөнгө оруулалтад Монгол Улсын Засгийн газрын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл нэмэгдэх боломжийг олгох нь чухал юм. Энэхүү олон санхүүгийн байгууллагууд нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Фитч болон Эс энд Пи байгууллагуудаас “AAA” зэрэглэлтэй буюу эрсдэлгүй хөрөнгө оруулалтын үнэлгээтэй байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагууд (Ж: АХБ, ОУСК...) Монголын хөрөнгийн зах зээл дээр төгрөгийн бонд гаргах, гаргасан тохиолдолд босгосон санхүүгийн эх үүсвэрийг Монголын аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийг урт хугацаатай, бага зардлаар санхүүжүүлэх зорилготой байгаа юм.

Гэсэн хэдий ч одоогоор Монгол Улсын хууль эрх зүйн орчин, ялангуяа санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийн холбогдох хуулиудад энэ талаарх зохицуулалт байхгүй байгаа тул эдгээр байгууллагууд өрийн хэрэгсэл гаргах боломжгүй хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.

Иймд олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгслийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон нэмж тусган хуулийн төсөлд шинэ зүйл нэмж зохицуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдах санхүүгийн үйлчилгээ, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийг зохицуулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь “Олон улсын байгууллагын гаргах өрийн хэрэгслийг бүртгэх, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

#### **5/19<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“19<sup>1</sup> дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих**

19<sup>1</sup>.1. Банк нь хадгаламжийн сертификатыг үнэт цаас хэлбэрээр үнэт цаасны зах зээлд арилжихаар нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд худалдаж болно.

19<sup>1</sup>.2.Энэ хуулийн 19<sup>1</sup>.1-д заасан үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификат нь мөнгөн хадгаламжийн гэрээгээр зохицуулагдахгүй.

19<sup>1</sup>.3.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх болон банканд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журмыг Төв банк /Монголбанк/-ны саналыг харгалзан Хороо батална.

19<sup>1</sup>.4.Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификатын үнийн дүн, нөхцөл, төрөл, төвлөрлийн үзүүлэлтэд тавигдах хязгаарлалтыг тогтоох, тайлагнах, хяналт тавихтай холбоотой журмыг Хорооны саналыг харгалзан Төв банк /Монголбанк/ батална.

19<sup>1</sup>.5.Банк нь хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны зөвшөөрөл авна.”

**Тайлбар:** Хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөрөнгийн зах зээл дээр арилжаалах үүднээс банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг нэмж оруулсан.

Хадгаламжийн сертификат гэдэг нь хөрөнгийн эх үүсвэр татах зорилгоор арилжааны банк, хадгаламж зээлийн байгууллага (thrift insitution), зээлийн холбоо зэрэг санхүүгийн байгууллагаас санал болгож буй нэрлэсэн үнэтэй, тодорхой хугацаа өнгөрсний дараа эргэн татагдах, тогтмол хүүтэй үнэт цаас юм. Бусад улс орнуудын туршлагаас харахад хадгаламжийн сертификат нь (i) уламжлалт, (ii) буцаан дуудах боломжтой, (iii) түргэн хөрвөх, (iv) өсөн нэмэгдүүлэх, (v) купонгүй, (vi) брокерын зэрэг төрлүүдтэй байдаг байна. Манай арилжааны банкууд уламжлалт хадгаламжийн сертификатыг гаргадаг бөгөөд бусад төрлийн сертификатыг хараахан нэвтрүүлээгүй байна.

Монголын банкууд зөвхөн уламжлалт хадгаламжийн сертификат нэвтрүүлсэн байна. Энэ нь хугацаатай хадгаламжаас илүү өндөр хүүтэй байхаас гадна бусад хугацаатай хадгаламжаас ялгагдах гол онцлог нь өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх, худалдах зэргээр хязгаарлагдмал хүрээнд шилжүүлэх боломжтой.

Монгол Улсын хувьд хадгаламжийн сертификатыг анх 2002 онд Голомт банк нэвтрүүлсэн байдаг. Өнөөдрийн байдлаар хадгаламжийн сертификатыг Голомт, Худалдаа Хөгжлийн банк, ХААН банкууд гаргаж байна. Банкуудаас санал болгож буй хадгаламжийн сертификат нь хөрвөх чадвар сул байгаа тул хөрөнгө оруулагчид ижил хэмжээний хүү амлаж буй “тусгай нөхцөл” бүхий харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг сонгож байна.

Монгол Улсад хадгаламжийн сертификатыг арилжаалах хоёрдогч зах зээл хөгжөөгүй бөгөөд хадгаламжийн сертификатын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалтгүй байна. Ихэнх улс оронд үндэсний санхүүгийн хяналтын байгууллага нь хадгаламжийн сертификатын арилжааг хянаж зохицуулах бүрэн эрхтэй байдаг байна. Зохицуулалтын журмын хувьд зарим улс оронд хадгаламжийн сертификатын талаарх тусгайлсан хууль тогтоомж байдаг бол заримд нь үнэт цаасны гэрээ хэлэлцээрийн ерөнхий зарчмаар арилжаалагддаг байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад банкнаас гаргасан

хадгаламжийн сертификатыг хамруулах байдлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, ҮЦТХТ дээр бүртгэлтэй, брокероор дамжин Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг хадгаламжийн сертификатыг бий болгох боломжтой.

Ийнхүү хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болсноор банкны салбараас эх үүсвэр гэнэт татагдах эрсдэл буурах, банкуудын тусгай нөхцөлтэй харилцах, хадгаламжийн хүү буурах, банкны эх үүсвэрийн зардал буурах, улмаар зээлийн хүү буурахад эерэгээр нөлөөлөх юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдах санхүүгийн үйлчилгээ, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийг зохицуулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь "Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх болон банканд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам"-ыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн. Мөн Төв банк /Монголбанкны/ тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк нь банкны үйл ажиллагаанд хяналт тавих шаардлагын хүрээнд Монголбанк нь "Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификатын үйнийн дүн, нөхцөл, төрөл, төвлөрлийн үзүүлэлтэд тавигдах хязгаарлалтыг тогтоох, тайлагнах, хяналт тавихтай холбоотой журам"-ын батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

#### **6/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:**

"20.4.Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргагч болон олон улсын санхүүгийн байгууллагад энэ хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.6, 20.1.8, 20.1.10 дахь заалт хамаарахгүй.

**Тайлбар:** Хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.6, 20.1.8, 20.1.10 заалтууд нь үнэт цаас гаргагч компани байх тохиолдолд тавигдах шаардлагууд тул Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргагч, олон улсын санхүүгийн байгууллагууд нь тухайн заалтуудад хамаарахгүй.

20.5.Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх тогтмол болон тухай бүр ирүүлэх мэдээлэл, түүний ил тод байдлын журмыг Хороо батална."

**Тайлбар:** Хөрөнгийн зах зээлийн хөгжил, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын шийдвэр, тэдний зах зээлд оролцох идэвхи сонирхолд үнэт цаас гаргагчийн ил тод мэдээлэл, засаглалын үр дүнтэй байдал, мэдээллийг цаг хугацаа алдалгүй авах, бусад хөрөнгө оруулагчидтай адил эрх эдлэх зэрэг асуудал нь жижиг хөрөнгө оруулагчдын хамгаалахад чухал үр нөлөөтэй.

Иймд жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах мэдээллийн ил тод байдал, засаглал, хувьцаа эзэмшигчдийн хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор олон улсад corporate action буюу үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг тогтмол тухай бүр мэдээлэх, түүнтэй холбоотой нарийвчилсан журмын Хороо батлах зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх тогтмол болон тухай бүр ирүүлэх мэдээлэл, түүний ил тод байдлын журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

#### **7/24 дүгээр зүйлийн 24.1.19 дэх заалт 24.10-24.13 дахь заалт:**

**"24.1.19.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа."**

**Тайлбар:** Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьцаа, зээлийн хамтын санхүүжилтын шинэ хэлбэрүүд үүсч бий болсон байна. Үнэт цаасны олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн тайланд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хамтын санхүүжилт нь техник технологийн дэвшил болон 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкуудын бизнесийн зээлийн хэмжээ буурсантай холбогдуулан сүүлийн үед ихээхэн эрчимтэй хөгжиж буй салбар

Энэхүү салбар нь 2025 гэхэд хөгжиж буй орнуудын хувьд \$90-96 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлнэ хэмээн Дэлхийн банк судалгаа гаргасан. Хамтын санхүүжилт нь ихээхэн эрсдэл дагуулдаг боловч энэ нь хөгжсөн улс орнуудын хувьд жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангах нэг арга хэрэгсэлд тооцогддог тул энэхүү үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчинг бий болгохоор зорьж байгаа нь ажиглагдаж байна. Манай улсын хувьд энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх нь жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгох томоохон давуу талтай боловч иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын талаар мэдлэг хомс, мэдээллийн ил тод байдлыг хангах байдал дутагдалтай зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ үйл ажиллагааг буруугаар ашиглах, залилах зэрэг эрсдэл бий болж болзошгүй тул хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөхгүйгээр энэхүү салбарыг дэмжих зохицуулалтын орчинг бий болгох шаардлагатай байна.

*IOSCO-с 2015 онд хамтын санхүүжилттай холбоотойгоор гаргасан мэдэгдлийн дагуу хэдийгээр зохицуулалтын орчин нь эхлэлийн үе шатандаа явж байгаа боловч хөрөнгө оруулагчдыг хамгаалах үүднээс зохицуулах байгууллага, бодлого боловсруулагчид дараах эрсдэлээс хамгаалах арга хэмжээг анхааралдаа авах нь зүйтэй байна. Үүнд:*

- 1. Онлайн платформыг бүртгэх, түүнд тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг бий болгох;*
- 2. Үнэт цаас гаргагч, зээл олгогчид, онлайн платформд мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагыг тавих;*
- 3. Онлайн платформын үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоож өгөх;*
- 4. Хөрөнгө оруулагчдыг мэдлэгжүүлэх, хамтын санхүүжилттай холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдлийг хөрөнгө оруулагчдаас шаардах;*
- 5. Нэг хөрөнгө оруулагчийн тодорхой хугацаанд оруулж болох хөрөнгийн хязгаарыг тогтоож өгөх;*
- 6. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гуравдагч кастодианиар хадгалуулахыг шаардах.*

*Иймд хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаанд хамааруулж, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад оруулахаар зохицуулсан.*

#### **8/24 дүгээр зүйлийн 24.10-24.13 дахь хэсэг:**

*"24.10.Нийтэд санал болгосноос бусад тохиолдолд зохицуулалттай этгээдийн хувьцааг худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхэд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:*

*24.10.1.хэлцэл хийж буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны байх;*

*24.10.2.худалдан авагч, барьцаалагч нь энэ хуулийн 27.2.5-д заасан шаардлагыг хангасан байх;*

*24.10.3.хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулсан байх;*

*24.10.4.хувьцааг тэргүүн ээлжид худалдан авахтай холбоотой Компанийн тухай хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлсэн байх.*

**Тайлбар:** *Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно" гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл*

*авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

24.11.Салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн зохицуулалттай этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

24.11.1.сүүлийн хоёр улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байх;

24.11.2.салбар, төлөөлөгчийн газар нь байнгын үйл ажиллагаа явуулах ажлын байртай, тухайн салбар, төлөөлөгчийн газарт тогтмол ажиллах ажилтантай байх;

24.11.3.салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

24.11.4.салбар, төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журмыг баталсан байх.

**Тайлбар:** *Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

24.12.Энэ хуулийн 24.1.1-24.1.14-т заасан зохицуулалттай этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бичиг баримтыг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

**Тайлбар:** *Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

24.13.Энэ хуулийн 24.12-т заасан шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг, тайлбар гаргуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр сунгаж болно.”

**Тайлбар:** *Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм*



хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

#### **9/25 дугаар зүйлийн 25.1.12 дахь заалт:**

“25.1.12.үйл ажиллагаатай холбогдох цахим сүлжээ, системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангах.”

*Тайлбар:* Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулагч зохицуулалттай этгээд нь цаг, хором бүр хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгөтэй холбоотой хэлцэл, арилжаа, хөрөнгийн хадгалалт, шилжүүлэг, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг тул тэдгээрийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болох програм хангамж, систем, серверт тавигдах зарчмыг хуульд нэмж тусгасан.

#### **10/27 дугаар зүйлийн 27.2.8- 27.2.12 дахь заалт:**

“27.2.8.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан талаарх нотлох баримт;

27.2.9.хувьцаа эзэмшигч (хувьцаат компанийн хувьд нийт хувьцааны таваас дээш хувийг эзэмшигч), төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан болон мэргэжилтэн нь дараах шалгуурыг хангасан байна:

27.2.9.1.Эрүүгийн хуульд заасан авлигын, эдийн засгийн болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргийн нэгд эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

27.2.9.2.зээл, батлан даалт, баталгааны гэрээний аль нэгд гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй;

27.2.9.3.сүүлийн таван жилд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байсан үнэт цаасны зах зээлд оролцогчийн тусгай зөвшөөрөл зөрчлийн улмаас хүчингүй болж байгаагүй байх;

27.2.9.4.гүйцэтгэх удирдлага, эсхүл мэргэжилтэн нь өөр зохицуулалттай этгээдийн тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй байх;

27.2.9.5.тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбоотой журамд заасан бусад шаардлагыг хангасан байх.

27.2.10.үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай, түүнийг хэрэгжүүлэх хараат бус дотоод хяналтын ажилтантай байх;

27.2.11.гадаад мэргэжилтнүүдийн тоо нийт ажилтны 30 хувиас хэтрэхгүй иргэд байх;

27.2.12.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх.”

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

#### **11/27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг:**

“27.6.Энэ хуулийн 24.1.6-24.1.9, 24.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

27.6.1.үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалттай байх;

27.6.2.үндсэн үйл ажиллагааг эрхлэх чиглэлийн болон мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

27.6.3.үйл ажиллагаанд ашиглах программ хангамж мэдээллийн нууцлал, мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангасан байх;

27.6.4.бусад дэд бүтцийн байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх;

27.6.5.дотоод мэдээлэл эзэмшигчдийн, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх.”

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

#### **12/33 дугаар зүйлийн 33.2.4 дэх заалт:**

“33.2.4.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тухайд Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан тусгай программ хангамжтай байх.”

**Тайлбар:** Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар

болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьцаа, зээлийн хамтын санхүүжилтын шинэ хэлбэрүүд үүсч бий болсон байна. Үнэт цаасны олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн тайланд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хувьцааны хамтын санхүүжилт нь техник технологийн дэвшил болон 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкуудын бизнесийн зээлийн хэмжээ буурсантай холбогдуулан сүүлийн үед ихээхэн эрчимтэй хөгжиж буй салбар

Энэхүү салбар нь 2025 гэхэд хөгжиж буй орнуудын хувьд \$90-96 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлнэ хэмээн Дэлхийн банк судалгаа гаргасан. Хамтын санхүүжилт нь ихээхэн эрсдэл дагуулдаг боловч энэ нь хөгжсөн улс орнуудын хувьд жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангах нэг арга хэрэгсэлд тооцогддог тул энэхүү үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчинг бий болгохоор зорьж байгаа нь ажиглагдаж байна. Манай улсын хувьд энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх нь жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгох томоохон давуу талтай боловч иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын талаар мэдлэг хомс, мэдээллийн ил тод байдлыг хангах байдал дутагдалтай зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ үйл ажиллагааг буруугаар ашиглах, залилах зэрэг эрсдэл бий болж болзошгүй тул хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөхгүйгээр энэхүү салбарыг дэмжих зохицуулалтын орчинг бий болгох шаардлагатай байна.

Иймд хуулийн төслийн 24.1.19, 50<sup>1</sup>-д хуьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг нэмж байгаатай холбоотойгоор түүнд тавигдах гол шаардлагыг нэмж тусгасан.

### **13/33 дугаар зүйлийн 33.7.4, 33.7.5 дахь заалт:**

"33.7.4.хороонд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлээгүй;

33.7.5.энэ хуулийн 33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур, нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон."

**Тайлбар:** Санхүүгийн зах зээл нь хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийн бүрэн байдал, хөрөнгийн өсөлт бууралттай холбоотой үйл ажиллагаа явагддаг тул санхүүгийн зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэгч байгуулагууд нь зохицуулалтын өндөр хяналт дор үйл ажиллагаа явуулах, санхүүгийн хэрэглэгчдийг аливаа байдлаар хохироох, хөрөнгийн үнэ цэнэд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй. Энэ хүрээнд зохицуулалттай үйл ажиллагаа явуулахад зохицуулагч байгууллагаас тодорхой нөхцөл шаардлагыг хангасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа тогтмол, тогтоосон хугацаанд хангаж байх шаардлагатай байдаг.

Түүнчлэн санхүүгийн зах зээлийн хөгжил маш хурдацтай хөгжиж, дүрэм журам, зохицуулалтын өөрчлөлт тухай бүр хийгдэж байдаг тул үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах үеийн нөхцөл байдал, түүнээс хойш 3 жил үйл ажиллагаа

явуулахгүй байх нь тодорхойгүй байдлыг үүсгэх, хэрэглэгчдэд эрсдэл үүсгэх боломжтой тул дээрх зохицуулалтыг нэмж тусгасан.

#### **14/33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсэг:**

"33.10.Энэ хуулийн 24.1.19-д заасан зохицуулалттай үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно."

**Тайлбар:** Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьцаа, зээлийн хамтын санхүүжилтын шинэ хэлбэрүүд үүсч бий болсон байна. Үнэт цаасны олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн тайланд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хамтын санхүүжилт нь техник технологийн дэвшил болон 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкуудын бизнесийн зээлийн хэмжээ буурсантай холбогдуулан сүүлийн үед ихээхэн эрчимтэй хөгжиж буй салбар

Энэхүү салбар нь 2025 гэхэд хөгжиж буй орнуудын хувьд \$90-96 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлнэ хэмээн Дэлхийн банк судалгаа гаргасан. Хамтын санхүүжилт нь ихээхэн эрсдэл дагуулдаг боловч энэ нь хөгжсөн улс орнуудын хувьд жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангах нэг арга хэрэгсэлд тооцогддог тул энэхүү үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчинг бий болгохоор зорьж байгаа нь ажиглагдаж байна. Манай улсын хувьд энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх нь жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгох томоохон давуу талтай боловч иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын талаар мэдлэг хомс, мэдээллийн ил тод байдлыг хангах байдал дутагдалтай зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ үйл ажиллагааг буруугаар ашиглах, залилах зэрэг эрсдэл бий болж болзошгүй тул хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөхгүйгээр энэхүү салбарыг дэмжих зохицуулалтын орчинг бий болгох шаардлагатай байна.

IOSCO-с 2015 онд хамтын санхүүжилттэй холбоотойгоор гаргасан мэдэгдлийн дагуу хэдийгээр зохицуулалтын орчин нь эхлэлийн үе шатандаа явж байгаа боловч хөрөнгө оруулагчдыг хамгаалах үүднээс зохицуулах байгууллага, бодлого боловсруулагчид дараах эрсдэлээс хамгаалах арга хэмжээг анхааралдаа авах нь зүйтэй байна. Үүнд:

7. Онлайн платформыг бүртгэх, түүнд тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг бий болгох;
8. Үнэт цаас гаргагч, зээл олгогчид, онлайн платформд мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагыг тавих;
9. Онлайн платформын үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоож өгөх;

10. Хөрөнгө оруулагчдыг мэдлэгжүүлэх, хамтын санхүүжилттэй холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдлийг хөрөнгө оруулагчдаас шаардах;
11. Нэг хөрөнгө оруулагчийн тодорхой хугацаанд оруулж болох хөрөнгийн хязгаарыг тогтоож өгөх;
12. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гуравдагч кастодианиар хадгалуулахыг шаардах.

Иймд хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаанд хамааруулж, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад оруулахаар зохицуулсан.

### **15/36 дугаар зүйлийн 36.17, 36.18 дахь хэсэг:**

"36.17.Брокер үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн номиналь данс эзэмшихэд тавигдах нөхцөл шаардлага, тухайн дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

**Тайлбар:** Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь дээрх журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

36.18.Брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

36.18.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, клирингийн байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;

36.18.2.брокерийн үйл ажиллагаа эрхлэх хоёроос доошгүй мэргэжилтэнтэй байх;

36.18.3.нягтлан бодох бүртгэлийн зааварт нийцсэн шаардлагатай мэдээлэл, харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн бүртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг хадгалах, мэдээлэл өгөхтэй холбоотой Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан тусгай программ хангамжтай байх."

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно" гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

### **16/37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг:**

“37.8.Дилерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

37.8.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

37.8.2.үнэт цаасны брокерын үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд эрхэлсэн байх;

37.8.3.дилерийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх.”

*Тайлбар: Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

### **17/39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг:**

“39.3.Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

39.3.1.хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх;

39.3.2.хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээ, хэлцлийг боловсруулж, хянах хуулийн мэргэжилтэнтэй, эсхүл үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээс энэ чиглэлээр тогтмол үйлчилгээ авахаар гэрээ байгуулсан байх;

39.3.3.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх.”

*Тайлбар: Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

### **18/40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг:**

“40.7.Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

40.7.1.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх;

40.7.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

40.7.3.эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн аль нэгд гүйцэтгэх удирдлага, эсхүл бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

40.7.4.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь гадаадын, эсхүл өөрийн орны санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлж байсан туршлагатай байх."

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно" гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

#### **19/41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсэг:**

"41.7.Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

41.7.1.үнэт цаасны үнэлгээ, үнийн тооцооллыг хийх, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах гурваас доошгүй мэргэжилтэнтэй байх;

41.7.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

41.7.3.үнэт цаас гаргагч этгээдтэй байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөл нь дараах зүйлийг тусгасан байх:

41.7.3.1.гэрээ хүчинтэй байх хугацаа;

41.7.3.2.талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

41.7.3.3.нийтэд санал болгож буй үнэт цаасны захиалгын хугацаа;

41.7.3.4.үнэт цаасны захиалгыг авах, хуваарилах арга аргачлал;

41.7.3.5.үнэт цаасны үнийг тогтворжуулах хугацаа, арга хэлбэр;

41.7.3.6.үйлчилгээний хураамжийн хэмжээ.

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох,

сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

41.7.4. үнэт цаасны зах зээлд брокерын, эсхүл дилерийн үйл ажиллагааг хоёр жилийн хугацаанд эрхэлж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас гишүүнчлэлийн үүрэг хангалттай биелүүлсэн талаарх дүгнэлт гаргуулсан, Хорооны баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байх.”

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

#### **20/42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсэг:**

“42.19.Хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хувьцаат компани хэлбэртэй банкны хувьцаа эзэмшигчийн тархалтын мэдээллийг Төв банк /Монголбанк/-аас шаардсан тохиолдолд мэдээллийн эзнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.”

**Тайлбар:** Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд системийн 5 арилжааны банк олон нийтэд нээлттэй банк болсонтой холбоотойгоор тэдгээрийн нээлттэй зах зээл дээр арилжаалагдаж буй хувьцааны хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл тухай бүр өөрчлөгдөж байх ба энэ талаарх мэдээлэл нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд (Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв)-д бүртгэгдэнэ. Монголбанк нь Төвбанкны тухай хуулийн хүрээнд банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалт хийх зорилгоор дээрх мэдээллийг үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс гаргуулан авах зохицуулалтыг тусгах санал ирүүлснийг тусгасан.

#### **21/45 дугаар зүйлийн 45.10, 45.11 дэх хэсэг:**

“45.10.Номиналь эзэмшигчээс бусад харилцагчийн үнэт цаасыг тухайн харилцагчийн нэр дээр бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.

**Тайлбар:** Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр олон улсын төлбөр тооцооны зарчим болох Delivery versus Payment/Т+2 буюу Төлбөрийн эсрэг Нийлүүлэлтийн зарчмыг 2020 онд нэвтрүүлсэнтэй холбоотойгоор үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэгч нь клирингийн гишүүн, төлбөр тооцооны гишүүн байгууллага болж харилцагчдын арилжааны хэлцлийн тоог бууруулах, арилжааны шийтгэлийг багасгах, харилцагчийн эрсдэлийг удирдах, арилжааны эцэслэлтийг хийх болсон.



Үүнтэй холбоотойгоор клирингийн гишүүн, төлбөр тооцооны гишүүн үнэт цаасны компани нь өөрийн номинал дансанд харилцагчдаа бүртгэх болсон.

Төлбөр тооцооны олон улсын дээрх зарчим нэвтрэхээс өмнө Монгол Улсын үнэт цаас эзэмшигч тус бүр нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч дээр нэрлэсэн данстай буюу тухайлсан бүртгэл хийгддэг байсан (кастодианы харилцагчаас бусад).

Энэ хүрээнд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч нь эдгээр төлбөр тооцооны гишүүн үнэт цаасны компаниудын номинал дансыг нэрлэсэн данс эзэмшигчээс тусад нь бүртгэл хөтлөх шаардлага гарч ирж байгааг ийнхүү нэмж зохицуулсан.

45.11. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцоно.”

**Тайлбар:** Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр олон улсын төлбөр тооцооны зарчим болох *Delivery versus Payment/T+2* буюу Төлбөрийн эсрэг Нийлүүлэлтийн зарчмыг 2020 онд нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийг нэгэн зэрэг шилжүүлэх үүргийг буюу төлбөр тооцоо эцэслэгийн үүрэг гүйцэтгэгч болсон. Иймд үнэт цаас болон төлбөр тооцооны эцэслэлттэй холбоотой эрсдэлийн удирдах, холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар хуулийн зохицуулалтыг нэмж тусгах шаардлага үүссэн.

#### **22/46 дугаар зүйлийн 46.7-46.10 дахь хэсэг:**

“46.7. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь харилцагчийн нэрийн өмнөөс түүний зөвшөөрлөөр үнэт цаасны төлбөр, шилжүүлэг гүйцэтгэж болно.

46.8. Кастодианы харилцагч нь гадаад улсад кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй номиналь эзэмшигч, эсхүл итгэмжлэгдсэн өмчлөгч байх тохиолдолд бенефициар өмчлөгчийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу таньж мэдэж, бүртгэнэ.

46.9. Энэ хуулийн 46.8-д заасан кастодианы харилцагч нь Хороо, үйлчилгээ үзүүлж буй кастодианы эрхэлж байгаа этгээдийн шаардлагаар бенефициар өмчлөгчдийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

**Тайлбар:** 1/Олон улсын хөрөнгө оруулагчид аль нэг улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаас авах замаар хөрөнгө оруулалт хийхдээ хөрөнгө оруулсан үнэт цаасыг өмчлөх эрхийг баталгаажуулах, өмчлөх эрхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэгч байгууллага болох харилцдаг олон улсын кастодиан банкаараа дамжин орж ирдэг

Олон улсын кастодиан банк нь харилцагчийнхаа хүсэлтээр хөрөнгө оруулах улсын дотоодын кастодиан банкыг дэд кастодиан банкаар томилон данс нээн хөрөнгө оруулах боломжийг нээн дотоодын кастодиан банктай хамтран ажилладаг

Дотоодын кастодиан банкыг дэд кастодиан банкаар томилоход тухайн улсын хуулийн зохицуулалтаар кастодиан банк нь өөрийн дотоод бүртгэл дэх харилцагчидийн үнэт цаас өмчлөх эрхийг баталгаажуулах эрх бүхий этгээдээр тодорхойлогдсон эсэх болон бусад кастодиан банкны үйл ажиллагааг хуулиар тодорхойлсон байдлыг шалгаж баталгаажуулдаг.

2/Олон улсын хөрөнгө оруулагчид гадаадын зах зээлд хөрөнгө оруулахын тулд хэд хэдэн зуучлагч байгууллагаар дамжих шаардлага үүсдэг. Жишээ нь хөрөнгө оруулагч -> брокер -> ICSD (Euroclear, Clearstream) эсвэл глобал кастодиан -> дэд кастодиан -> CSD.

Зах зээлийн оролцогчид харилцагчиддаа номинал данс нээж, харилцагчдынхаа харилцагчдын үнэт цаасыг (clients' clients' holding) хадгалж байгаа тохиолдолд тухайн дансанд хадгалагдаж байгаа үнэт цаасны эцсийн өмчлөгчдийг тодорхойлох боломжгүй. Олон улсын практикт эцсийн өмчлөгчдийг зөвхөн тухайн эцсийн өмчлөгчид анхлан данс нээсэн оролцогч буюу дээрх жишээгээр брокер нь дотоод бүртгэлээрээ үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулдаг бөгөөд тухайн эцсийн өмчлөгчдийн үнэт цаастай холбоотой эрх, үүрэг нь тухайн брокерийн үйл ажиллагаа явуулж буй улсын хуулиар зохицуулагддаг.

Мөн номинал дансанд хадгалагдаж байгаа үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор (жишээ нь: татвар) эцсийн өмчлөгчдийн мэдээлэл шаардагдсан тохиолдолд глобал кастодиан брокероос ирүүлсэн мэдээлэл, дэд кастодиан глобал кастодианаас ирүүлсэн мэдээллийг тус тус хүлээн зөвшөөрдөг тул дээрх зохицуулалтыг тусгасан.

46.10.Кастодианы үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

46.10.1.тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага бол Компанийн тухай хуульд заасан шаардлага хангасан төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

46.10.2.мэргэжилтнүүд нь банк, санхүү, хөрөнгийн зах зээл дээр ажиллаж байсан туршлагатай, үнэт цаасны зах зээл дээр ажиллах эрх авсан, гурваас дээш жил ажилласан зургаа болон түүнээс дээш мэргэжилтэнтэй байх;

46.10.3.Төв банк /Монголбанк/, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, бусад мэргэжлийн оролцогч болон харилцагчтай мэдээлэл солилцох, төлбөр тооцоо гүйцэтгэх тоног төхөөрөмж, техник, программ хангамжийг бүрдүүлсэн байх;

46.10.4.кастодианы үйл ажиллагаа явуулах сүлжээ, программ хангамжид гэмтэл, саатал гарсан, давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүнд хадгалсан мэдээллийн бааз, бусад өгөгдлийг давхар хадгалах, сэргээх системтэй байх;

46.10.5.нийтэд холбогдох мэдээлэл хүргэх өөрийн тогтмол ажилладаг цахим хуудастай байх;

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

46.10.6.тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь банк бол дараах шаардлагыг хангасан байна:

46.10.6.1.кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгаар, бие даасан нэгжтэй байх;

46.10.6.2.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж нь харилцагчид үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангасан дэд бүтэцтэй байх;

46.10.6.3.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн бүртгэл, тайлан, тооцоо болон албан бичиг хэрэг хөтлөлт нь банкны үндсэн болон бусад үйл ажиллагааны бүртгэл, тайлан, тооцоо, албан бичиг хэргээс тусдаа хөтлөгдөх нөхцөл боломжоор хангасан, эдгээр мэдээлэлд зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжид ажиллаж буй ажилтан нэвтрэх боломжтой байх;

46.10.6.4.банкны үйл ажиллагааг гурван жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн байх;

46.10.6.5.гурваас доошгүй гишүүнээс бүрдсэн төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд тэдгээрийн нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх.”

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

**23/47 дугаар зүйлийн 47.8, 47.9 дэх хэсэг:**

“47.8.Нээлттэй хувьцаат компани болох урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах зорилгоор хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэж, хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож, тэдгээрийн хооронд арилжиж болно.

**Тайлбар:** Олон улсын жишигт, хөрөнгийн биржүүд зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон тодорхой хөрөнгийн шаардлага хангасан, эрсдэл даах

чадвартай хувь хүмүүсийн хүрээнд үнэт цаасыг санал болгон худалддаг туслах захыг ажиллуулдаг.

Туслах захад бүртгэгдэх үнэт цаас гаргаагчид тавих шалгуур, шаардлагыг Бирж өөрөө тогтоодог. Туслах захын жишээ: Лондонгийн хөрөнгийн биржийн "AIM", Хонг Конгийн хөрөнгийн биржийн "GEM", Японы хөрөнгийн биржийн "Mothers and Probond market".

47.9.Энэ хуулийн 47.8-д заасан харилцааг зохицуулсан нарийвчилсан журмыг Хороо батална."

**Тайлбар:** Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь дээрх журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

#### **24/50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг:**

"50.5.Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

50.5.1.хувьцаа эзэмшигч нь дараах этгээд байна:

50.5.1.1.банк, санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллага;

50.5.1.2.сүүлийн таван жилд жилийн аудитлагдсан тайлангаар үйл ажиллагааны борлуулалтын орлого нь нэг тэрбум төгрөгөөс доошгүй, Монгол Улсад бүртгэлтэй компани;

50.5.1.3.зэрэглэл тогтоох үйл ажиллагааг гурваас доошгүй жил эрхэлж буй гадаад улсын зэрэглэл тогтоох байгууллага;

50.5.1.4.компанийн нийт гаргасан хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй иргэн.

50.5.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх;

50.5.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах дүрэм, журам, аргачлал, тэмдэглэгээ, тайлангийн загварыг баталсан байна:

50.5.3.1.зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загвар;

50.5.3.2.Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам болон ёс зүйн дүрэм;

50.5.3.3.үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам;

50.5.3.4.тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журам;

50.5.3.5.шинжээтэй байгуулах гэрээний үндсэн загвар;

50.5.3.6.арга, аргачлал, үзүүлэлт, тэмдэглэгээ, тодорхойлолтын тухай танилцуулга.

50.5.4.олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудастай байх;

50.5.5.зэрэглэл тогтоох хороо таваас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүн хуульд заасан мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх;

50.5.6.зэрэглэл тогтоох чиглэлээр ажилласан ажлын туршлагатай хоёроос доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх, эсхүл эдийн засаг, санхүүгийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын чиглэлээр таваас доошгүй жил ажилласан дөрвөөс доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх.”

*Тайлбар: Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

## **25/50<sup>1</sup> дүгээр зүйл:**

### **“50<sup>1</sup> дүгээр зүйл.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа**

50<sup>1</sup>.1.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай программ хангамжаар дамжуулан гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчийн хооронд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулах зорилготой байна.

50<sup>1</sup>.2.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны үндсэн орлого нь гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчид тусгай программ хангамж ашиглуулснаас авах шимтгэлээс бүрдэнэ.

50<sup>1</sup>.3.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа,түүний программ хангамжид тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо тогтооно.

50<sup>1</sup>.4.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 11.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамаарахгүй.

50<sup>1</sup>.5.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавигдах гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн татан төвлөрүүлэх

хөрөнгийн нийт хэмжээ, хөрөнгө оруулалт татах хугацаа болон иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, хөрөнгө оруулах хөрөнгийн дээд хэмжээ, хязгаарлалтыг Хороо тогтооно.”

**Тайлбар:** Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьцаа, зээлийн хамтын санхүүжилтын шинэ хэлбэрүүд үүсч бий болсон байна. Үнэт цаасны олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн тайланд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хамтын санхүүжилт нь техник технологийн дэвшил болон 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэн банкуудын бизнесийн зээлийн хэмжээ буурсантай холбогдуулан сүүлийн үед ихээхэн эрчимтэй хөгжиж буй салбар

Энэхүү салбар нь 2025 гэхэд хөгжиж буй орнуудын хувьд \$90-96 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлнэ хэмээн Дэлхийн банк судалгаа гаргасан. Хамтын санхүүжилт нь ихээхэн эрсдэл дагуулдаг боловч энэ нь хөгжсөн улс орнуудын хувьд жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, тэдгээрийг зардал багатай эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангах нэг арга хэрэгсэлд тооцогддог тул энэхүү үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчинг бий болгохоор зорьж байгаа нь ажиглагдаж байна. Манай улсын хувьд энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх нь жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгох томоохон давуу талтай боловч иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын талаар мэдлэг хомс, мэдээллийн ил тод байдлыг хангах байдал дутагдалтай зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ үйл ажиллагааг буруугаар ашиглах, залилах зэрэг эрсдэл бий болж болзошгүй тул хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөхгүйгээр энэхүү салбарыг дэмжих зохицуулалтын орчинг бий болгох шаардлагатай байна.

IOSCO-с 2015 онд хамтын санхүүжилттэй холбоотойгоор гаргасан мэдэгдлийн дагуу хэдийгээр зохицуулалтын орчин нь эхлэлийн үе шатандаа явж байгаа боловч хөрөнгө оруулагчдыг хамгаалах үүднээс зохицуулах байгууллага, бодлого боловсруулагчид дараах эрсдэлээс хамгаалах арга хэмжээг анхааралдаа авах нь зүйтэй байна. Үүнд:

13. Онлайн платформыг бүртгэх, түүнд тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг бий болгох;
14. Үнэт цаас гаргагч, зээл олгогчид, онлайн платформд мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагыг тавих;
15. Онлайн платформын үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоож өгөх;
16. Хөрөнгө оруулагчдыг мэдлэгжүүлэх, хамтын санхүүжилттэй холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдлийг хөрөнгө оруулагчдаас шаардах;
17. Нэг хөрөнгө оруулагчийн тодорхой хугацаанд оруулж болох хөрөнгийн хязгаарыг тогтоож өгөх.

18. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гуравдагч кастодианиар хадгалуулахыг шаардах.

Иймд хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаанд хамааруулж, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад оруулахаар зохицуулсан.

#### **26/51 дүгээр зүйлийн 51.1.6 дахь заалт:**

"51.1.6.хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг."

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт "Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг төлөөлөх ажиллагаа байна." гэж заасан.

Гэтэл мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.7.1 дэх заалт нь "Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ хуульд заасан үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаатай хавсран эрхэлж болно" гэж заасан нь хуулийн давхардал үүсгэж байна.

Иймд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд "үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ"-ний төрлийг оруулсан.

#### **27/51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг:**

"51.4.Энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх хүсэлт гаргаж болно:

51.4.1.Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирал дараалан хангаж ажилласан байх;

51.4.2.Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар сайн болон хангалттай үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байх."

**Тайлбар:** Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно" гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.

### **28/63 дугаар зүйлийн 63.1.20-63.1.24 дэх заалт:**

"63.1.20.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журмыг тогтоож, үйлчилгээ үзүүлэгч этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;

63.1.21.хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой журмыг батлах;

63.1.22.үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон журмыг батлах;

63.1.23.үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэл, өв залгамжлалаар шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг батлах;

63.1.24.хуульд заасан бусад."

**Тайлбар:** Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь дээрх журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

### **29/78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсэг:**

"78.3.Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох үйлдлээс сэргийлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо батална."

**Тайлбар:** Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь дээрх журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

### **30/80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг:**

"80.6.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо батална."

**Тайлбар:** Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь дээрх журмыг батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

### **31/88<sup>2</sup> дугаар зүйл:**

"88<sup>2</sup>.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг



88<sup>2</sup>.1. Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.

88<sup>2</sup>.2. Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

88<sup>2</sup>.2.1. холбогдох мэргэжлийн байгууллагаас ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн дүгнэлт гарсан байх;

88<sup>2</sup>.2.2. үнэт цаас үйлдвэрлэхэд ашиглагддаг шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй байх;

88<sup>2</sup>.2.3. үнэт цаас үйлдвэрлэхтэй холбоотой аюулгүй ажиллагаа, нууцлалыг хангасан байх.

88<sup>2</sup>.3. Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

88<sup>2</sup>.3.1. ерөнхий танилцуулга, үүсгэн байгуулах баримт бичиг;

88<sup>2</sup>.3.2. үнэт цаас үйлдвэрлэхтэй холбоотой тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааг ханган ажиллах хүний нөөцийн мэдээлэл;

88<sup>2</sup>.3.3. үнэт цаас үйлдвэрлэх горимыг тогтоосон журам, илүүдэл болон алдаатай үнэт цаасны устгал, түүний бүртгэлд тавих хяналт, байгууллагын дотоод хяналтад мөрдөгддөг дүрэм, журмын хуулбар."

*Тайлбар: Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно" гэж заасан. Энэ дагуу үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

**2 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "нийслэл," гэсний дараа "олон улсын санхүүгийн байгууллага," гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.13 дахь заалтын "хөрөнгө" гэсний өмнө "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан" гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийн "24.1.17" гэсний дараа ", 24.1.19" гэж, мөн зүйлийн 33.6.2 дахь заалтын "33.3" гэсний дараа ", 33.10" гэж, 36 дугаар зүйлийн 36.8 дахь хэсгийн "дансанд" гэсний дараа ", эсхүл номиналь дансанд" гэж, мөн зүйлийн 36.11 дэх хэсгийн "харилцагчийн нэр дээр" гэсний дараа ", эсхүл мөнгөн хөрөнгийн номиналь" гэж, 41 дүгээр зүйлийн 41.4.1 дэх заалтын "бэлтгэх," гэсний дараа "үнэт цаас гаргагч түүний санал болгох үнэт цаасны талаар магадлан шинжилгээ хийх," гэж, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийн "бүртгэлийн" гэсний өмнө "тухайлсан" гэж, 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалтын "дилерийн" гэсний дараа ", үнэт цаасны итгэмжлэн удирдах" гэж, 63 дугаар зүйлийн 63.1.6, 63.1.10 дахь заалтын "хасах" гэсний дараа ", түүнтэй холбоотой нарийвчилсан журмыг тогтоох" гэж тус тус нэмсүгэй.

*Тайлбар: 1/ Олон улсын санхүүгийн байгууллагууд нь сүүлийн жилүүдэд хөгжиж буй зах зээлийн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаадын хөрөнгө*

оруулалтын тухайн улсад оруулах, тухайн өрийн хэрэгслээр дамжуулан босгосон санхүүгийн эх үүсвэрийг тухайн орны дотоодын хувийн хэвшлийн томоохон төсөл хөтөлбөр, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай урт хугацааны санхүүжилтийг олгоход зарцуулж, үүгээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, валютын урсгалыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан, тэдгээрийн portfolio investment буюу багцын хөрөнгө оруулалтад Монгол Улсын Засгийн газрын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл нэмэгдэх боломжийг олгох нь чухал юм. Энэхүү олон санхүүгийн байгууллагууд нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Фитч болон Эс энд Пи байгууллагуудаас “AAA” зэрэглэлтэй буюу эрсдэлгүй хөрөнгө оруулалтын үнэлгээтэй байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагууд (Ж: АХБ, ОУСК...) Монголын хөрөнгийн зах зээл дээр төгрөгийн бонд гаргах, гаргасан тохиолдолд босгосон санхүүгийн эх үүсвэрийг Монголын аж ахуй нэгжүүдийн хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийг урт хугацаатай, бага зардлаар санхүүжүүлэх зорилготой байгаа юм.

Гэсэн хэдий ч одоогоор Монгол Улсын хууль эрх зүйн орчин, ялангуяа санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийн холбогдох хуулиудад энэ талаарх зохицуулалт байхгүй байгаа тул эдгээр байгууллагууд өрийн хэрэгсэл гаргах боломжгүй хууль эрх зүйн орчин тодорхойгүй байгааг тодорхой болгож, энэ хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагыг үнэт цаас гаргагчаар нэмж зохицуулсан.

2/ Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, давхардал, хийдлийг арилгах зорилтын хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд давхарлан зохицуулагдаж байсныг нэгтгэн зохицуулсан. Энэ хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан гэж тодотгосон.

3/Түүнчлэн бусад заалтуудыг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн зохицуулалтыг тодохой болгож нэмж оруулсан.

**3 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:**

“3.1.Энэ хуулиар үнэт цаасыг нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд гаргах, арилжих, бүртгэх, клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.”

**Тайлбар:** Одоо мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалт, зохицуулах харилцаа нь биржийн зах зээлийн зохицуулалтад төвлөрсөн, компанийн бонд гаргах болон үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа үр дүнтэй биш, биржийн бус зах зээлийг хязгаарласан байсан.

*Иймд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлж, үүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулсан*

*Мөн хөрөнгийн зах зээлд олон улсын төлбөр тооцооны Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг 2020 онд нэвтрүүлсэн мөн санхүүгийн зах зээл дээр өргөн хэрэглэгддэг нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн хуультай нийцүүлэх зорилгоор тооцоо гэдэг үгийг клиринг /clearing/ гэж хэрэглэж явахаар болсон.*

#### **2/4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.4 дэх заалт:**

*"4.1.1."үнэт цаасны зах зээл" гэж үнэт цаасыг бүртгүүлэх, гаргах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зах зээлийн харилцааг;*

***Тайлбар:** Хөрөнгийн зах зээлд олон улсын төлбөр тооцооны Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг 2020 онд нэвтрүүлсэн мөн санхүүгийн зах зээл дээр өргөн хэрэглэгддэг нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн хуультай нийцүүлэх зорилгоор тооцоо гэдэг үгийг клиринг /clearing/ гэж хэрэглэж явахаар болсон.*

*Мөн үнэт цаасны өмчлөх эрх бүртгэл болон арилжааны төлбөр тооцоог зохицуулж байгаа хууль журмын зохицуулалт тодорхой бус байгаа нь цаашид зах зээлийг тэлэх, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх практик шаардлагыг үүсгэж байна.*

*4.1.2."биржийн зах зээл" гэж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн үнэт цаасыг арилжихтай холбогдсон харилцааг;*

***Тайлбар:** Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээл нь "биржийн" болон "биржийн бус зах зээл" гэсэн 2 зах зээлээс бүрддэг нийтлэг жишигтэй байдаг. Энэ хүрээнд дотоодын үнэт цаасны зах зээд биржийн болон биржийн бус зах зээлийг бий болгож, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад зах зээлийн талаар ойлгомжгүй, тодорхой бус байдлыг бий болгохоо сэргийлэх, олон улсын жишигт зах зээлийн нэр томъёогоо нийцүүлэх шаардлага тулгарсан.*

*4.1.3."биржийн бус зах зээл" гэж энэ хуулийн 4.1.19-д заасан этгээд хууль тогтоомжоор хориглоогүй, өөрийн өмчлөлийн болон өмчлөгчөөс эрх олгосон хөрөнгөөр санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг;*

***Тайлбар:** Биржийн бус зах зээлд мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, идэвхтэй хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн хөрөнгө оруулагчдын өөрийн болон өмчлөгчөөс эрх олгосон хөрөнгөөр санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн.*

*4.1.4."үнэт цаасны анхдагч зах зээл" гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа хөрөнгө оруулагчид нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд худалдахтай холбогдсон харилцааг;"*

***Тайлбар:** Одоо мөрдөгдөж буй хуулийн тус заалтаар үнэт цаасыг зөвхөн хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох харилцааг зохицуулсан*

нь биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орхигдуулсан, зах зээл тэлэх боломжийг хаасан зохицуулалт байсан тул үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хүрээнд гаргаж болох талаар зохицуулсан.

#### **3/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:**

"4.1.7."үүсмэл санхүүгийн хэрэгсэл /дериватив/" гэж опцион гэрээ, фьючерсийн гэрээ, форвард гэрээ, своп гэрээ болон Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг;"

*Тайлбар:* Биржийн бус зах зээл дээр арилжаалагддаг форвард, своп зэрэг хэрэгслийг үүсмэл санхүүгийн хэрэгсэлд хамааруулсан. Мөн хөрөнгийн зах зээлийн хурдацтай өөрчлөгдөж буй хөгжлийг харгалзан шинээр үүсэн гарч ирж болзошгүй үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд арилжиж болох зохицуулалтыг нэмж тусгасан

#### **4/4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт:**

"4.1.13."хадгаламжийн бичиг гаргагч /депозитор/" гэж Монгол Улсын болон гадаад улсын үнэт цаасны хадгаламжийн /кастодиан/ үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг;"

*Тайлбар:* Одоо мөрдөгдөж буй хуулийн 14,15 дугаар зүйлүүдэд хадгаламжийн бичгийг Монголын Улсын болон гадаад улсын хадгаламжийн бичиг гэж 2 ангилан зохицуулсан байдаг бөгөөд үүнийг нэр томъёонд нарийвчлан тусгах шаардлагатай юм.

#### **5/4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалт:**

"4.1.19."мэргэжлийн хөрөнгө оруулагч" гэж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, андеррайтер, дилер, үнэт цаасны итгэмжлэн удирдах, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зэрэг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж тогтоосон бусад этгээдийг;"

*Тайлбар:* Мэргэжлийн хөрөнгө оруулагч гэдэг тодорхойлолт нь мэргэжлийн хөрөнгө оруулагч гэдэгт ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хамааруулах талаар тодорхойлж байгаа тул нэр томъёоны нэршлийг өөрчилж, үйл ажиллагааны төрлийг нэмсэн. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Хорооны гаргасан шийдвэр нь Тогтоол хэлбэртэй тул Хорооноос "мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж тогтоосон" болгож өөрчилсөн. Ингэснээр Хороо цаашид бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан Тогтоолоор мэргэжлийн хөрөнгө оруулагчдад тавигдах шаардлагад өөрчлөлт оруулах боломжтой болох юм.

#### **6/4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь заалт:**

"4.1.27."үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хөрөнгийн биржийн бүртгэл" гэж тухайн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын биржийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг;"

**Тайлбар:** Хөрөнгийн бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д зааснаар арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гэж тодорхойлогддог бөгөөд одоо байгаа хуулийн нэршлээр "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийг зөвхөн арилжаа эрхлэх байгууллага мэтээр зах зээл дээр ойлгогдож төөрөгдөл үүсгэж буй тул өөрчлөн найруулсан.

#### **7/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсэг:**

"9.3.Урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар нэмж гаргахдаа хялбаршуулсан журмаар Хороонд бүртгүүлэх ба түүнтэй холбогдсон журмыг Хороо батална.

**Тайлбар:** Олон улсын жишгийн дагуу үнэт цаас гаргагчийн урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд нэмж гаргахдаа андеррайтераар дамжуулан зохион байгуулах, ингэснээр хаалттай хүрээнд үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах, зардал бууруулах, андеррайтерын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүний тоог өсгөхөөр зохицуулсан. Түүнчлэн Биржид бүртгэлтэй, хорооны зохицуулалтад байдаг ХК нь дахин үнэт цаас гаргахдаа хялбаршуулсан журмаар бүртгүүлэх боломжийг олгосноор үнэт цаас гаргагчид учруулах хүндрэлийг багасгана.

9.4.Урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол энэ талаар Хороонд мэдээлэл хүргүүлэх ба олон нийтэд өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ."

**Тайлбар:** Биржид бүртгэлтэй, хорооны зохицуулалтад байдаг ХК нь дахин үнэт цаас гаргахдаа хялбаршуулсан журмаар Хороонд мэдээлэх боломжийг олгосноор үнэт цаас гаргагчид учруулах хүндрэлийг багасгана. Түүнчлэн хаалттай хүрээнд арилжиж байгаа талаарх тус мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар мэдээлснээр тухайн төрлийн үнэт цаасыг худалдан авах сонирхолтой олон нийт мэдээллээр хангагдаж, нийт төвлөрүүлэх орлогын тоо өсөх зэрэг давуу талтай.

#### **8/9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэг:**

"9.13.Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас энэ хуулийн 9.6-д заасны дагуу нийтэд санал болгон гаргах үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэсэн, нийтэд санал болгох болон үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг бүртгэсэн байгууллага хариуцахгүй."

*Тайлбар:* Одоогийн мөрдөгдөж байгаа хуульд “Хороо, хөрөнгийн биржээс...” гэж заасан байдаг ба үүнийг “...арилжаа эрхлэх байгууллагаас...” болгож өөрчлөх нь зүйтэй юм.

### **9/12 дугаар зүйлийн 12.5-12.7 дахь хэсэг:**

“12.5.Энэ хуулийн 12.4-т заасан тайланд үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр арилжих бэлтгэл хангагдсан тухай үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолтыг хавсаргасан байна.

*Тайлбар:* Хуулийн заалтыг ишилсэн нь тухайн заалт нь хуулийн 12.4-т заасан агуулгатай давхцаж байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх” гэж заасны дагуу эш татах нь зүйтэй юм.

Түүнчлэн өмнөх хуулийн зохицуулалтад дурдсан хөрөнгийн бирж гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэж заасны дагуу өөрчлөн найруулсан.

12.6.Хороо үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах ба зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно.

*Тайлбар:* Арилжаа гэснийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэлийн аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана.” гэж заасны дагуу худалдах гэж өөрчилсөн. Учир нь үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гарган худалдах үйл ажиллагаа явагддаг тул дээрх заалтын дагуу өөрчлөх нь зүйтэй юм.

12.7.Хороо доор дурдсан нөхцөлийн аль нэг нь бүрэн хангагдсан бол үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсон гэж үзнэ:

*Тайлбар:* Арилжаа гэснийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэлийн аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана.” гэж заасны дагуу худалдах гэж өөрчилсөн. Учир нь үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гарган худалдах үйл ажиллагаа явагддаг тул дээрх заалтын дагуу өөрчлөх нь зүйтэй юм.

12.7.1.үнэт цаасыг тогтоосон үнээр гаргаж байгаа тохиолдолд санал болгосон бүх үнэт цаас худалдагдсан буюу татан төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;

*Тайлбар:* Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх бөгөөд тухайн компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байна.” гэж заасны дагуу нэрлэсэн үнэ нь компанийн хувьцааны анх тогтоосон үнэ, харин тогтоосон үнэ нь хувьцаа

гаргах үеийн компанийн тухайн үеийн зах зээлийн эрэлт, үнэ цэнээр тогтож буй үнэ юм. Иймд нэрлэсэн үнэ гэснийг тогтоосон үнэ болгож өөрчилсөн

Түүнчлэн одоогийн мөрдөгдөж байгаа хуульд зааснаар “үнэт цаасыг нэрлэсэн үнээр гаргаж байгаа тохиолдолд санал болгосон бүх хувьцаа” гэж заасан байх ба энэ тохиолдолд утга, агуулгын хувьд үнэт цаас гэдэг нь хувьцаа гэдгээр ойлгогдож байх тул бүх үнэт цаас гэж өөрчилсөн болно.

12.7.2.үнэт цаасыг захиалгын бүртгэлийн аргаар санал болгосон тохиолдолд төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;

**Тайлбар:** Олон улсад андеррайтерийн компаниуд нь анхдагч зах зээлд үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг санал болгон гаргах ажиллагааг хэрэгжүүлэхдээ ихэвчлэн захиалгын бүртгэлийн аргыг ашигладаг бөгөөд ингэснээр тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны эрэлтээс хамаараад хөрөнгө оруулагчид санал болгосон үнээс дээгүүр үнээр захиалга өгч, худалдан авах боломж бүрддэг.

12.7.3.үнэт цаасыг санал болгосны дараа түүний худалдаагүй үлдсэн хэсгийг андеррайтер нь худалдан авч энэ хуулийн 12.7.1 эсхүл 12.7.2-т заасан нөхцөлийг бүрдүүлсэн.”

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын банк буюу андеррайтерийн компаниуд нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахдаа урьдчилан хэлэлцээр хийсэн стратегийн хөрөнгө оруулагчид болон бусад сонирхол бүхий томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг худалдаж, хуваарилах замаар үнэт цаас гаргагчийн шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх ажиллагааг амжилттай зохион байгуулдаг. Үнэт цаас гаргагчид гэрээ байгуулсан андеррайтер нь анхдагч зах зээлд үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээдэг бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болгох хүрээнд худалдаагүй үлдсэн хэсгийг өөрийн хөрөнгөөр худалдан авч үүргээ хэрэгжүүлдэг болгох замаар үүрэг, ү хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн.

**10/16 дугаар зүйл:**

**“16 дугаар зүйл.Компанийн өрийн хэрэгсэл**

16.1.Компанийн өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр энэ хуульд нийцүүлэн гаргана.

16.2.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх журмыг Хороо батална.

16.3.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь дараах нөхцөлийн аль нэгийг хангасан байна:

16.3.1.үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаатай байх;

16.3.2.санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр зэрэглэл тогтоолгосон байх.

16.4.Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан компани тодорхой үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.

16.5.Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдах тохиолдолд эхний гаргах өрийн хэрэгсэл нь энэ хуулийн 10.1-д заасан хугацаанд гарсан байна.

16.6.Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-д заасан болон бусад этгээд нь компанийн өрийн хэрэгслийг эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээллийг тухай бүр шаардах, барьцаа, баталгааны гэрээг байгуулах, түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг итгэмжлэлгүйгээр эдэлнэ.”

*Тайлбар: Дотоодын аж ахуйн нэгжүүд олон нийтээс болон хаалттай хүрээнд компанийн өрийн хэрэгсэл гаргах замаар шаардлагатай санхүүжилт татахад зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, компанийн өрийн хэрэгсэл гаргахад тавигдах шаарлага, хугацаа, үе шатыг багасгах шаардлага үүссэн. Тодруулбал, компанийн өрийн хэрэгслийг бирж, биржийн бус зах зээл дээр гаргах, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаа хөрөнгө шаардахгүй байх өөрийн хөрөнгийн хэмжээний шаардлагыг тавихгүй байх зэрэг зохицуулалтыг тусгасан.*

*Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг нь агуулгын хувьд бүхэлдээ өөрчлөгдөж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9-т “Өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томьёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохооргүй байвал түүнийг өөрчлөн найруулна.” гэж заасны дагуу өөрчлөн найруулсан болно.*

### **11/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:**

“17.3.Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад нийтэд санал болгон үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэнэ.”

*Тайлбар: Дотоодын аж ахуйн нэгжүүд гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагаас гадна биржийн бус зах зээл дээр олон нийтэд үнэт цаасаа санал болгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан. Ингэснээр гадаад улсад үнэт цаас гаргасан компаниудын үнэт цаас холбоотой мэдээллийн сан бүрдэх боломж нэмэгдэнэ.*

### **12/19 дүгээр зүйл:**

#### **“19 дүгээр зүйл.Үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих**

19.1.Үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр гаргах, арилжих, оролцогчид тавих нөхцөл, шаардлагыг тогтоох ерөнхий журмыг Хороо батална.



19.2.Биржийн зах зээл дээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэгсэл, стандарт гэрээний нөхцөл, түүнийг арилжих журмыг тухайн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага батална.

19.3.Биржийн бус зах зээл дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжихдаа олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, стандартыг баримтална.”

*Тайлбар: Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлж, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнэт цаасны компаниуд, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санхүүгийн хөшүүргийг бүрдүүлэх шаардлага үүссэн. Үүнтэй холбогдуулан зөвхөн биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчийн хооронд арилжаалагддаг байсныг олон улсын нийтлэг жишгийн дагуу бирж болон биржийн бус зах зээл дээр арилжаалагдах боломжтой байхаар зохицуулсан.*

### **13/20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт:**

“20.1.6.санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд, мөн жилийн эцсийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;”

*Тайлбар: Санхүүгийн тайлалд аудит хийлгүүлэн ирүүлэхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд багтахгүй байх бэрхшээл гарч байсан тул өөрчлөн найруулсан.*

### **14/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:**

“21.2.Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон, хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Хороо үнэт цаас гаргагчид учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шаардах, тухайн шийдвэр болон түүнийг үндэслэн хийсэн хэлцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг итгэмжлэлгүйгээр эдэлж болно.”

*Тайлбар: Санхүүгийн зохицуулах зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасанчлан тус Хороо нь хөрөнгө, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн байгууллага тул үнэт цаас гаргасан компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийг хамгаалах эрхийг нэмж тусгасан.*

### **15/29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь хэсэг:**

“29.1.2.хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, клиринг, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага зэрэг эрх бүхий өөрийгөө зохицуулах байгууллагаас гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий бол;”

*Тайлбар: “Тооцооны байгууллага” гэдгийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай нийцүүлэн санхүүгийн салбарын нэр томъёог ижил утгаар ойлгох, зах зээл дээр тогтсон нэр томъёог ашиглаж хэвшүүлэх, санхүүгийн хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэхгүйн тулд “клирингийн байгууллага” гэж өөрчилсөнтэй холбоотойгоор тус заалтыг өөрчлөн найруулсан.*

### **16/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:**

“33.3.Энэ хуулийн 24.1.15-24.1.17-д заасан зохицуулалттай үйл ажиллагааны төрөл тус бүрд тавих нөхцөл, шаардлагыг энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага, Хуульчдын холбоо, хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын саналыг харгалзан Хороо тогтооно.”

*Тайлбар: Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Аудитын тухай хуулийг ишилсэн байсан нь дээрх хуулиудад өөрчлөлт орох тохиолдолд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсэж болзошгүй гэж үзсэн тул хассан байдлаар уг заалтыг өөрчилсөн.*

### **17/35 дугаар зүйлийн 35.8, 35.9 дэх хэсэг:**

“35.8.Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь Хорооны төлөөлөл байна.

*Тайлбар: Өөрийгөө зохицуулах байгууллага болохын хувьд мэргэжлийн холбоонд мэргэшлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой чиг үүргийг өсгөх шаардлага тулгарсан. Энэ хүрээнд мэргэшлийн зөвлөлийн даргыг Хороо удирдах зохицуулалтыг хасан гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь Хорооны төлөөлөл байхаар зохицуулсан.*

35.9.Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулахтай холбогдсон журмыг энэ хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо батална.”

*Тайлбар: Өөрийгөө зохицуулах байгууллага болохын хувьд мэргэжлийн холбоонд мэргэшлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой чиг үүргийг өсгөх шаардлага тулгарсан. Энэ хүрээнд шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулахтай холбогдсон журам батлах эрхийг мэргэжлийн холбоонд шилжүүлсэн.*

### **18/36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсэг:**

“36.14.Брокерын нэр дээрх харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь данснаас бусдын өмнө брокерийн хүлээсэн үүргийг гүйцэтгэхгүй ба эрх бүхий этгээдээс брокерын дансыг битүүмжлэх тохиолдолд харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь дансыг давхар битүүмжлэхийг хориглоно.

*Тайлбар: Олон улсын санхүүгийн зах зээлд үнэт цаасны компаниуд харилцагчдад үйлчилгээ үзүүлэхдээ мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь дансаар дамжуулан арилжааны захиалгыг түргэн шуурхай, өртөг багатайгаар гүйцэтгэдэг нийтлэг жишиг байдаг. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгаж, үнэт цаасны арилжааны үр ашигт байдлыг өсгөх зорилгоор мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номиналь дансны зохицуулалтыг тусгаж өгсөн.*

### **18/36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсэг:**

"36.16.Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлөөр эрхлэх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

*Тайлбар:* Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн энгийн зөвшөөрөлд багтсан зөвшөөрөл бөгөөд энэ хуульд заасан зохицуулалттай этгээд брокер, дилерийн компаниуд уг үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг нарийвчлан тодорхойлох шаардлага үүссэн.

36.16.1.Хорооноос тогтоосон хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

*Тайлбар:* Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа нь хөрөнгө оруулагч, харилцагчдын хөрөнгөөр гадаад улсын зах зээл дээрээс үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийдэг, эрсдэлтэй үйл ажиллагаа тул хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрт учирж болзошгүй эрсдэлээс хамгаалах хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох шаардлагатай.

36.16.2.Хорооноос тогтоосон тусгай нөхцөл шаардлагыг хангасан үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн программтай байх ба программ нь дараах нөхцөлийг хангасан байна:

36.16.2.1.гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн болон кастодиан, брокерын компанийн дүрэм, журамд нийцүүлэн харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;

36.16.2.2.харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;

36.16.3.харилцагчийн данс хариуцсан мэргэжилтэнтэй байх ба уг мэргэжилтэн нь үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй байх;

36.16.4.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерын үйл ажиллагааны журамтай байх;

36.16.5.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэхэд баримтлах бодлого, бизнесийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тооцоололтой байх."

*Тайлбар:* Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа нь хөрөнгө оруулагч, харилцагчдын хөрөнгөөр гадаад улсын зах зээл дээрээс үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийдэг, эрсдэлтэй үйл ажиллагаанд хамаардаг. Үүнтэй холбогдуулан гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаанд тавих шаардлагыг тухайлан тусгаж өгсөн бөгөөд үйл ажиллагаа, зах зээлийн эрсдэлтэй холбогдуулан үйл ажиллагаа нь доголдох, харилцагч, хөрөнгө оруулагч хөрөнгөө алдахаас сэргийлэх зорилгоор зохицуулсан.

20/41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг:

"41.1. Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох, захиалга авах, хуваарилах, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ."

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын банк буюу андеррайтерийн компаниуд нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахдаа урьдчилан хэлэлцээр хийсэн стратегийн хөрөнгө оруулагчид болон бусад сонирхол бүхий томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг худалдаж, хуваарилах замаар үнэт цаас гаргагчийн шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх ажиллагааг амжилттай зохион байгуулдаг. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгосон үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын сан, тэтгэврийн сан, банк, санхүү болон даатгалын компаниуд худалдан авдаг бол санхүүгийн мэдлэг, мэдээлэл дутмаг жижиг хөрөнгө оруулагчид ихэвчлэн мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдээр дамжуулан оролцдог нийтлэг жишигтэй. Харин жижиг хөрөнгө оруулагчид ихэвчлэн хоёрдогч зах зээлд үнэт цаасыг брокерийн компаниар дамжуулан шууд худалдан авах, худалдах замаар идэхтэй оролцдог. Дээрх олон улсын жишгийн дагуу андеррайтерийн компанийн үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийг тодорхой болгон зохицуулсан.

#### **21/43, 44 дүгээр зүйл:**

#### **"43 дугаар зүйл. Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа"**

43.1. Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа (цаашид "клирингийн үйл ажиллагаа" гэх) гэж клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд (цаашид "клирингийн төв" гэх)-ээс хэрэгжүүлэх доор дурдсан үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:

43.1.1. үнэт цаасны арилжааны хэлцлийг хуваан худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч тал буюу дундын зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

43.1.2. үнэт цаасны арилжааны хэлцлийн эсрэг тал болсонтой холбоотой эрх үүргийг хэрэгжүүлэх;

43.1.3. үнэт цаасны арилжааны баталгаажсан болон арилжааны бус хэлцлийн дагуу үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэхтэй холбоотой арилжаанд оролцогч талуудын хүлээх үүргийг хэлцэл тус бүрээр эсхүл цэвэршүүлсэн дүнгээр тодорхойлох;

43.1.4. үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөр тооцооны байгууллагад илгээх;

43.1.5. үнэт цаасны арилжааны хэлцэлд оролцогч талууд үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан үүсэх талуудын болон системийн эрсдэлийг удирдах.

43.2. Клирингийн төв нь клирингийн үйл ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.

43.3.Клирингийн төв гишүүнчлэлтэй (цаашид “клирингийн гишүүн” гэх) байх бөгөөд клирингийн төвийн тусгай зөвшөөрлийн шалгуурыг Хорооны журмаар, клирингийн төвийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн төвийн журмаар тус тус зохицуулна.

43.4.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас барьцаа шаардах, барьцаа хөрөнгийг өөрийн дансанд байршуулах, баталгаажсан хэлцэлтэй холбоотой гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.5.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор үнэт цаасны компани өөрийн харилцагчаас захиалгын үнийн дүнгийн тодорхой хувиар барьцаа байршуулахыг шаардах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.6.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааны системийн эрсдэлийг удирдах зорилгоор клирингийн төв нь төлбөрийн баталгааны сан байгуулах, төлбөрийн баталгааны сангийн үйл ажиллагааны журам гаргах, удирдан зохион байгуулах үүрэгтэй. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн төв, клирингийн гишүүний төлбөрийн баталгааны санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.

43.7.Шүүхээс үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын баталгаажсан хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцсон тохиолдолд тухайн баталгаажсан хэлцлийн клиринг, төлбөр тооцоог хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал, шимтгэл, баталгаажсан хэлцлийн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

43.8.Үнэт цаасны арилжааны баталгаажсан хэлцэлтэй холбоотой төлбөрийн үүрэг бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд тухайн хэлцлийн клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, клирингийн төв, төлбөр гүйцэтгэх байгууллагын энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг зогсоохгүй.

43.9.Клирингийн төв нь тухайн мэдээллийг нийтэд нээлттэй болгох талаар Хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас бичгээр шаардсан, эсхүл хууль хяналтын байгууллагын шаардлага, шүүхийн шийдвэр гарснаас бусад тохиолдолд өөрийн гишүүн, түүний харилцагчийн талаарх өөрт байгаа бүх мэдээллийн нууцлалыг хадгална.

43.10.Клирингийн үйл ажиллагааны журмыг Хороо батална.

43.11.Төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан клирингийн гишүүний хөрөнгийг холбогдох хуулийн дагуу хуваарилахдаа тэргүүн ээлжид үнэт цаасны төлбөрийн үүргийг барагдуулна.

*Тайлбар: Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжааны дараа төлбөрт горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, арилжаа,*

төлбөрийн тооцооллыг үр ашигтайгаар зохион байгуулах шаардлага бий болсон. Үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг олон улсын нийтлэг жишиг, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гаргасан зарчмууд, зах зээлийн нөхцөл байдал болон өөрийн орны онцлогтой нийцүүлэн сайжруулсан.

#### **44 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа**

44.1. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий хуулийн этгээдээс хэрэгжүүлэх доор дурдсан үйл ажиллагааг ойлгоно:

44.1.1. холбогдох байгууллагаас ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах;

44.1.2. үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг хэлцэл тус бүрээр, эсхүл цэвэршүүлсэн дүнгээр нэгэн зэрэг гүйцэтгэх;

44.1.3. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарвал тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох;

44.1.4. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээний тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх.

44.2. Үнэт цаасны төлбөр тооцоог тухайн арилжаа явагдсанаас хойш ажлын гурван өдөрт багтаан гүйцэтгэнэ.

44.3. Үнэт цаасны шилжүүлэг хийгдсэнээр үнэт цаасны өмчлөх эрх шилжсэнд тооцно."

*Тайлбар:* Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжааны дараа төлбөрт горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын үйл ажиллагааг Үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг олон улсын нийтлэг жишиг, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гаргасан зарчмууд, зах зээлийн нөхцөл байдал болон өөрийн орны онцлогтой нийцүүлэн сайжруулсан.

#### **22/45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг:**

"45.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаас хадгалуулагчийн өмчлөл дэх үнэт цаасны ногдол ашиг болон үнэт цаас худалдсаны төлбөрийг банкин дахь харилцагчийн мэдүүлсэн дансанд шилжүүлнэ."

*Тайлбар:* Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн үндсэн чиг үүрэг нь үнэт цаас гаргагч болон бусад оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх тул "мөнгөн хөрөнгө хадгалах эрхгүй" гэдэг хэсгийг хасах шаардлагатай болсон.

#### **23/45 дугаар зүйлийн 45.9 дэх хэсэг:**

"45.9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь нийтэд болон хаалттай хүрээнд худалдахаар санал болгосон үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн санд бүртгэнэ."

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээл нь биржийн болон биржийн бус зах зээлээс бүрдэж байгаа бөгөөд нийтэд санал болгон биржийн зах зээл дээр, эсхүл нийтэд санал болголгүйгээр хаалттай хүрээнд биржийн бус зах зээлд үнэт цаас гаргаснаас үл хамаараад үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь аливаа үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийг шаардлагатай.

#### **24/48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг:**

"48.2. Клирингийн үйл ажиллагааг тухайн арилжааг зохион байгуулж байгаа байгууллагаас өөр байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд уг байгууллагыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хөрөнгийн биржийн арилжаанд оролцсон гэж үзэхгүй."

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэл, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд "хөрөнгийн бирж" гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага" гэж өөрчлөн тусгаж байгаатай холбогдуулан тус заалтыг өөрчлөн найруулсан.

#### **25/54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг:**

"54.1. Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ."

**Тайлбар:** Санхүүгийн тайланд аудит хийлгүүлэн ирүүлэхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд багтахгүй байх бэрхшээл гарч байсан тул холбогдох өөрчлөн найруулсан.

#### **26/63 дугаар зүйлийн 63.1.19 дэх заалт:**

"63.1.19. энэ хуулийн 9.3-т заасан үнэт цаасыг бүртгэх;"

**Тайлбар:** Нийтэд санал болгон үнэт цаас гаргасан, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргахад Хороонд бүртгүүлэх зохицуулалтыг тусгасан. Олон нийтийн өмчлөлтэй, олон нийтээс хөрөнгө татсан үнэт цаас гаргагчийн хувьд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц шийдвэр гаргах буюу хаалттай хүрээнд үнэт цаас гаргах нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн эрх ашигтай холбоотой асуудал. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгө, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус заалтыг нэмж тусгасан.

**4 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын "хугацаа дуусмагц" гэснийг "нөхцөлийн дагуу" гэж, мөн зүйлийн 4.1.11 дэх заалтын "гэрээний талуудад үүсгэх гэрээ буюу" гэснийг "үүсгэдэг" гэж, мөн зүйлийн 4.1.21 дэх заалтын "мэдээллийн" гэснийг "нийгмийн цахим сүлжээ, мэдээлэх" гэж, 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтын "Аймаг" гэснийг "Засгийн газар,

аймаг" гэж, мөн зүйлийн 5.2.2 дахь заалтын "зохицуулалттай" гэснийг "үнэт цаасны" гэж, мөн зүйлийн 5.2.4 дэх заалтын "банкнаас гаргасан" гэснийг "энэ хуулийн 5.1.11-т зааснаас бусад" гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн ", эсхүл" гэснийг "болон" гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх заалтын, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн зүйлийн 17.1 дэх хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.6.2, 42.6.3 дахь заалтын "хөрөнгийн биржид" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад" гэж, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн гарчгийн "Хөрөнгийн биржид" гэснийг "Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад" гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Компанийн" гэснийг "Үнэт цаас гаргагчийн" гэж, мөн зүйлийн 9.16 дахь хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн "хөрөнгийн биржийн" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын" гэж, 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийн "Санхүүгийн зохицуулах хороонд" гэснийг "Хороонд" гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн, мөн зүйлийн 10.5.9 дэх заалтын "арилжих" гэснийг "худалдах" гэж, 10 дугаар зүйлийн 10.9.9 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 56.2.8 дахь заалтын "хөрөнгийн биржээс" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "зохицуулалттай этгээдтэй" гэснийг "андеррайтертэй" гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн "арилжсан" гэснийг "худалдсан" гэж, мөн зүйлийн 12.8 дахь хэсгийн "зах зээлийн арилжааг" гэснийг "зах зээлд худалдах ажиллагааг" гэж, мөн зүйлийн 12.9 дэх хэсгийн "арилжаанаас" гэснийг "анхдагч зах зээлээс" гэж, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн, мөн зүйлийн 49.1.4 дэх заалтын, 55 дугаар зүйлийн 55.1.4 дэх заалтын, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийн "хөрөнгийн бирж" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага" гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын "арилжааны тооцооны" гэснийг "клирингийн" гэж, мөн зүйлийн 24.1.8 дахь хэсгийн "арилжааны төлбөрийн" гэснийг "төлбөр тооцооны" гэж, мөн зүйлийн 24.7 дахь хэсгийн "24.1.14" гэснийг "-24.1.5, 24.1.14" гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн "Зохицуулалттай" гэснийг "Энэ хуулийн 24.1.1-24.1.14-д заасан зохицуулалттай" гэж, мөн зүйлийн 35.5 дахь хэсгийн "шалгаруулалтыг" гэснийг "шалгаруулалт, мэргэжилтэнд зориулсан үргэлжилсэн сургалтыг" гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн "стандарт нөхцөл, гэрээ байгуулах журмыг" гэснийг "нөхцөл, түүнд тавигдах шаардлагыг" гэж, мөн зүйлийн 36.15 дахь хэсгийн "олгосноос" гэснийг "олгох, харилцагчийн болон брокерийн номиналь данс хоорондын шилжүүлгээс" гэж, 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн "оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч" гэснийг "оруулагч" гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн "болон" гэснийг "хөтлөх эрхтэй ба" гэж, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн "цаасыг" гэснийг "цаасны тухайлсан бүртгэл хөтөлж," гэж, 47 дугаар зүйлийн 47 дугаар зүйлийн 47.2, 47.3, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 49.2, 49.3 дахь хэсгийн, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн "Хөрөнгийн бирж" гэснийг "Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага" гэж, 47 дугаар зүйлийн 47.4.2 дахь заалтын, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн, 51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн "тооцооны" гэснийг "клирингийн" гэж, 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийн, 48 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 48.1 дэх хэсгийн, 49 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын "Хөрөнгийн биржийн" гэснийг "Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын" гэж, 54 дүгээр зүйлийн гарчгийн "Аудитийн" гэснийг "Аудитын" гэж, 63 дугаар зүйлийн 63.1.11 дэх заалтын "батлах зөвшөөрөл олгох" гэснийг "батламжлах,



түүнтэй холбоотой нарийвчилсан журмыг тогтоох” гэж, 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийн 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн “бүртгүүлснээр” гэснийг “батламжлуулснаар” гэж тус тус өөрчилсүгэй.

**Тайлбар:** Дээрх хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёоны тодорхойлолтуудыг Хууль тогтоомжийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд нийцүүлэх шаардлагатай байх тул тус хуулийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасныг үндэслэн боловсруулахдаа мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн агуулгад тавигдах шаардлага, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгад тавигдах шаардлага болон Үнэт цаасны цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад заалт нэр томъёотой нийцүүлэх шаардлагатай байсан тул өөрчлөн найруулсан.

**5 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “гэрээний зүйл болох” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “энэ хуулийн 9.2-т зааснаас бусад” гэснийг, мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтын “Компанийн” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2.3 дахь заалтын, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтын “болон эргэлтийн” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “гурван жилийн хугацаагаар” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.4.6 дахь заалтын “өөрийн харилцагчид” гэснийг тус тус хассугай.

**Тайлбар:** Тухайн 5 дугаар зүйлд заасан заалтууд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-т “зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх”, 29.1.3-т “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх”, 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих”, 32.1-т “Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ.” гэж тус тус заасан заалтад нийцэхгүй байх тул хассан болно.

**6 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28, 4.1.32, 4.1.33 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5.16 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Тайлбар:** 1/ 4 дүгээр зүйлийн 4.1.28, 4.1.32, 4.1.33 дахь заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4-т заасан нэр томъёо нь “олон утгатай бол, нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол, шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй” зэрэгт заасан шаардлага, нөхцөлд нийцэхгүй байна

Түүнчлэн 4.1.28 дахь заалтад тусгагдсан Хөрөнгийн бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д зааснаар арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гэж тодорхойлогддог бөгөөд одоо байгаа хуулийн нэршлээр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг зөвхөн

арилжаа эрхлэх байгууллага мэтээр зах зээл дээр ойлгогдож төөрөгдөл үүсгэж буй тул хасах нь зүйтэй юм.

2/ 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтын тухайд Хороо нь үнэт цаас бүртгэх, зөвшөөрөл олгох асуудлыг нэг тогтоолооо гаргадаг тул хууль дээр тусдаа зохицуулалт байх шаардлагагүй гэж үзсэн.

3/ 10.5.16 дахь заалтын тухайд Хорооны журмаар хөрөнгийн үнэлгээний тайлан шаардахаа больсон бөгөөд бизнесийн үнэлгээг андеррайтер нь хийдэг практиктай. Түүнчлэн хөрөнгийн үнэлгээний тайлан нь хэрэглээ талаасаа хэрэг болохгүй ч үнэт цаас гаргагчийн зардлыг нэмэгдүүлдэг үр ашиггүй

4/ 12.2. Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгоно.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 20.. оны .. сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

---

## **1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

### **1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:**

“6.5.Энэ хуулийн 4.1.3-д заасан хөрөнгө оруулалтын сан нь зөвхөн хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх бөгөөд тухайлсан сангийн төрөлгүй байна.”

***Тайлбар:** Хуулийн 6.2.2-д заасан зохицуулалтыг өөрчлөн найруулсантай холбоотойгоор тус зохицуулалтыг 6.5 дахь заалт болгон, олон улсын жишгийн дагуу хувийн хөрөнгө оруулалтын санг тодорхой сангийн төрөлгүй байхаар зохицуулсан.*

*Олон улсад хувийн хөрөнгө оруулалтын сан нь хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлэх, сангийн хөрөнгө оруулах хэрэгсэл нээлттэй байснаар мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчийн хувьд санхүүгийн зах зээл дээр урт хугацаат хямд өртөгтэй санхүүжилтийг нийлүүлэх, ингэснээр хувийн хэвшлийн компаниуд урт хугацааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ашигтай ажиллах, эдийн засаг тэлэх, татварын орлогыг нэмэгдүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг.*

### **2/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3.Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацааг Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 10.1-д заасан хугацаагаар нэг удаа сунгаж болно.”

***Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангуудыг урт хугацаанд тогтвортой ажиллуулах, иргэдэд ашиг, өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сангуудын үйл ажиллагаа явуулах хугацааг нэг удаа сунгах боломжийг үүсгэх шаардлага тулгарсан. Хөрөнгө оруулалтын сангуудын хийсэн зарим урт хугацааны төсөл хөтөлбөрүүд нь 10 жилдээ зарим тохиолдолд багтаж үр ашгаа өгөх боломжгүй тул хугацааг сунгах шаардлага үүсдэг.*

### **3/14 дүгээр зүйлийн 14.16, 14.17 дахь хэсэг:**

“14.16.Хороо энэ хуулийн 14.4-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэж ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

***Тайлбар:** Санхүүгийн зохицуулах хороо нь ажлын ачааллаас шалтгаалан зарим тохиолдолд санг үүсгэн байгуулах хүсэлтийг шийдвэрлэхэд урт хугацаа шаардаж байгаа нь үүсгэн байгуулагч этгээдэд тодорхойгүй байдал үүсгэх, шат дамжлага, зардал нэмэгдүүлэх эрсдэлтэй байх хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг тодорхой болгож өгсөн.*

14.17.Энэ хуулийн 14.16-д заасны дагуу Хороо хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд нь санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

*Тайлбар: Санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал өдөр, цаг, минутаар хурдан хувьсан өөрчлөгддөг. Иймд санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороо бүртгэснээс хойш тодорхой хугацааны дотор сангийн үүсгэн байгуулах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчдыг хугацааны төөрөгдөлд оруулах, хөрөнгө оруулалтын алдаатай шийдвэр гаргахаас сэргийлэх давуу талтай.*

**4/14<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“14<sup>1</sup> дүгээр зүйл.Хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах**

14<sup>1</sup>.1.Хувийн хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд гэрээний үндсэн дээр байгуулж болно.

14<sup>1</sup>.2.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхгүй байна.

14<sup>1</sup>.3.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна:

14<sup>1</sup>.3.1.нэгж эрх эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага;

14<sup>1</sup>.3.2.нэгж эрх гаргах, худалдах, худалдан авах, арилжих зохицуулалт;

14<sup>1</sup>.3.3.нэгж эрхийн үнэ тогтоох, цэвэр хөрөнгийн үнэлгээний тооцоолол;

14<sup>1</sup>.3.4.кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлага;

14<sup>1</sup>.3.5.сангийн үйл ажиллагааг сурталчлахад тавих хязгаарлалт;

14<sup>1</sup>.3.6.бусад.

14<sup>1</sup>.4.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч нь санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр сангийн үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

14<sup>1</sup>.5.Энэ хуулийн 14<sup>1</sup>.1-т заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, үйл ажиллагаа, гэрээнд тавигдах шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.”

*Тайлбар: Олон улсын санхүүгийн зах зээлд хувийн хөрөнгө оруулалтын сангууд нь ихэвчлэн гэрээний хэлбэртэй үүсгэн байгуулагддаг нийтлэг жишигтэй бөгөөд дотоодын зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан*

төвлөрүүлж, тэдгээрийн хөрөнгийг мэргэжлийн түвшинд удирддаг хувийн ХОС-г бий болгох шаардлагын улмаас гэрээний хэлбэртэй сангийн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлага тулгарсан.

Одоогийн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хувийн ХОС нь хамтын ХОС-тай адил Тусгай зориулалтын компани хэлбэртэй байгаа нь компани үүсгэн байгуулах, дүрмийг батлах, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг цаг хугацаа шаардсан ажиллагаа шаардагдаж байна. Иймд гэрээний хэлбэртэй сангуудыг бий болгосноор санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулснаар уян хатан, хялбар шуурхай болно.

#### **5/19 дүгээр зүйлийн 19.14 дэх хэсэг:**

“19.14.Хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор сангийн нэгж эрхийн танилцуулгыг холбогдох баримт бичгийн хамт Хороонд бүртгүүлэхээр ирүүлэх бөгөөд хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш Хороо ажлын 20 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэж ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.”

**Тайлбар:** Санхүүгийн зохицуулах хороо нь ажлын ачааллаас шалтгаалан зарим тохиолдолд санг үүсгэн байгуулах хүсэлтийг шийдвэрлэхэд урт хугацаа шаардаж байгаа нь үүсгэн байгуулагч этгээдэд тодорхойгүй байдал үүсгэх, шат дамжлага, зардал нэмэгдүүлэх эрсдэлтэй байх хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг тодорхой болгож өгсөн.

#### **6/21 дүгээр зүйлийн 21.2.10 дахь заалт:**

“21.2.10.сангийн нэгж эрхийг зээлээр олгох.”

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сан нь сангийн нэгж эрхийг хөрөнгө оруулагчдад санал болгон хөрөнгө татан төвлөрүүлж, уг хөрөнгөөр мэргэжлийн хөрөнгө оруулалт хийж ашигтай ажиллан, нэгж эрх эзэмшигчдэд ашиг хүртээх ёстой.

Мөн сангийн нэгж эрх эзэмшигчид бүгд адил тэгш эрхтэй байх үүднээс сангийн нэгж эрхийг зээлээр олгох, сангийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, үр ашигтай байдлыг хангах зорилгоор тус зохицуулалтыг оруулсан.

#### **7/26 дугаар зүйлийн 26.1.13, 26.1.14 дэх заалт:**

“26.1.13.хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах хэрэгслийг нэмэгдүүлж, зарим хэрэгслийг тодотгож өгсөн.

26.1.14.хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан бусад санхүүгийн хэрэгсэл.”

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах хэрэгслийг нэмэгдүүлж, зарим хэрэгслийг тодотгож өгсөн.

### **8/30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалт:**

“30.1.7.хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсны улмаас тухайн сан цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.”

**Тайлбар:** Энэ хуулийн 14.3.3-д ХОС нь үүсгэн байгуулагч нь тухайн хөрөнгө оруулалтын сантай хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байх; гэж заасан тул ХОМК нь тусгай зөвшөөрөл хүчингүй болсон нөхцөлд ХОС үйл ажиллагаа явуулах боломжгүй болж болно.

### **9/39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалт:**

“39.4.5.сангийн цэвэр активын үнэлгээг кастодиан гүйцэтгэсэн тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани давхар хяналт тавих.”

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн зах зээлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активын үнэлгээг хөрөнгө оруулалтын менежментийн компаниас гадна тухайн сантай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодиан тооцоолдог жишиг байдаг. Энэ тохиолдолд тухайн сангийн цэвэр активын үнэлгээг үнэн зөв, бодитой тооцоолж буй эсэхэд сангийн хөрөнгийг удирдаж буй хөрөнгө оруулалтын менежментийн компани нь байнгын хяналт тавих шаардлагатай болдог. Ингэснээр хөрөнгө оруулалтын сангийн үнэлгээ зах зээлийн ханшаар бодитой тогтоож, хөрөнгө оруулагч, олон нийт үнэн зөв мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой болох чухал ач холбогдолтой.

### **10/39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэг:**

“39.8.Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх зааврыг Хороо нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.”

**Тайлбар:** Журам, заавар батлах эрх байхгүй байсан тул хуульд тодорхой тусгах шаардлагатай.

### **11/44<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“44<sup>1</sup> дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага**

44<sup>1</sup>.1.Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.1.1.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

44<sup>1</sup>.1.2.энэ хуульд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

44<sup>1</sup>.1.3.энэ хуулийн 44.5-д заасан хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбоотой журамд заасан шаардлагыг хангасан байх;

44<sup>1</sup>.1.4.сангийн хөрөнгөөр арилжаа хийх, брокерт захиалга өгөх, брокерын баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх Хорооноос тогтоосон тусгай нөхцөл шаардлагыг хангасан программ хангамжтай байх.

44<sup>1</sup>.2.Энэ хуулийн 44<sup>1</sup>.1.1-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

44<sup>1</sup>.3.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.3.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани гурваас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

44<sup>1</sup>.3.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

44<sup>1</sup>.3.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

44<sup>1</sup>.3.2.2.банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн байх;

44<sup>1</sup>.3.2.3.тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитын компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх;

44<sup>1</sup>.3.2.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.”

*Тайлбар: Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байсан тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл шаардлагыг энэ хууль руу нэмж оруулан зохицуулах шаардлага үүссэн.*

#### **12/46 дугаар зүйлийн 46.1.10-46.1.12 дахь заалт:**

“46.1.10.сангийн удирдлага нь хувийн ашиг сонирхлын үүднээс сангийн хөрөнгийг зарцуулах, удирдлагын зардлыг үндэслэлгүй хэтрүүлэх;

46.1.11.сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийг төвлөрүүлэх;

46.1.12.сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, сангийн гишүүдийн хурлын зардал, хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ болон гүйцэтгэлийн урамшууллаас бусад төлбөр, хураамжийг сангийн хөрөнгөөс гаргах.”



**Тайлбар:** Зохицуулалтыг сайжруулан нэмж найруулсан.

**13/55 дугаар зүйлийн 55.1.11-55.1.13 дахь заалт:**

"55.1.11.биржээр арилжаалагддаг сангийн төрөлтэй хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг батлах;

**Тайлбар:** Олон улсад өргөн хүрээнд ашиглагддаг хамтын сангийн нэг төрөл болох биржээр арилжаалагддаг сангийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалтын орчныг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр энэ төрлийн хамтын сангууд бий болж, шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэн зах зээл идэвхжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо сайжрах чухал ач холбогдолтой. Үүнтэй холбогдуулан Хороонд санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтоосон журмыг батлах эрхийг хуульд тусгах шаардлагатай байна.

55.1.12.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мэдээлэх журмыг батлах;

**Тайлбар:** Одоогийн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар ХОМК нь ХОС-г үүсгэн байгуулж, сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гүйцэтгэх зохицуулалттай байгаа хэдий ч, ХОМК болон ХОС-ийн хооронд гарч болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэхтэй холбоотой харилцаа хуульд дутмаг туссан байгаа нь учир дутагдалтай байна. Олон улсын нийтлэг жишгийн дагуу ХОМК нь аливаа сонирхлын зөрчлийн талаар нийтэд мэдээлж, хөрөнгө оруулагчдын бодит, үнэн зөв мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах боломжийг олгодог. Иймд үүнтэй холбоотой журмыг тогтоох эрхийг Хороонд олгох заалтыг хуулийн тусгах шаардлагатай.

55.1.13.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг батлах."

**Тайлбар:** Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулагдах санхүүгийн үйлчилгээ, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийг зохицуулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно." гэж заасан шаардлагыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулах хороо нь "Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журам" батлах эрхийг хуульд тусгайлан заах шаардлага үүссэн.

**2 дугаар зүйл.** Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн "компани" гэсний дараа ", эсхүл Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд" гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн "бүртгэлийн" гэсний дараа "болон хөрөнгө оруулалтын сангийн төрөл, түүний үйл ажиллагааны онцлогтой холбоотой нарийвчилсан" гэж, мөн зүйлийн 14.7.2 дахь заалтын "хөрөнгийн" гэсний дараа "доод" гэж, мөн зүйлийн 14.13 дахь хэсгийн "байгууллага" гэсний дараа "хуулийн этгээдийн хэлбэртэй" гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын "эрхлэх" гэсний дараа ", сангийн хөрөнгийг зарцуулах" гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн "эрхийн" гэсний дараа "өмчлөх эрхийг" гэж, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтын "нээлттэй" гэсний өмнө "Монгол Улсын болон гадаад улсын" гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн "Тухайн" гэсний дараа "хамтын", 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "шалгуурыг" гэсний дараа "хамтын" гэж тус тус нэмсүгэй.

*Тайлбар: 1/Олон улсын санхүүгийн зах зээлд хувийн хөрөнгө оруулалтын сангууд нь ихэвчлэн гэрээний хэлбэртэй үүсгэн байгуулагддаг нийтлэг жишигтэй бөгөөд дотоодын зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж, тэдгээрийн хөрөнгийг мэргэжлийн түвшинд удирддаг хувийн ХОС-г бий болгох шаардлагын улмаас гэрээний хэлбэртэй сангийн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлага тулгарсан.*

Одоогийн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хувийн ХОС нь хамтын ХОС-тай адил ТЗК хэлбэртэй байгаа нь компани үүсгэн байгуулах, дүрмийг батлах, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг цаг хугацаа шаардсан ажиллагаа шаардагдаж байна. Иймд гэрээний хэлбэртэй сангуудыг бий болгосноор санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулснаар уян хатан, хялбар шуурхай болох бөгөөд хуулийн төсөлд гэрээний үндсэн дээр байгуулах хөрөнгө оруулалтын сан, түүнийг бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

2/ Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө учир хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, зарцуулах асуудлууд нарийвчлан зохицуулагдсан байдаг. Иймд хуулийн төслийн 21.2.1-д сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглуулахгүй байх үүднээс зохицуулалтыг сайжруулсан.

3/ Кастодианы эрхлэх үйл ажиллагааг хуульд тодорхой тусгаснаар олон улсын кастодиан банкуудад тавигддаг хууль тогтоомжийн тодорхой байдал сайжирна.

4/ Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах хэрэгслийг нэмэгдүүлж, зарим хэрэгслийг тодотгож өгсөн. Ингэснээр сангийн үйл ажиллагаа өргөжих, мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нэмэгдэх ач холбогдолтой.

5/ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь анх батлагдахдаа хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг "Сан" гэсэн ерөнхий нэршлээр нийтлэг адилхан зохицуулсан байдаг. Энэхүү одоогийн зохицуулалт хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг хязгаарлаж, хэт их зохицуулалтад оруулснаар үйл ажиллагаа хумигдах, зохицуулалтын шаардлагыг хангах цаг хугацаа, зардлыг нэмэгдүүлж байгаа тул хувийн болон хамтын сангийн зохицуулалтыг ялгаатайгаар зохицуулах шаардлага үүссэн.

**3 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалт:**

“4.1.1.“хөрөнгө оруулалтын сан” гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлэх санг;

**Тайлбар:** Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, давхардал, хийдлийг арилгах зорилтын хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд давхарлан зохицуулагдаж байсныг нэгтгэн зохицуулсан. Энэ хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тодорхойлолтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиас хасаж үндсэн хуульд нь нэгтгэсэн.

4.1.2.“хамтын хөрөнгө оруулалтын сан” гэж нэгж эрхээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгон хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын санг;”

**Тайлбар:** Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлж, гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоог өсгөх хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд хэрэглэгддэг хамтын сангийн шинэ төрөл болох “биржээр арилжаалагддаг сан”-г үүсгэн байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх шаардлага үүссэн. “Биржээр арилжаалагддаг сан”-ийн төрөлтэй хамтын санг үүсгэн байгуулахад анхдагч зах зээл дээр нэгж эрхээ санхүүгийн хэрэгслээр солилцдог. Тус сангууд нь ихэвчлэн индексийн сангууд байдаг бөгөөд мэргэжлийн оролцогч /authorised participant/ нь индекст багтдаг санхүүгийн хэрэгслийг санд худалдаж, нэгж эрх оронд нь авдаг. Иймд дээрх хамтын сангуудыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлтийг оруулах шаардлага үүссэн.

**2/4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт:**

“4.1.11.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;”

**Тайлбар:** ҮЦЗЗТХ-иас хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн зохицуулалтыг салгаж Хөрөнгө оруулалтын сангийн үндсэн хууль руу нэгтгэж байгаагаар холбоотойгоор ҮЦЗЗТХ-ийн 4.1.33 дахь заалтад “хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд.” гэж заасан Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тодорхойлолтыг оруулсан.

**3/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:**

“6.2.Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дараах төрөлтэй байна:

6.2.1.нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг нээлттэй;

**Тайлбар:** ҮЦЗЗТХ-иас хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн зохицуулалтыг салгаж Хөрөнгө оруулалтын сангийн үндсэн хууль руу нэгтгэж байгаатай холбоотойгоор ҮЦЗЗТХ-ийн 38 дугаар зүйлийг Хөрөнгө оруулалтын сангийн хуульд нэгтгэн зохицуулж байгаа тул 6.2.1-6.2.2 дахь заалтуудыг тус тус дэлгэрүүлэн хуулийн зохицуулалтыг сайжруулан өөрчлөн найруулсан.

6.2.2.үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй хаалттай;

**Тайлбар:** Хувийн хөрөнгө оруулалтын сан нь ихэвчлэн хамтын ХОС шиг аливаа төрөлгүй байдаг тул олон улсын нийтлэг жишиг, өөрийн орны онцлог нийцүүлж, хувийн ХОС-г үүсгэн байгуулахад тавих нөхцөл, шаардлагыг хялбаршуулж, уян хатан болгох шаардлага тулгарч байгаа тул тус заалтаар хувийн хөрөнгө оруулалтын санг хязгаарлаж байсныг болиулсан.

6.2.3.үүсгэн байгуулагчаас сангийн нэгж эрхээ зохицуулалттай этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслээр солих замаар сангийн активаа бүрдүүлдэг, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр нэгж эрх нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг /цаашид “биржээр арилжаалагддаг сан” гэх/;

**Тайлбар:** Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлж, гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоог өсгөх хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд хэрэглэгддэг хамтын сангийн шинэ төрөл болох “биржээр арилжаалагддаг сан”-г үүсгэн байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Уг төрлийн хамтын сангууд дотоодын зах зээлд бий болох суурь нөхцөлийг бүрдүүлснээр мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчид болох хамтын сангуудын тоо өсөх, тэдгээрийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэх, улмаар гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж эхлэх чухал ач холбогдолтой болно.

#### **4/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:**

“7.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.”

**Тайлбар:** Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор олон улсад түгээмэл хэрэглэгддэг “Гэрээний хэлбэртэй” хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг энэ хуульд

шинээр тусгаж байгаатай холбоотойгоор энэ заалтыг өөрчлөн найруулж сайжруулсан.

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор олон улсад түгээмэл хэрэглэгддэг "Гэрээний хэлбэртэй" хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг энэ хуульд шинээр тусгаж байгаатай холбоотойгоор энэ заалтыг өөрчлөн найруулж сайжруулсан.

#### **5/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

"14.1.Хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон Хорооноос зөвшөөрсөн бусад хуулийн этгээд үүсгэн байгуулна.

**Тайлбар:** Олон улсын санхүүгийн зах зээлд ХОС-г зөвхөн ХОМК үүсгэн байгуулдаггүй бөгөөд хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах идэвх, сонирхолтой аж ахуйн нэгжүүд ХОС-г үүсгэн байгуулж, сангийн хөрөнгөө мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх ХОМК-уар удирдуулдаг. Энэ хүрээнд дотоодын зах зээлд ХОС-г Хорооноос тогтоосон этгээд үүсгэн байгуулдаг нөхцөлийг бүрдүүлэх шаардлага үүссэн.

#### **6/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:**

"16.1.Хөрөнгө оруулалтын сан нь сангийн төрөл, хэлбэрээс үл хамааран дараах зүйлийг тусгасан дүрэмтэй байна:

16.1.1.сангийн нэр, төрөл, хэлбэр болон түүнийг тодорхойлсон, товчилсон ялгах тэмдэглэгээ;

16.1.2.сангийн зарласан болон гаргасан нэгж эрхийн тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

16.1.3.хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээрийн бүрэн эрх;

16.1.4.сангийн гишүүдийн хурал болон нэгж эрх эзэмшигчийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт;

16.1.5.сангийн хөрөнгө оруулалтын бодлого, үйл ажиллагааны чиглэл;

16.1.6.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн нэр, регистрийн дугаар;

16.1.7.кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар;

16.1.8.хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа;

16.1.9.хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээ;

16.1.10.хувийн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгө оруулалтыг санхүүгийн хэрэгслээр оруулж болох эсэх, оруулах бол тухайн хэрэгслийг үнэлэх зарчим, аргачлалын тухай;

16.1.11.хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа дуусгавар болж хөрөнгийг хөрөнгө оруулагчдад бүрэн хуваарилж дууссан тохиолдолд татан буугдах тухай болон татан буулгах ажиллагааны журам;

16.1.12.бусад.”

**Тайлбар:** Компанийн тухай хуулийн зохицуулалт нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн зөвхөн 2 төрлийн компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг голчлон зохицуулдаг бөгөөд Тусгай зориулалттай компанийн зохицуулалт тусгагдаагүй байна. Үүнтэй холбоотойгоор Тусгай зориулалт хэлбэртэй ХОС-ийн дүрэм нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компанийн дүрэмтэй ижилхэн зохицуулагдах боломжгүй тул Тусгай зориулалтын компанийн хэлбэртэй сангийн дүрэмд хамааралгүй заалтуудыг хасаж өөрчлөн найруулж, зохицуулалтыг сайжруулсан.

**7/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:**

“19.3.Хамтын хөрөнгө оруулалтын сангийн тухайд сангийн нэгж эрхийн танилцуулга, түүнийг хөрөнгө оруулагчид танилцуулах, сангийн нэгж эрхийг худалдах ажиллагааны журмыг Хороо батална.”

**Тайлбар:** Захиргааны тухай хуульд нийцүүлэн “...журмыг Хороо тогтооно” гэсэн зохицуулалтыг “...журмыг Хороо батална” гэж өөрчилсөн.

Мөн хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийтэд болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад нэгж эрх гаргах боломжтой тул “...нэгж эрхийг нийтэд танилцуулах” гэсэн заалтыг “... нэгж эрхийг хөрөнгө оруулагчдад” гэж өөрчлөн ерөнхий байдлаар зохицуулснаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх цар хүрээг уян хатан, сонголттой олгох ач холбогдолтой.

**8/19 дүгээр зүйлийн 19.13.3 дахь заалт:**

“19.13.3.нээлттэй төрлийн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийт гаргасан нэгж эрхийн гуравны хоёр буюу түүнээс дээш хэмжээний нэгж эрхийг тухайн санд буцаан худалдсан;”

**Тайлбар:** Хуулийн өмнөх зохицуулалт нь “... худалдахаар захиалга өгсөн” гэж байсныг “худалдсан” буюу тухайн үйл ажиллагаа хийгдэж дууссан нөхцөлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зогсоохоор зохицуулсан.

Учир нь санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал нь маш хурдацтай өөрчлөгддөг бөгөөд тухайн үйл ажиллагаа хийгдээгүй, гүйцэтгэгдээгүй байхад сангийн үйл ажиллагааг зогсоох нь хөрөнгө оруулагчдын хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, үнэгүйдүүлэх өндөр эрсдэлтэй.

**9/21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалт:**

"21.2.3.сангийн хөрөнгө оруулагчид ашиг олох болон нэгж эрхээ тодорхой үнэ ханшаар эргүүлэн авах амлалт, баталгаа гаргах, мөнгөн хөрөнгөөр зээл олгох, хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээс хамаарч хууль болон Хорооноос тогтоосон хязгаараас хэтрүүлэн бусдаас зээл авах;"

*Тайлбар: Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглуулахгүй байх үүднээс зохицуулалтыг сайжруулсан.*

#### **10/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:**

"22.1.Хөрөнгө оруулалтын сангийн гишүүний бүртгэлийг тухайн санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани хөтлөх үүрэгтэй ба энэхүү үүргээ кастодианаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно."

*Тайлбар: Кастодианы үйл ажиллагаа эрхлэгчид тавигддаг харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зохицуулалтыг нэмсэн.*

#### **11/22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг:**

"22.4.Нэгж эрхийн номиналь эзэмшигч нь гишүүний бүртгэлд бенефициар өмчлөгчийн нэрийг давхар тусгана."

*Тайлбар: Кастодианы үйл ажиллагаа эрхлэгчид тавигддаг харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зохицуулалтыг нэмсэн.*

#### **12/24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг:**

"24.1.Хамтын хөрөнгө оруулалтын сан энэ хуулийн 26.1.1-26.1.3, 26.1.5-26.1.8-д заасан болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно."

*Тайлбар: Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид зах зээл дээр санхүүжилт шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой болох юм.*

Одоогийн хуулийн зохицуулалтаар хамтын хөрөнгө оруулалтын сан нь зөвхөн Засгийн газрын өрийн хэрэгсэл, аймаг нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн[6] дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэсэн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах зах зээлд эерэг нөлөөтэй.

#### **13/44 дүгээр зүйлийн 44.7.1 дэх заалт:**

"44.7.1.үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ;"

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг төлөөлөх ажиллагаа байна.” гэж заасан.

Гэтэл мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.7.1 дэх заалт нь “Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ хуульд заасан үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаатай хавсран эрхэлж болно” гэж заасан нь хуулийн давхардал үүсгэж байна.

Иймд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд “үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ”-ний төрлийг оруулсан.

#### **14/45 дугаар зүйлийн 45.3.2 дахь заалт:**

“45.3.2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.10, 24.1.15-24.1.17-д заасан үйл ажиллагаа эрхлэгч болон түүний холбогдох этгээд нь хүсэлт гаргагч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болох нь тогтоогдсон;”

**Тайлбар:** Хуулийн одоогийн зохицуулалт нь Хороо нь Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэлд хүсэлт гаргагч этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.5, 24.1.10, 24.1.15-24.1.17-д заасан үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй харилцан хамааралтай нь тогтоогдсон гэж заасан.

ҮЦЗЗТХ-ийн 24.1.1, 24.1.2, 24.1.5-д заасан үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай сонирхлын зөрчил үүсэх хэмжээний зөрчил гаргах боломжгүй тул тус заалтуудыг хасаж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 24.1.10, 24.1.15-24.1.17-д заасан этгээдүүдэд тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн.

#### **15/48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг:**

“48.1.Кастодиан нь хууль болон хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр тооцоо гүйцэтгэх, хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг эрхэлнэ.”

**Тайлбар:** Хуулийн тодорхойлолтыг илүү тодорхой, ойлгомжтой байдлаар өөрчлөн найруулж зохицуулалтыг сайжруулсан.

**4 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “хөрөнгөөр” гэснийг “хөрөнгө болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслээр” гэж, 14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтэд” гэснийг



“хөрөнгө оруулагчид” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж” гэснийг “хөрөнгө оруулалт хийж” гэж, мөн зүйлийн 19.11.7 дахь заалтын “Хорооноос тогтоосон” гэснийг “Энэ хуулийн 19.3-т заасан Хорооноос баталсан журамд заасан” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “хөрөнгө оруулах гэрээний үндсэн дээр” гэснийг “хаалттай хүрээнд” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “сан” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол сангийн гишүүдийн хурал/” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “зохицуулалттай” гэснийг “Монгол Улсын болон гадаад улсын үнэт цаасны” гэж, мөн зүйлийн 26.1.6 дахь заалтын “зохицуулалттай” гэснийг “үнэт цаасны” гэж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хөрөнгө” гэснийг “Хамтын хөрөнгө” гэж, 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “татгалзаж болно” гэснийг “татгалзана” гэж, мөн зүйлийн 45.3.1 дэх заалтын “хөрөнгө оруулалтын менежментийн компанийн” гэснийг “хүсэлт гаргагч хуулийн этгээдийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**Тайлбар:** 1/ Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төрөлд “exchange traded fund” de/e “биржээр арилжаалагддаг сан”-ийн төрлийг олон улсын жишигт нийцүүлэн нэмж оруулсантай холбогдуулан санд хөрөнгө оруулах хэрэгслийг нэмж зохицуулж өгсөн.

Уг төрлийн хамтын сангууд дотоодын зах зээлд бий болох суурь нөхцөлийг бүрдүүлснээр мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчид болох хамтын сангуудын тоо өсөх, тэдгээрийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэх, улмаар гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж эхлэх чухал ач холбогдолтой болно.

2/ Мөн хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийтэд болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад нэгж эрх гаргах боломжтой тул “...нэгж эрхийг нийтэд танилцуулах” гэсэн заалтыг “... нэгж эрхийг хөрөнгө оруулагчдад” гэж өөрчлөн ерөнхий байдлаар зохицуулснаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх цар хүрээг уян хатан, сонголттой олгох ач холбогдолтой.

3/ Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хуулийн 44.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын санд менежментийн үйлчилгээ үзүүлэх үндсэн мөн чанартай бөгөөд 19.2 дахь заалт нь хуулийн давхардал үүсгэж байгаа тул зохицуулалтыг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн санд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болгон өөрчилсөн.

4/ Хууль тогтоомжийн зохицуулалтыг сайжруулах, тодорхой болгох хүрээнд “Хорооноос тогтоосон бусад...” гэсэн тодорхойгүй ойлгомжгүй зохицуулалтыг сайжруулан “Энэ хуулийн 19.3-т заасан Хорооноос баталсан журамд заасан” гэж өөрчилсөн. Ингэснээр санг үүсгэн байгуулагч нь сангийн нэгж эрхийн танилцуулгад Хорооноос баталсан журмын хүрээнд асуудлуудаа оруулах, нэмэлт тодорхойгүй зүйлс дахин дахин нэхэгдэхгүй, хугацаа хэмнэх, шат дамжлагыг багасгах ач холбогдолтой.

5/ Хувийн хөрөнгө оруулалтын сан нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхгүй хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг тул энэ тухай хуульд тодорхой зааж өгсөн.

6/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хэлбэрийг өргөжүүлж гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулагдах санг хуулийн төслийн 14<sup>1</sup> дүгээр зүйлд нэмсэн тул тус зохицуулалттай уялдуулан тухайн сангийн хэлбэрээс хамаарч ТЗК хэлбэртэй сангийн тухайд Төлөөлөн удирдах зөвлөл, гэрээний үндсэн дээр байгуулагдсан хувийн хөрөнгө оруулалтын сангийн тухайд сангийн гишүүдийн хурал нь тухайн сангийн багц дүрмийг батлахаар зохицуулсан.

7/ Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах хэрэгслийг нэмснээр хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын эрсдэлээ удирдах, сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг өсгөх боломжийг олгох, мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа өргөн хүрээнд хийх боломж олгох юм.

8/ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь анх батлагдахдаа хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг "Сан" гэсэн ерөнхий нэршлээр нийтлэг адилхан зохицуулсан байдаг. Энэхүү одоогийн зохицуулалт хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг хязгаарлаж, хэт их зохицуулалтад оруулснаар үйл ажиллагаа хумигдах, зохицуулалтын шаардлагыг хангах цаг хугацаа, зардлыг нэмэгдүүлж байгаа тул хувийн болон хамтын сангийн зохицуулалтыг ялгаатайгаар зохицуулах шаардлага үүссэн.

9/ Хуулийн зохицуулалтыг хоёрдмол утгагүй, тодорхой болгох хүрээнд "...татгалзаж болно" гэснийг "татгалзана" гэж өөрчилсөн.

10/ Тусгай зөвшөөрөл олгохоос өмнөх үйл ажиллагаа тул "хөрөнгө оруулалтын менежментийн компани" бус "хүсэлт гаргагч хуулийн этгээд" гэж өөрчилсөн.

**5 дугаар зүйл.** Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх хэсгийн "Компанийн тухай хуульд нийцүүлэн баталсан" гэснийг, 19 дүгээр зүйлийн гарчгийн "нийтээс" гэснийг, мөн зүйлийн 19.1 дэх хэсгийн "нийтээс" гэснийг тус тус хассугай.

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр нь Тусгай зориулалтын компани хэлбэртэй хэдий байгуулагдах боловч ХХК болон ХК-ийн шинж чанараас зарим чанараараа ялгаатай учир сангийн дүрэм нь Компанийн тухай хуульд заасан компанийн дүрэмд заасан зарим заалтууд хамааралгүй болно. Иймд "Компанийн тухай хуульд нийцүүлэн баталсан" гэснийг хассан.

Мөн хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийтэд болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад нэгж эрх гаргах боломжтой тул "нийтээс" гэснийг хассан.

**6 дугаар зүйл.** Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.6 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.3.3 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**Тайлбар:** 1/ Хөрөнгө оруулалтын сангийн тодорхойлолтыг нэр томъёоны хэсэгт тодорхойлсон, түүнчлэн хамтын сангийн үйл ажиллагаа нь зохицуулалттай үйл ажиллагаа бус үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамаарахаар өөрчлөлт хийсэн тул энэ зүйл бүхлээрээ зохицуулалтын зөрчил, давхардал үүсгэхээр байгаа учир хассан.

2/ Хамтын хөрөнгө оруулалтын сангийн мөн чанар нь нээлттэй хувьцаат компанитай ижил байх тул Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтыг хүчингүй болгох өөрчлөлтийг оруулж байгаатай холбоотойгоор Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой заалтыг хассан.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 20.. оны .. сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

## 2. КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.17 дахь хэсэг хэсэг нэмсүгэй.

“46.17.Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг уг журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.”

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлд олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох замаар арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэн нээлттэй хувьцаат компани болсон дотоодын аж ахуйн нэгжүүдийн хувьд холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, хариуцлага нь нэмэгддэг олон улсын жишигтэй. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилахтай холбоотой чиг үүрэг тухайлан тусгаагагүй байгаагаас шалтгаалан жижиг хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа цаг хугацаанд нь авахгүй байх асуудал үүсэж ирсэн.

2 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “гаргасан” гэсний дараа “барьцаа,” гэж нэмсүгэй.

**Тайлбар:** Дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гарган шаардлагатай санхүүжилтээ татах бололцоог нэмэгдүүлэх хүрээнд үнэт цаас гаргахад тавих шаардлага, нөхцөлийг хөнгөвчлөх, зарцуулагдах цаг хугацаа, өртгөийг багасгах зэрэг хэрэгцээ үүссэн. Энэ хүрээнд дотоодын аж ахуйн нэгжүүд гуравдагч этгээдийн барьцаатай компанийн өрийн хэрэгсэл гаргах бололцоотой болгосноор шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, бондын зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлнэ.

3 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### 1/3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсэг:

“3.9.Хөрөнгө оруулалтын сан нь тусгай зориулалтын компани хэлбэртэй байна. Уг хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.”

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын сан нь тусгай зориулалтын хэлбэртэй тул Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулснаас бусад компанийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий харилцаа нь Компанийн тухай хуулиар зохицуулагдах шаардлагатай.

#### **2/46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэг:**

“46.14.Хувьцаат компанийн хувьд ногдол ашиг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.”

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлд олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох замаар арилжаа эрхлэх байгууллагад бүртгээгдэн нээлттэй хувьцаат компани болсон дотоодын аж ахуйн нэгжүүдийн хувьд холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, хариуцлага нь нэмэгддэг олон улсын жишигтэй. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилахтай холбоотой чиг үүрэг тухайлан тусгагдаагүй байгаагаас шалтгаалан жижиг хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа цаг хугацаанд нь авахгүй байх асуудал үүсэж ирсэн. Үүнээс улбаалан жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хороонд нээлттэй хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилахтэй холбоотой харилцааг зохицуулсан эрхийг тусгасан.

#### **3/86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэг:**

“86.1.Компанийн хувьцаа эзэмшигч нь дангаараа эсхүл бусад хувьцаа эзэмшигчидтэй хамтран компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.”

**Тайлбар:** Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлэх тохиолдол манай улсын хувьд цөөн байгаа бөгөөд хөрөнгийн зах зээл жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн бүтэцтэй. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нэг хувьцаа эзэмшигч бусад хувьцаа эзэмшигчидтэй хамтран шүүхэд нэхэмжлэл гаргах бололцоотой байхаар тусгасан.

Үнэт цаасны зах зээл дээр жижиг хувьцаа эзэмшигчид нь хувьцааны эзэмших хувь хэмжээ нь дийлэнх хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдээс харьцангуй бага байдаг тул компанийн засаглал, компанийн үйл ажиллагааны шийдвэр гаргалтад нөлөөлөх бага байдаг. Иймд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчдийг нэгдэх, нийлэх замаар өөрсдийн эрх ашгийг хамгаалах боломжийг бий болгож байгаа юм.

**4 дүгээр зүйл.** Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан” гэснийг тус тус хассугай.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зохицуулалттай үнэт цаас буюу санхүүгийн хэрэгсэлд хувьцаат компанийн хувьцааг хамруулсан байдаг бөгөөд компанийн хувьцааны онцлог, ялгаа, эрх хэмжээ зэрэг нь Компанийн тухай хуулиар зохицуулагдаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зөвхөн

олон нийтэд санал болгосон хувьцаат компанийн хувьцаа хамрагдаж байгаа бол Компанийн тухай хуулиар компанийн хэлбэрээс үл хамаараад бүх хувьцааг тодорхойлсон байдаг.

Олон улсын жишгийн дагуу аж ахуйн нэгжүүд компанийн бонд гаргахад санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгох, эсхүл барьцаа, батлан даалт, баталгаатай зэрэг үүргийн гүйцэтгэл хангуулах нэмэлт хөрөнгийн шаардлагыг хангадаг. Харин компани нь өөрийн хөрөнгө буюу хуримтлагдсан ашиг, хувь нийлүүлсэн хөрөнгө, нэмж төлөгдсөн капитал зэргийг барьцаалан өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд олон улсад төдийлөн ашиглагддаггүй бөгөөд үүнээс гадна тухайн компани төлбөрийн чадваргүй болох, санхүүгийн чадавхгүй болох үед хөрөнгө оруулагчид бондын төлбөрөө өгөх боломжгүй болж, татан буугдах зэрэг эрсдэлтэй.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

### **3. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсгийн "арга хэмжээг авахдаа" гэсний дараа "үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаа, төлбөрийн үүргийг тасалдуулах," гэж нэмсүгэй.

**Тайлбар:** IOSCO-н 38-р зарчмын дагуу клирингийн төв нь системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй учраас шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулснаар бид ямар ч арга хэмжээ авах боломжгүй болж дараа дараагийн арилжаанд эрсдэл үүснэ. Иймд энэ хуулийн заалтад нэмж тусгах шаардлагатай.

**2 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн "Төлөөлөгчийн" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчийн" гэж өөрчилсүгэй.

**Тайлбар:** Хэрэв арилжаанд оролцогч төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй эрсдэл үүсвэл арилжаа буцахгүй учраас дээрх олон улсын байгууллагаас гаргасан зарчмын дагуу тооцооны байгууллага эрсдэлийг хааж авсан үнэт цаасыг шууд захиран зарцуулж үүссэн төлбөрийн үүргийг хаах ёстой. Энэ эрхийг хэрэгжүүлэхийн тулд клирингийн төв клирингийн гишүүний өмнөөс төлөөлөх шаардлага үүснэ.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

#### 4. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

##### **1/18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг:**

“18.13. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг энэ хуулийн 18.3-т заасны дагуу тодорхойлно.

*Тайлбар:* ААНОАТТХ-д Монгол Улсад төлөөний газаргүй, оршин суугч бус этгээд нь хувьцаа, үнэт цаас борлуулсны ашгаас бус нийт борлуулсан дүнгээс 20%-ийн суутган татвар төлөхөөр заасан байдгийг нь хувьцаа, үнэт цаас борлуулсны ашгаас болгон өөрчлөхгүй бол гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд зарим тохиолдолд алдагдалд орох эрсдэлийг үүсгэж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх эрсдэлтэй байна. Цаашид зах зээл идэвхижиж гадны хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд оруулах шаардлага үүсэж байгаа энэ үед нэлээн томоохон хэмжээний хаалт болохоор заалт тул өөрчлөн найруулсан.

18.14. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг тодорхойлох, тайлагнах, суутган тооцох, төсөвт төлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална.”

*Тайлбар:* Татварын ерөнхий газар нь хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгслийг борлуулсны орлогын татварын төвлөрүүлэлт хангалтгүй, тооцоход хүндрэлтэй байдаг. Хэдийгээр татварын хуулиудад хөрөнгө борлуулсны орлогод татвар ногдуулахаар зохицуулсан байдаг боловч үнэт цаас борлуулсны орлогод татвар ногдуулж төлсөн тохиолдол хангалтгүй байна. Хөрөнгө оруулагч, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд татвар ногдуулах эсэхээс илүүтэй татварын орчин нь ойлгомжтой, тодорхой байх нь нэн чухал байдаг тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, банкнаас бусад санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий газраас аргачлал арга зүйгээ сайжруулан, бэлтгэлээ хангаж, татвар ногдуулах, бүрдүүлэх ажиллагааг тодорхой болгох хүртэл түр хугацаанд татвар ногдуулахыг хойшлуулах нь зүйтэй байна.

##### **2/24 дүгээр зүйлийн 24.1<sup>1</sup> дэх хэсэг:**

“24.1<sup>1</sup>. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд ногдуулж, суутгана.”

**Тайлбар:** Үнэт цаас борлуулсны орлогод тооцох татварыг тооцоолох нь өөрөө олон улсын стандартын дагуу багцын хөрөнгө оруулалтаас тооцох эсхүл тухайн хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр тооцох, мөн FIFO зарчим буюу эхэнд нь үнэт цаасыг худалдаж авсан үнэт цаасыг эхэнд нь зарах зарчмыг хэрэглэх зэргээс шалтгаалан үнэт цаас борлуулсны орлогыг тооцох нь ярвигтай тул үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага дээрх татварыг ногдуулж, суутгах нь зүйтэй гэж үзсэн.

**2 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын "18.6.8-д" гэснийг "18.6.8, 18.6.13-д" гэж өөрчилсүгэй.

**Тайлбар:** Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох өөрчлөлтийг оруулсан.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг ... оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Аливаа татвар ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийг дараа оны санхүүгийн жил эхлэхэд мөрдөх боломжтой.

## **5. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл болон Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ борлуулсны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2023-2026 онд 90 хувиар, 2027-2030 онд 50 хувиар тус тус хөнгөлсүгэй.

**Тайлбар:** Татварын ерөнхий газрын мэдээгээр хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгслийг борлуулсны орлогын татварын төвлөрүүлэлт хангалтгүй, тооцоход хүндрэлтэй байдаг. Хэдийгээр татвар ногдуулахаар зохицуулсан байдаг боловч татвар ногдуулж төлсөн тохиолдол хангалтгүй байна. Хөрөнгө оруулагч, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд татвар ногдуулах эсэхээс илүүтэй татварын орчин нь ойлгомжтой, тодорхой байх нь нэн чухал байдаг тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, банкнаас бусад санхүүжилтийн тогтолцоог нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий газраас аргачлал арга зүйгээ сайжруулан, бэлтгэлээ хангаж, татвар ногдуулах, бүрдүүлэх ажиллагааг тодорхой болгох хүртэл түр хугацаанд татвар ногдуулахыг хойшлуулах нь зүйтэй байна.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөнгөлөлтөд ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлого хамаарахгүй.

**Тайлбар:** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалттай нийцүүлсэн.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2031 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Аливаа татвар ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийг дараа оны санхүүгийн жил эхлэхэд мөрдөх боломжтой.

## **6. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

**1/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:**

"20.4. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ болон Монгол Улсад бйарладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу тодорхойлно.

**Тайлбар:** ХХОАТХ-д Монгол Улсад оршин суугч бус этгээд нь хувьцаа, үнэт цаас борлуулсны ашгаас бус нийт борлуулсан дүнгээс 20%-ийн суутган татвар төлөхөөр заасан байдгийг нь хувьцаа, үнэт цаас борлуулсны ашгаас болгон өөрчлөхгүй бол гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд зарим тохиолдолд алдагдалд орох эрсдэлийг үүсгэж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх эрсдэлтэй байна. Цаашид зах зээл идэвхижиж гадны хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд оруулах шаардлага үүсэж байгаа энэ үед нэлээн томоохон хэмжээний хаалт болохоор заалт тул өөрчлөн найруулсан.

20.5. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, тайлагнах, суутган тооцох, төсөвт төлөхөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.14-т заасан журмыг баримтална."

**Тайлбар:** Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох өөрчлөлтийг оруулсан.

**2/25 дугаар зүйлийн 25.1<sup>1</sup> дэх заалт:**

"25.1<sup>1</sup>. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагддаг хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд ногдуулж, суутгана."

**Тайлбар:** Үнэт цаас борлуулсны орлогод тооцох татварыг тооцоолох нь өөрөө олон улсын стандартын дагуу багцын хөрөнгө оруулалтаас тооцох эсхүл



тухайн хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр тооцох, мөн FIFO зарчим буюу эхэнд нь үнэт цаасыг худалдаж авсан үнэт цаасыг эхэнд нь зарах зарчмыг хэрэглэх зэргээс шалтгаалан үнэт цаас борлуулсны орлогыг тооцох нь ярвигтай тул үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага дээрх татварыг ногдуулж, суутгах нь зүйтэй гэж үзсэн.

**2 дугаар зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.5 болон 25.1.6 дахь заалтын "20.1-д" гэснийг "20.1, 20.4-д" гэж тус тус өөрчилсүгэй.

**Тайлбар:** Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох өөрчлөлтийг оруулсан.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг ... оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Аливаа татвар ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийг дараа оны санхүүгийн жил эхлэхэд мөрдөх боломжтой.

## **7. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл болон Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/ борлуулсны орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг 2023-2026 онд 90 хувиар, 2027-2030 онд 50 хувиар тус тус хөнгөлсүгэй.

**Тайлбар:** Татварын ерөнхий газрын мэдээгээр хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгслийг борлуулсны орлогын татварын төвлөрүүлэлт хангалтгүй, тооцоход хүндрэлтэй байдаг. Хэдийгээр татвар ногдуулахаар зохицуулсан байдаг боловч татвар ногдуулж төлсөн тохиолдол хангалтгүй байна. Хөрөнгө оруулагч, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд татвар ногдуулах эсэхээс илүүтэй татварын орчин нь ойлгомжтой, тодорхой байх нь нэн чухал байдаг тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, банкнаас бусад санхүүжилтийн тогтолцоог нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий газраас аргачлал арга зүйгээ сайжруулан, бэлтгэлээ хангаж, татвар ногдуулах, бүрдүүлэх ажиллагааг тодорхой болгох хүртэл түр хугацаанд татвар ногдуулахыг хойшлуулах нь зүйтэй байна.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөнгөлөлтөд ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлого хамаарахгүй.

**Тайлбар:** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалттай нийцүүлсэн.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2031 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө. .

**Тайлбар:** Аливаа татвар ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийг дараа оны санхүүгийн жил эхлэхэд мөрдөх боломжтой.

## **8. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

### **1/11.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 12.21 дэх заалт:**

“12.21. Компани, олон улсын санхүүгийн байгууллага нь хуульд зааснаас бусад зах зээлд, буюу бусад арга, хэрэгслийг ашиглаж өрийн хэрэгсэл гаргасан;”

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд компани болон олон улсын байгууллага нь зөвхөн үнэт цаасны зах зээлд буюу биржийн болон биржийн бус зах зээл дээр тус хуульд нийцүүлэн өрийн хэрэгсэл гаргахаар тусгасан.

### **2/11.26 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Хөрөнгө оруулалтын менежментийн компани хуульд заасан нийтлэг үүргээ хэрэгжүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**Тайлбар:** Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8-д заасан нийтлэг үүргүүдийг биелүүлэхээр хуульчилсан. Гэвч хөрөнгө оруулалтын менежментийн компани хуульд заасан эдгээр үүргээ биелүүлэхгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах эсэх талаар зохицуулалт байдаггүй.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 12.2, 12.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар нэмж гаргахдаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлээгүй;

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 9.3 дахь хэсгийг өөрчлөн найруулж буй тул томьёоллыг ижил болгосон. Мөн эрх бүхий байгууллагад гэснийг Санхүүгийн зохицуулах хороонд гэж тодорхой болгосон.

12.3.урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлээгүй;”

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 9.4 дэх хэсгийг өөрчлөн найруулж буй тул томьёоллыг ижил болгосон. Мөн эрх бүхий байгууллагад гэснийг Санхүүгийн зохицуулах хороонд гэж тодорхой болгосон.

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.9 дэх заалтын, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.18, 12.19 дэх заалтын, мөн зүйлийн 13 дахь хэсгийн 13.10 дахь заалтын “хөрөнгийн бирж” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн 7.1 дэх заалтын, мөн зүйлийн 15 дахь хэсгийн 15.2 дахь заалтын “хөрөнгийн бирж,” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага,” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн “Хөрөнгийн бирж” гэснийг “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.7 дахь заалтын, мөн зүйлийн 13 дахь хэсгийн 13.1, 13.2 дахь заалтын “хөрөнгийн биржид” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.20 дахь заалтын “хөрөнгийн биржийн” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын” гэж, 12 дахь хэсгийн “12.21” гэснийг “12.22” гэж, мөн зүйлийн 14 дэх хэсгийн “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хөрөнгийн бирж” гэсэн нэр томьёог “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэж өөрчлөн тусгаж байгаатай холбогдуулан дээрх заалтуудад өөрчлөлт оруулсан.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх хугацааг заасан, харин аудитаар баталгаажуулсан тайланг хүргүүлэх хугацааг Аудитын тухай хуульд заасан байдаг тул дээрх өөрчлөлтийг оруулсан.

**4 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.5, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өмнө нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын сангийн талаарх зарим зохицуулалтуудыг хүчингүй болгож Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмсэн. Иймд хөрөнгө оруулалтын сантай холбоотой зөрчлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих гэсэн хэсгээс хассан.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

## **9. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"22.5.Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг энэ хуулийн 3.1-т заасан үйл ажиллагаа тус бүрийн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиар зохицуулна."

**Тайлбар:** Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай болон Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай зэрэг хуулийн дагуу холбогдох зөвшөөрөл олгож, бүртгэл хийж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль нь 2005 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 22.5 дахь хэсэгт дээрх хуулиуд бүгд тусгагдаагүй, мөн тус Хорооны зохицуулалтын салбар нэмэгдэх болгонд тус заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар байгаа тул агуулгаар нь томьёолж найруулсан.

**2 дугаар зүйл.** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын "мэргэжлийн" гэснийг "зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд" гэж өөрчилсүгэй.

**Тайлбар:** УИХ-аас 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн найруулж баталсан бөгөөд тус шинэчилсэн найруулгыг батлахдаа дагуулж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулаагүй.

2002 оны хуучин хуульд "үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах" гэж туссан нь 2013 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд "үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх" гэж шинэчлэгдсэн тул тус хуулийн агуулгад нийцүүлэн өөрчилсөн.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

## **10. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.5 дахь заалт нэмсүгэй.

*"1.5. Үнэт цаасны арилжааг түр зогсоох, үнэт цаас тусгаарлах."*

*Тайлбар: Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасан дотоод мэдээл эзэмшигч арилжаанд оролцох, үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглаж, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тодорхой түвшинд барих, өсгөх, бууруулах зэрэг зөрчлийг шалган шийдвэрлэхэд тухайн арилжааг түр хугацаанд зогсоох шаардлага үүсдэг.*

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.*

## **11. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "мэргэжлийн" гэснийг "зохицуулалттай" гэж өөрчилсүгэй.

*Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд бусад хууль тогтоомж дээрх нэр томъёоны зарүүтэй байдлыг арилгасан.*

**2 дугаар зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

*Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд бусад хууль тогтоомжийн зөрчлийг арилгасан.*

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.*

## **12. МӨНГӨ УГААХ БОЛОН, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Мөнгө угаах болон, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын "мэргэжлийн байгууллага" гэснийг "зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд" гэж өөрчилсүгэй.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд бусад хууль тогтоомж дээрх нэр томъёоны зарүүтэй байдлыг арилгасан.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

### **13. ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.3.6 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“15.5.3.6.үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд болон мэргэжлийн холбоо;”

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд бусад хууль тогтоомж дээрх нэр томъёоны зарүүтэй байдлыг арилгасан.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

### **14. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийн “мэргэжлийн байгууллагын” гэснийг “зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн” гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн “мэргэжлийн байгууллагаас” гэснийг “зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс” гэж тус тус өөрчилсүгэй.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд бусад хууль тогтоомж дээрх нэр томъёоны зарүүтэй байдлыг арилгасан.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

### **15.НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нотариатын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

**“46.1.8. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагдах замаар өмчлөх эрх шилжихээс бусад тохиолдолд хувьцаа, үнэт цаасыг бусдын өмчлөлд шилжүүлэх гэрээ”**

**Тайлбар:** *Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан биржийн зах зээл дээр арилжаалагдаж буй үнэт цаасны өмчлөх эрх нь үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн цахим системд бүртгэгдэж, арилжааны бүртгэлийн түүх тухай бүр үүсч хадгалагдаж байдаг бөгөөд цахим арилжааны системээр дамжуулан хийгдэж буй олон сая арилжааг тухай бүр нотариатаар баталгаажуулах боломжгүй тул дээрх зохицуулалтыг тусгасан.*

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлд болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тайлбар:** *Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.*

САНГИЙН ЯАМ

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,  
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН  
СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

---

Улаанбаатар хот  
2022 он



---

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад хөрөнгийн зах зээл нь 1990-ээд оны эхэн үед нийгмийн тогтолцоонд эрс шилжилт гарч, хувийн өмч гэх ойлголт дөнгөж бий болсон үе буюу тухайн үеийн өмч хувьчлалтай холбогдон үүссэн. Үнэт цаасны тухай анхны хууль 1994 онд батлагдаж, улмаар зах зээлийг зохицуулж, хяналт тавих төрийн байгууллага болох Үнэт цаасны хороо байгуулагдаж, хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд үүсэх үндэс суурийг тавьсан. Хуулийн анхны зорилго нь иргэдэд өмчийн хуваарилалт хийж, цаашид дахин хуваарилалтыг оновчтой хийх тогтолцоог бий болгоход чиглэж байсан.

Үүнээс хойш Монгол улсын нийгэм, эдийн засаг аажим өссөөр компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаа амжилттай хийгдэж, зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд үүсэж эхэлсэнтэй холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд 2002 онд, үүний дараа дэлхийн санхүүгийн хямралтай холбоотойгоор Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO) -аас гаргасан зарчим, зөвлөмжид тулгуурлан 2013 онд тус тус шинэчилсэн найруулга батлагдан мөрдөгдөж байна.

Одоо мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон түүнээс өмнө мөрдөгдөж байсан хуулиудын зохицуулалт нь зах зээлийн түүхэн хөгжилтэй холбоотойгоор биржийн зах зээл, тэр дундаа компанийн хувьцааны зах зээлийг голчлон зохицуулж байгааг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас 2018 онд хийсэн "Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчны үнэлгээ" төслийн үр дүнгийн тайланд тусгасан байна.

Хууль эрх зүйн орчны чиг хандлага биржийн зах зээлийн зохицуулалт руу илүү төвлөрснөөр зах зээл дээр хөгжих ёстой байсан бусад чухал санхүүгийн хэрэгсэл, тухайлбал компанийн бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, урт хугацаат хөрөнгө оруулалтын сангуудын хөгжил, зохицуулалтууд орхигдсон. Иймд цаашид хөрөнгийн зах зээлийн дээр дурдсан асуудлуудыг сайжруулах, мэргэжлийн оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил сүүлийн жилүүдэд буюу 2015 оноос эхлэн идэвхжиж байгаа бөгөөд үүнийг дагаад зөв зохистой хууль, эрх зүйн орчин болон төрийн бодлого, зохицуулалтыг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байхыг зах зээлийн хөгжил шаардаж байна. Одоогийн мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсанаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Гэвч хөрөнгийн зах зээлийн практикт олон улсын болоод дотоодын хүчин зүйлтэй холбоотойгоор шинээр бий болж буй нөхцөл байдал, зохицуулалтгүй орхигдсон зарим асуудлууд нь хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлтийг хийх шаардлагыг мөн нөхцөлдүүлж байна.

Тухайлбал, санхүүгийн салбарт технологийн дэвшил хурдсаж, санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх үйл явц, шат дамжлага, цаг хугацаа болон зардал багасаж хялбар болж байна. Үүнтэй холбоотойгоор хувийн хэвшлийн зүгээс технологид суурилсан санхүүгийн финтек бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгох үйл явц ихэсч, зохицуулагч байгууллагаас зохих тусгай зөвшөөрлийг авах хүсэлтийг ихээр ирүүлж байна. Гэсэн хэдий ч зохицуулагч байгууллагад энэ талаарх эрх олгосон хууль, эрх зүйн орчин хараахан бүрдээгүй тул хөрөнгийн зах зээл дээрх финтект суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх асуудал хүндрэлтэй байна. Цаашид бодлого боловсруулагч, зохицуулагч байгууллагууд нь зах зээлд шинээр гарч ирж буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого, зохицуулалтын орчныг бий болгох нь зүйтэй байна.

Дээр дурдсан үндэслэлүүдээс гадна Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт 4.3-д “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж заасан. Энэхүү зорилтыг хөгжүүлэх I дүгээр шатанд (2021-2030 он) “Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүн өссөн байна”, II дугаар шатанд (2031-2040 он) “Томоохон хөрөнгийн зах зээл дээр дотоодын бүтээгдэхүүнийг чөлөөтэй арилжаалдаг болсон байна”, III дугаар шатанд (2041-2050 он) “Олон улсад өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлсэн байна” гэсэн үр дүнд хүрэхээр төлөвлөгдсөн байна.

Мөн Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 43-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний зорилго 2.1-д “Хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчныг шинэчилж, зохицуулагч байгууллагын зохицуулалт, хяналтын чадавхыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгана” гэж, мөн 2.1.1-д “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заасан нь уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын<sup>2</sup> /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

## **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол Улсад 1990 онд анх шинээр үүссэн хөрөнгийн зах зээлийн хөгжил сүүлийн жилүүдэд огцом хурдацтай явагдаж буй бөгөөд үүнийг дагаад зөв зохистой хууль, эрх зүйн орчин болон төрийн бодлого, зохицуулалтыг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байхыг шаардаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай анхны хууль 1994 онд батлагдаж, 2002 оноос удаах шинэчилсэн найруулгыг мөрдөж байсан бол одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг 2013 онд шинэчлэн баталж байсан ба баталснаас нь хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэвч хөрөнгийн зах зээлийн практикт олон улсын болоод дотоод орчны хурдацтай өөрчлөлттэй холбоотойгоор зах зээл дээр шинээр хөгжиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд зохицуулалтын орчин тодорхойгүй байгаа нь хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд дотоодын хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдын санхүүгийн боловсрол дээшилж тэр дундаа хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт сайжирч, хөрөнгийн зах зээлийн идэвх сэргэж байна.


Тухайлбал 2021 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөг буюу ДНБ-ны 15.3 хувьтай тэнцэж байна. Хувьцааны хөрвөх чадвар 2016 онд 3.3 хувь байсан бол 2018 онд 8.4 хувьд хүрч сайжирсан ч 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас 1.8 хувь хүртэл буурч, 2021 оноос дахин сэргэн 5.1 хувьд хүрсэн байна.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 2: Арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3: ТОП-20 индекс




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж ТӨХК

Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах хүсэл сонирхол байвч зохицуулалтын орчны тодорхой бус байдал, зах зээл дээр хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүтээгдэхүүн үйлчилгээ бага, хөрөнгө оруулагчдын эрх ашиг бүрэн хамгаалагдаагүй, компанийн засаглал сул, мэдээллийн ил тод байдал байдаггүй зэрэг асуудлуудаас үүдэн хөрөнгө оруулалт хийдэггүй байна.

Тухайлбал, Монголын хөрөнгийн бирж ТӨХК дээр бүртгэлтэй нийт компаниудын хувьцаат компаниудын үүргийн биелэлт буюу санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэр зэрэг хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийн

тайланг харахад 2016-2020 оны хооронд нийт компаниудын 60-75 хувь нь бүрэн бус, хангалтгүй гэсэн үнэлгээтэй байна.

Хүснэгт 2: Хувьцаат компаниудын үүргийн биелэлтийн тайлан



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж ТӨХК

Иймд цаашид Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд олон улсын жишгийн дагуу хөгжүүлэх, ингэхдээ компанийн өрийн хэрэгсэл, мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчдыг зах зээлд бий болгох, зах зээлд оролцогчдыг чадавхжуулах, дэд бүтцийн системийн олон улсын зарчим, стандартуудыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, шинээр хөгжиж буй технологийн дэвшлийг зах зээлд нэвтрүүлэх, финтек бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, түүний эрх зүйн орчныг бий болгох зэрэг асуудлаар одоогийн хууль эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн

бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

#### **1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:**

Сангийн яам 2017 онд нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (цаашид ЕСБХБ гэх )-тай хамтран “Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн үнэлгээ”-ний төслийг хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд богино хугацаанд нэн тэргүүнд яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээний зөвлөмжийг өгсөн. Энэ нь нэгдүгээрт, “Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах”, хоёрдугаарт, “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд Олон улсын төлбөр тооцооны суурь зарчим болох DvP/T+2 буюу Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ Төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 дахь өдөрт гүйцэтгэх” зарчмыг нэвтрүүлэх зөвлөмж юм.

Дээрх 2 зөвлөмжийн дагуу Сангийн яам нь ЕСБХБ-тай хамтран 2018-2019 онд төслийн 2 дугаар үе шатыг эхлүүлж “хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчны үнэлгээ” дэд төслийг хэрэгжүүлж дүгнэлт зөвлөмжийн хураангуй тайланг 2019 оны 2 дугаар сарын 1-ны өдөр хөрөнгийн зах зээлийн оролцогчдод танилцуулан хэлэлцүүлэг хийсэн. Энэхүү хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчны үнэлгээгээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хууль эрх зүйн орчинд дараах шинэчлэл, сайжруулалтыг хийх хэрэгтэй гэж үзсэн. Үүнд:

##### **1. Компанийн бонд гаргалт**

Компанийн бонд зах зээлийн хөгжилд саад учруулж буй, шаардлагагүй хууль эрх зүйн орчны саад тотгорыг арилгах, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр гаргах, зохицуулагч байгууллага болон арилжаа эрхлэгч байгууллагын хаалттай үнэт цаасыг бүртгэх дүрэм журмыг хялбарчлах, ялгаатай тогтоох;

##### **2. Репо болон дериватив хэлцлүүд**

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үүсмэл санхүүгийн хэрэгслүүд болон түүний төрлүүдийг тодорхойлолтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд тусгах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн нөхөн төлөлтийн үеийн үр дүнгийн үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон репо хэлцэлд ашиглагдах стандарт баримт бичгүүдийг бий болгох замаар олон улсын стандартад ойртуулах;

##### **3. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц**

Үнэт цаасны эрхийн бүртгэл, арилжааны төлбөр тооцоог зохицуулж буй хууль, журмуудын хоорондын зөрчлийг арилгах, хаалттай гаргасан үнэт цаасыг бүртгэлжүүлэх, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдод тавигдах үйл ажиллагааны, мэдээллийн технологийн, санхүүгийн болон мэргэжлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан зохистой байдлын шаардлагууд тавих, хяналт хийх;

##### **4. Мэдээллийн ил тод байдал, компанийн засаглал**

Үнэт цаасны танилцуулгыг бодит байдалд тулгуурласан, дэлгэрэнгүй хэлбэртэй болгох, үнэт цаас гаргагчийн материаллаг мэдээллийг нээлттэй өгөх үүргийг нэмэгдүүлэх, үнэт цаас гаргагч сайтар боловсруулсан мэдээлэл ил тод болгох, шаардлагуудыг тусгасан нэгдмэл багц журам гаргах, компанийн засаглалыг сайжруулах хүрээнд зөрчил гаргагчдад ногдуулах хариуцлагыг өндөрсгөх, зайлшгүй ил тод болгох мэдээллийг нийтэд хүргэх төвлөрсөн эрх бүхий платформ бий болгох;

**5. Олон улсын санхүүгийн байгууллагууд бонд гаргах**

Гадаадын хуулийн этгээдүүд болон санхүүгийн олон улсын байгууллагууд бонд гаргаж болох эсэх, түүнд тавигдах шаардлагуудыг тодорхой болгох, үнэт цаасны танилцуулгыг Монгол хэл дээр гаргах зохицуулалт хийх;

**6. Засгийн газар, төрийн байгууллагын өрийн зах зээл**

Түүнчлэн, Сангийн яамнаас 2019.10.09-ний өдөр Санхүүгийн салбарын бодлого боловсруулагчид, зохицуулагч байгууллага, салбарын мэргэжлийн холбоод болон зах зээлд оролцогчдын төлөөллүүдийн хооронд “Банкнаас бусад санхүүгийн салбарыг тэнцвэртэйгээр хөгжүүлэх, түүний өнөөгийн тулгамдсан асуудлуудыг ярилцах, шийдэл гаргах” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт оролцогчид Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд доорх асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй гэдэг дээр нэгдсэн санал дүгнэлтэд хүрээд байна. Үүнд:

- Засгийн газрын дотоод үнэт цаасыг Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.3-д заасан зориулалт буюу Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих зориулалтаар гаргах, зах зээлийн суурь хүүгийн өгөөжийн муруйг тогтоох;
- Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын систем болон төлбөр тооцооны горимыг олон улсын стандартад нийцүүлэн, төлбөрийн эсрэг нийлүүлэлт, дундын зохицуулагч байгууллага, төлбөрийн баталгааны сан, клирингийн гишүүн, төлбөрийн чадваргүйдлийн удирдлагын зохицуулалтыг холбогдох хууль, эрх зүйн орчинд тусгах;
- Санхүүгийн шинэлэг технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын орчныг үүсгэх;
- Зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчид буюу урт хугацаат хөрөнгө оруулагчид бий болгох, ингэхдээ хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх. Одоо байгаа нөөц боломжоо ашиглан хөрөнгийн зах зээлд урт хугацаат хөрөнгө оруулагчийг бий болгох. Хувийн даатгалын сангийн хөрөнгө, нийгмийн даатгал сангийн хөрөнгө, даатгалын компаниудын нөөц санг хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах сувгийг нээж өгөх;
- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, Монголд орж ирэх гадаад валютын урсгалыг дэмжих, дотоодын эдийн засагт дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад валютаар өрийн хэрэгсэл, бонд гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

- Компанийн өрийн хэрэгслийн хаалттай болон нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг хөгжүүлэх, ингэх нь дотоодын хувийн аж ахуйн нэгжүүдэд урт хугацаат хөрөнгө оруулалт татах маш том гарцыг бий болгох юм. Үүнтэй холбогдуулан компанийн зээлжих зэрэглэл тогтоох байгууллага, үйлчилгээг бий болгох;
- Хөрөнгийн зах зээлд оролцох шат дамжлага, шимтгэл, хураамжийг бууруулах.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болох брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх болон менежментийн компаниуд, хөрөнгийн биржүүд, төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагууд, кастодиан банкнууд, мэргэжлийн холбоод зэрэг байгууллагуудын төлөөллийг хамруулан “Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох” хэлэлцүүлгийг 2017 оны 1 дүгээр сарын 25 –26-ны өдрүүдэд зохион байгуулж, хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн талаар санал солилцсон.

Үүнээс гадна салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагын талаар холбогдох байгууллагуудаас албан бичгээр санал авсан бөгөөд хэлэлцүүлэг болон албан бичгээр хүлээн авсан саналуудыг нэгтгэн дүгнэвэл, хуулийг хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулах дараах практик шаардлага үүсжээ. Үүнд:

- Зохицуулалттай үйл ажиллагаа, тэдгээрийн онцлог, ялгаа, үйл ажиллагааны хүрээг тодорхой болгох;
- Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудын хариуцах асуудлын хүрээг ялгаатай тогтоох;
- Өрийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах, хязгаарлалтыг багасгах;
- Дэд бүтцийн байгууллагуудын гишүүддээ тавих хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагын харилцан уялдаа, хариуцан хэрэгжүүлэх эрх хэмжээг илүү тодорхой болгох..

## **1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, дэд бүтэц, мэргэжлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, дундын зуучлагч, хөрөнгө оруулагч гэх мэт өргөн хүрээг нарийвчлан зохицуулсан хууль юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийхэд зах зээлд оролцогчдод эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх дараах этгээдүүд байна. Үүнд:

1/ Хөрөнгө оруулагчид (гадаадын болон дотоодын иргэн, хуулийн этгээд)

2/ Үнэт цаас гаргагч

3/ Зах зээл дээр зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд (брокер, дилер, андеррайтер, арилжаа эрхлэгч, арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэгч, арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэгч, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч, төлбөр мэргэжлийн холбоод гэх мэт)



Хүснэгт 1. Ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд

	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Хөрөнгө оруулагчид (гадаадын болон дотоодын иргэн, хуулийн этгээд)	<p>Хөрөнгө оруулагчдын эрх ашигт эергээр нөлөөлнө.</p> <p>1. Одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчинд үнэт цаас (хувьцаа, бонд) өмчлөгчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт муу байна. Хөрөнгө оруулагчид үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд оруулсан хөрөнгө оруулалтаа хэрхэн нэхэмжлэх талаарх зохицуулалт тодорхойгүй байгаагаас энэ зах зээлд орох итгэл төрдөггүй байна.</p> <p>2. Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор хуульд оруулах өөрчлөлт нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтсон стандартын дагуу тогтмол авах давуу тал үүснэ.</p> <p>3. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/Т+2 горим” олон улсын зарчим нэвтэрснээр үнэт цаасны арилжаанд оролцохдоо өмнө нь төлбөрөө урьдчилж байршуулдаг байсан бол одоо эрсдэлийн маржингийн тодорхой хувийг урьдчилан төлж, үлдсэн төлбөрийг арилжаа явагдсанаас хойш 2 хоногийн дотор байршуулдаг болох юм. Энэ нь хөрөнгө оруулагчид мөнгөн хөрөнгөө олон хоног нэг дансанд үр ашиггүй байршуулж мөнгөний үнэ цэнийг алдагдуулах эрсдэлээс сэргийлж төлбөрөө төлсөн даруйдаа үнэт цаасаа өмчлөх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
2	Үнэт цаас гаргагч	<p>1. Компанийн биржийн зах зээл дээр үнэт цаасыг олон нийтэд нээлттэй гаргах, түүнийг зохицуулагч байгууллага болон арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг хялбаршуулна. Ингэснээр үнэт цаас гаргаж олон нийтэд</p>

		<p>санал болгоход цаг хугацаа хэмнэх ба зохицуулагч байгууллагаас авах зөвшөөрөл цөөрч, дагалдан бий болдог хүнд суртал арилах зэрэг нөлөөтэй болно.</p> <p>2. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр биржийн болон биржийн бус зах зээлийн зохицуулалтын тодорхой бус байдал багасах ба ингэснээр үнэт цаас гаргагч өөрсдийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн зах зээл, хөрөнгө оруулагчдын бүлэг, үнэт цаасны төрлөө сонгох өргөн боломж нээгдэнэ.</p> <p>3. Хуулийн төсөлд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах үүднээс мэдээллийн ил тод байдлыг хангаж, зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагын дагуу мэдээлж байх үүргийг оруулна. Энэхүү зохицуулалт орсноор хувьцаат компаниуд болон үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх, үүргээ биелүүлдэггүй үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахгүй байх зэрэг сонголт бий болно. Ингэснээр цаашид хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн үнэт цаас гаргагч нь бага хүүтэйгээр санхүүжилт татах итгэлцэл зах зээл дээр үүсч, хөрөнгийн зах зээл хөгжих чухал ач холбогдолтой юм.</p>
3	<p>Зах зээл дээр зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд (брокер, дилер, андеррайтер, арилжаа эрхлэгч, арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэгч, арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэгч, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч, төлбөр мэргэжлийн холбоод гэх мэт...)</p>	<p>1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/Т+2 горим” олон улсын зарчим нэвтрэхтэй холбоотойгоор үнэт цаасны арилжаанд оролцоход хөрөнгө оруулагч мөнгөн төлбөрийг 100 хувь урьдчилж байршуулдаг байсан системийг хална. Ингэснээр үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 өдрийн дараа гүйцэтгэхтэй холбоотойгоор дэд бүтцийн байгууллагууд болох үнэт цаасны тооцооны, төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, үнэт цаасны брокерын компаниудад харилцагчдын төлбөрийн</p>

	<p>чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, үүнтэй холбоотойгоор зах зээлд төлбөрийн баталгааны сан байгуулах зэрэг нэмэлт үүргүүд үнэт цаасны компаниуд болон тооцоо эрхлэх байгууллага, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орох юм.</p> <p>2. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг үр ашигтай болгох, арилжаа эрхлэгч байгууллага болон зохицуулагч байгууллагын бүртгэлийн үйл ажиллагааг үр ашигтай давхардалгүй болгох хүрээнд үнэт цаас гаргах үйл ажиллагааг хялбаршуулж байгаатай холбогдуулан арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны амжилттай болсон эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах, мөн зах зээлийг урвуулан ашиглах, хөрөнгө оруулагчдыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ болох арилжаа зогсоох чиг үүргийг арилжаа эрхлэх байгууллагад шинээр өгөхтэй холбогдуулан тэдний үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.</p> <p>3. Одоо мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь биржийн зах зээлийн үйл ажиллагааг голчлон зохицуулж байгаатай холбогдуулан биржийн бус зах зээлийн харилцаа, түүн дээр гарах бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих эрх зүйн зохицуулалт дутагдаж байсан. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр биржийн болон биржийн бус зах зээлийн зохицуулалтын ялгааг гаргаж өгсөнтэй холбогдуулан зохицуулалттай этгээдүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд цаашид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломж шинээр нээгдэж байгаа болно.</p>
--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

### 1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

#### 1.3.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт 4.3-д “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж заасан. Энэхүү зорилтыг хөгжүүлэх I дүгээр шатанд (2021-2030 он) “Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүн өссөн байна”, II дугаар шатанд (2031-2040 он) “Томоохон хөрөнгийн зах зээл дээр дотоодын бүтээгдэхүүнийг чөлөөтэй арилжаалдаг болсон байна”, III дугаар шатанд (2041-2050 он) “Олон улсад өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлсэн байна” гэсэн үр дүнд хүрэхээр төлөвлөгдсөн байна.

Мөн Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 43-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний зорилго 2.1-д “Хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчныг шинэчилж, зохицуулагч байгууллагын зохицуулалт, хяналтын чадавхыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгана” гэж, мөн 2.1.1-д “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заасан нь уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

### **1.3.2. Практик шаардлага**

Монгол Улсад 1990 онд анх шинээр үүссэн хөрөнгийн зах зээлийн хөгжил сүүлийн жилүүдэд огцом хурдацтай явагдаж буй бөгөөд үүнийг дагаад зөв зохистой хууль, эрх зүйн орчин болон төрийн бодлого, зохицуулалтыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай анхны хууль 1994 онд батлагдаж, 2002 оноос удаах шинэчилсэн найруулгыг мөрдөж байсан бол одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг 2013 онд шинэчлэн баталж байсан ба баталснаас нь хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэвч хөрөнгийн зах зээлийн практикт олон улсын болоод дотоод орчны хурдацтай өөрчлөлттэй холбоотойгоор зах зээл дээр шинээр хөгжиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд зохицуулалтын орчин тодорхойгүй байгаа нь нь хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлж байна.


Сүүлийн жилүүдэд дотоодын хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдын санхүүгийн боловсрол сайжирч тэр дундаа хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын урсгал сайжирч, хөрөнгийн зах зээлийн идэвх сэргэж байна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагчдад

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах хүсэл сонирхол байвч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчинд зарим асуудлууд зохицуулалтгүй байгаа, дэд бүтцийн системд олон улсын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн зарчим хэрэгждэггүй нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн шалтгаан болж байна. Эдгээрийг тодруулбал:

1. Хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний зохицуулалтын орчныг сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл идэвхжиж зах зээлийн арилжааны дүн өсөж байсан хэдий ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр арилжааны хэмжээ өмнөх оноос 2.2 дахин буурч 2020 оны жилийн эцсийн байдлаар 65.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Харин 2021 оноос арилжааны хэмжээ дахин сайжирч 1,414.2 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт арилжааны үнийн дүнг бүтцээр нь авч үзвэл хувьцааны арилжаа 21.6 хувь, компанийн бондын арилжаа 74.1 хувийг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа 4 хувь орчмыг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа 0.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Хэдийгээр 2020 оноос эхлэн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гарч ирсэн, компанийн бондын арилжаа эрс нэмэгдсэн байгаа ч хөрөнгө оруулагчдын хувьд багцын хөрөнгө оруулалт хийх, багц бүрдүүлэхэд бүтээгдэхүүний төрөл бага, үнэт цаасны хөрвөх чадвар муу, эрсдэлгүй хөрөнгө оруулалт болох Засгийн газрын үнэт цаасны арилжаа байхгүй байна.

Зураг 2. Арилжааны дүн бүтээгдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

а) Компанийн бондын зах зээл нь эдийн засгийн өсөлт болон дотоодын компаниуд, хөрөнгө оруулагчид, засгийн газрын хувьд маш чухал юм. Компанийн бонд нь зээлдэгч компани болон хөрөнгө оруулагчдыг холбож, банкны санхүүжилтийг орлож, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, иргэдийн төрөөс хараат байх

байдлыг хязгаарлах, урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэр татах чухал хэрэгсэл болдог.

Одоо мөрдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь зөвхөн нийтэд арилжаалдаг үнэт цаасны зах зээлийг хамарч байгаа ба компанийн бондыг хаалттай хэлбэрээр болон биржийн бус зах зээл дээр гаргах үйл ажиллагааг орхигдуулсан нь нь бондын зах зээлийг хөгжүүлэхэд саад учруулж байна. Үр дүнд нь хаалттай хүрээнд гаргах бондыг хэрхэн гаргах, баримтжуулах, холбогдох эрхийг хэрхэн бүртгэх талаар тодорхой дүрэм, журам байхгүй байна. Одоогийн нөхцөлд хөрөнгийн зах зээл дээр “хаалттай хүрээнд худалдаалах бонд” гэж нэрлэгдээд байгаа санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн зээлийн гэрээний хэлбэртэй байгаа бөгөөд тэдгээрийн эрх нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд эсвэл кастодианд бүртгэгдээгүй бөгөөд хоорондоо худалдах зориулалттай санхүүгийн хэрэгслүүд биш болоод байна.

Монгол Улсад бондын зах зээл анх 2001 онд үүссэн боловч сүүлийн 18 жилийн хугацаанд Монголын хөрөнгийн биржид дөнгөж 16 компани, Үнэт цаасны бирж дээр 1 компани буюу нийт 16 компани олон нийтэд өрийн хэрэгсэл гаргах замаар 31 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан байна. Эдгээр компаниудын гаргасан өрийн хэрэгслийн хугацаа нь 6-24 сар байсан бөгөөд санхүүжилтийн 90 хувь нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зарцуулагдсан байна.

Хүснэгт-2: Компанийн бондын зах зээлийн мэдээлэл

Бонд гаргагч компани	Бондын нэр	Нэрлэсэн үнэ	Хүү	Хугацаа /сар/	Үнийн дүн /сая төгрөг/	Он
Барилга корпорац	Шинэ зуун	10,000 ₮	19.6%	10	5,335.7	2001
Нийслэл өргөө	Нийслэл өргөө	5,000 ₮	19.7%	12	1,200.0	2002
Алтан хот корпорац	Их барилга	10,000 ₮	19.8%	8	996.9	2004
Их барилга төсөл	Их барилга төсөл	50,000 ₮	19.8%	8	1,300.0	2004
Пума групп	Пума бонд	10,000 ₮	21.6%	12	1,000.0	2004
Эм Си Эс Электроникс	Эм Си Эс электроникс бонд	120,000 ₮	19%	18	872.6	2004
Эм Си Эс Электроникс	Эм Си Эс электроникс бонд	100 US\$	11%	12	605.0	2002
Анод банк	Анод бонд	10,000 ₮	19.6%	24	209.5	2005
Говь	Говь	10,000 ₮	19.2%	12	1,000.0	2003
Мон инжбар	Бүтээн байгуулалт	10,000 ₮	21.6%	18	500.0	2005

Монфреш жүүс	Монфреш бонд	10 US\$	11%	12	182.8	2007
Мон инжбар	Бүтээн байгуулалт	10,000 ₮	11.2%	24	502.0	2008
Жаст агро	Монгол мах	10,000 ₮	16.2%	12	4,399.5	2011
Эрчим инженеринг	Эрчим бонд	10,000 ₮	18.5%	6	500.0	2015
Сүү	Сүү бонд	100,000 ₮	17.5%	6	6,000.0	2017
Лэнд мн	Лэнд бонд	100,000 ₮	17%	12	5,000.0	2020

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж ТӨХК

Харин сүүлийн жилүүдэд компаниуд дээр дурдсанчлан “хаалттай хүрээнд худалдаалах бонд” хэлбэрээр олон нийтээс санхүүжилт татах үйл ажиллагаа эрс нэмэгдсэн ба албан бус тооцооллоор 2018 онд 20-40 тэрбум төгрөгийн бонд хаалттай хүрээнд гарсан ба купоны хэмжээ дунджаар 16-20 хувьтай байсан байна.

Хэдийгээр компаниуд хаалттай хүрээнд бонд гарган санхүүжилт татаж байгаа нь сайшаалтай боловч цаашлаад энэхүү үйл ажиллагаа нь ямар нэгэн зохицуулалтгүйгээр үргэлжлэх, олон тооны мэргэжлийн бус хөрөнгө оруулагчдаас их хэмжээгээр хөрөнгө оруулалт татах нь үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хөрөнгө оруулагчдыг олноор нь хохиролд оруулах, хөрөнгийн зах зээлд итгэх итгэлгүй болгох, хөрөнгийн зах зээлийн нэр хүнд унах өндөр эрсдэлтэй байна.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь тухайн бонд гаргагчийн гаргах боломжтой бондын дүнг тухай бонд гаргагчийн (хэрвээ бонд нь баталгаатай бол бонд гаргагчийн болон баталгаа гаргагчийн нийлбэр) өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байхаар хязгаарлалт хийсэн. Түүнчлэн Компанийн тухай хуульд бондыг хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалж гаргахыг шаардаж байгаа нь Монголын компаниудыг бонд гаргахад саад учруулж байна.

б) Сүүлийн жилүүдэд хувийн, хаалттай компаниуд /ХХК/ олон нийт, иргэдээс мэдээллийн цахим сүлжээ ашиглан “бонд” гэх нэрийдлээр зээлийн гэрээ байгуулан санхүүжилт татсан тохиолдлууд гарах болсон. Энэ тал дээр үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төрийн зохицуулагч байгууллага болохын хувьд Санхүүгийн зохицуулах хороо нь албан ёсоор өөрийн цахим хуудсаар, мөн дээрх компаниудын удирдлагуудад мэдэгдэл хүргүүлж, олон нийтэд анхааруулах арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн.

Тухайлбал, компанийн бонд болон зээлийн гэрээ хоёр нь зарчмын хувьд, мөн бонд нь санхүүгийн хэрэгсэл болохын хувьд дан ганц зээлийн гэрээнээс олон зүйлээр онцлог, нарийн зохицуулалттай байдаг бөгөөд олон нийт буюу 50-аас дээш хөрөнгө оруулагчдад санал болгох үед заавал Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр гаргах хуулийн зохицуулалт одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хэдийгээр компани, хуулийн этгээд хаалттай хүрээнд бонд гаргаж болох ч, “бонд” гэх нэрийдлээр зээлийн гэрээ байгуулж, санхүүжилт татаж байгаа нь

санхүүгийн мэдлэггүй олон нийт, иргэдийг төөрөгдүүлж, ямар ч барьцаа хөрөнгөгүй, эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхэд хүргэж байгаа ба дээрх зээлийн гэрээнээс үүдэлтэйгээр хөрөнгө оруулагчид хохирсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтаас гадуур тул иргэд, олон нийтийг эрх ашгийг хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хамгаалах боломж бүрдээгүй байна.

Бусад хөгжингүй орнуудад олон нийт, иргэдээс цахим технологи ашиглан санхүүжилт татахтай холбогдсон харилцааг хамтын санхүүжилт /crowdfunding/-ийн хууль тогтоомжоор зохицуулж байгаа ба Монгол Улсад хувийн компаниудын олон нийт, иргэдээс санхүүжилт татаж байгаа хэлбэр нь дээрх хамтын санхүүжилтийн нэг төрөлд багтахар байна. Хамтын санхүүжилт нь өндөр эрсдэлтэй санхүүгийн үйл ажиллагаанд хамаардаг тул цахим технологийг ашиглан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага тулгарч байна.

в) Одоо мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үүсмэл санхүүгийн хэрэгслүүд (дериватив) нь зөвхөн бирж дээр арилжаалагдах үйл ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд биржийн бус зах зээлийн үүсмэл санхүүгийн хэрэгслийн эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй байна.

Иймд, цаашид үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр нээлттэй болон хаалттайгаар арилжаалах зохицуулалтыг бий болгохын тулд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үүсмэл санхүүгийн хэрэгслүүд болон түүний төрлүүдийн тодорхойлолтуудыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэх, цаашид хөрөнгийн зах зээл дээр эдгээр хэрэгслүүдийг арилжаалахдаа үүсмэл санхүүгийн хэрэгслийн олон улсын стандарт гэрээний загваруудыг ашиглах шаардлагатай байна.

2. Монголын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн систем, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны горим нь 2020 оны 3 сарын 31-ны өдрөөс өмнө хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны арилжаанд оролцоход үнэт цаас худалдан авах мөнгөн төлбөрийг урьдчилж 100 хувь байршуулахыг шаарддаг байсан. Энэ нь хөрөнгийн зах зээлийн олон улсын зарчим болох “Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт”-ийн зарчим буюу “харилцагч мөнгөн төлбөр төлсөн даруйд нэгэн зэрэг үнэт цаасыг өмчлөх эрхтэй болох” зарчмыг зөрчиж байсан.

Монгол Улс хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системдээ төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг хэрэгжүүлдэггүйн улмаас 2017 онд олон улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшнийг хөгжлөөр нь ангилдаг “FTSE Frontier market watch list” - ээс хасагдсан. Гадаадын хөрөнгө оруулагчид тухайн орны хөрөнгийн зах зээлд оролцоход дээрх жагсаалтад байгаа эсэхийг урьдчилж хардаг байна. Ийнхүү тус жагсаалтаас хасагдсан нь гаднын хөрөнгө оруулагчид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд орж ирэхгүй байх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Улмаар Сангийн сайдын 2019 оны 149 дүгээр тушаалаар “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “DvP/T+2 горим” буюу “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” олон улсын зарчмыг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг хөрөнгийн зах зээлийн нийт оролцогч байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулж, шаардлагатай



эрх зүйн болон дэд бүтцийн системүүдийн бэлтгэл ажлыг гүйцэтгэснээр 2020 оны 3 сарын 31-ны өдрөөс Монголын хөрөнгийн зах зээл дээрх олон улсын зарчмыг нэвтрүүлсэн.

Хэдийгээр дээрх зарчим нь дэд бүтцийн байгууллагуудын мөрдөн ажиллах журмын хүрээнд одоогоор зохицуулагдаж байгаа хэдий ч энэхүү зарчмын дагуу хийгдэх төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 өдрийн дараа эцэслэх, төлбөр хийгдэхэд нэгэн зэрэг үнэт цаасыг шилжүүлэх механизм, аль нэг үнэт цаасны арилжаанд оролцогч төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг удирдах зорилгоор дэд бүтцийн байгууллагуудын зах зээлд гүйцэтгэх үүргүүдийг дахин зохион байгуулах, энэ дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Дампуурлын тухай хуульд шаардлагатай өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

Цаашид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд дээрх олон улсын төлбөр тооцооны үндсэн зарчмыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд оролцоход шат дамжлага болон зардал буурч мөн зах зээлд итгэх итгэл нэмэгдэх юм.

3/ Дотоодын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны компаниуд буюу брокер, дилерийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал, олон улсад дагаж мөрдөгддөг зарим төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа болох үнэт цаас зээлэх, зээлдүүлэх, богино хугацаат арилжааны үйл ажиллагааг эрхлэх боломж хаалттай байгаа нь үнэт цаасны компаниуд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг хязгаарлаж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлд Үнэт цаасны арилжаа эрхлэх 2, төлбөр тооцооны 1, төвлөрсөн хадгаламжийн 1 байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн 34 компани, 26 хувийн хөрөнгө оруулалтын сан, 3 кастодиан банк, 55 үнэт цаасны компани, мөн үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх 49 аудитын, 22 үнэлгээний, хуулийн зөвлөгөө үзүүлэх 39 компани тус тус үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хороонд бүртгэлтэй нийт 314 хувьцаат компани байна.

Зураг . ҮЦК-уудын тоо, хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/



Түүнчлэн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчид дутагдаж байгаагаас хувьцаа болон компанийн бондын зах зээлд урт хугацаат хөрөнгө оруулалт орж ирэх, үнэт цаас гаргагч компаниудад урт хугацаат санхүүжилт татах боломж хязгаарлагдмал байна. Иймд цаашид хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалтын сан, хувийн тэтгэврийн сан зэрэг урт хугацаат хөрөнгө оруулагчдыг дэмжих зохицуулалтын уян хатан орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Хүснэгт-3: Зохицуулалттай этгээдийн тоо /2021/

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	34
5	Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	26
6	Кастодиан банк	3
7	Брокер	55
8	Дилер	36
9	Андеррайтер	19
10	Хөрөнгө оруулалтын зөвлөх	16
11	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
12	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	10
13	Аудитын компани	49
14	Үнэлгээний компани	22
15	Хуулийн компани	39
16	Бүртгэлтэй хувьцаат компани /СЗХ/	314

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монголын хөрөнгийн бирж дээр 2005 оноос хойш 19 компани хувьцаагаа олон нийтэд санал болгож нийт 100 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан. Үүний Лэндмн, Мандал даатгал, Ард даатгал, Монгол шуудан зэрэг 10-аад компани 2015-2020 оны хооронд шинээр үнэт цаас гаргасан бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга нь дунджаар 3 дахин их орж ирсэн нь хөрөнгө оруулагчдын эрэлт их байгааг харуулж байна. Гэвч хөрөнгө оруулагчдын зүгээс богино хугацаанд хувьцааны ханшийн зөрүүгээс ашиг хийх боломжийг хайж хөрөнгө оруулалт хийж байгаа нь аажимдаа хувьцааны үнэ унах эрсдэл үүсгэж байна.

4/ Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос 2019 онд хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдын дунд явуулсан “Үнэт цаасны компанийн брокерын үйлчилгээний төлбөр, тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгааны нэгдсэн дүгнэлтээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудын хөрөнгө оруулагчдаас авдаг шимтгэл нь өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад Монголын хөрөнгийн биржийн шимтгэл 99.3% өндөр, үнэт цаасны компанийн шимтгэл 82%

өндөр, зохицуулагч байгууллагын шимтгэл азийн орнуудтай харьцуулахад 0.039%, клирингийн үйлчилгээний шимтгэл 0.19-0.23%-иар тус тус өндөр байгаа нь тогтоогдсон.

Хүснэгт-4: Дэд бүтцийн байгууллагуудын арилжааны шимтгэл

	Нийт гүйлгээ / сая MNT /	Харилцагчдын брокерын компанид төлөх шимтгэл /хувиар/		Үүнээс:				СЗХ-ны зохицуулалтын шимтгэл * / хувь /
				АТТ /хувиар/		МХБ /хувиар/		
				Авах	Зарах	Авах	Зарах	
Хувьцаа	≤100.0	1.4~2.5	1.4~2.5	0.24	0.24	0.4	0.4	10
	100.0-1,000.0	1.4~2.5	1.4~2.5	0.24	0.24	0.38	0.38	
	1,000.0-10,000.0	1.4~2.5	1.4~2.5	0.24	0.24	0.3	0.3	
	10,000.0-30,000.0	1~2.5	1~2.5	0.24	0.24	0.2	0.2	
	≥30,000.0	1~2.5	1~2.5	0.24	0.24	0.15	0.15	
ЗГҮЦ (анхдагч)	-	0.048~0.05	0.048~0.05	0.00375	0.00175	0.00875	0.12	/* СЗХ бүх оролцогчдоос зохицуулалтын үйлчилгээний хөлс авдаг /
ЗГҮЦ (хоёрдогч)	-	0.048~0.05	0.048~0.05	0.00375	-	0.00875	-	
Компанийн бонд (анхдагч)	-	0.1	0.1	0.0075	0.0075	0.0175	0.1575	
Компанийн бонд (хоёрдогч)	-	0.1	0.1	0.0075	-	0.0175	-	

Мөн хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцоход үнэт цаасны данс болон мөнгөн хөрөнгийн данс нээлгэх үйл ажиллагаанаас хамаарч хамгийн багадаа 2-4 хоног зарцуулдаг, шат дамжлага ихтэй байгаа нь хөрөнгө оруулагчдыг энэ зах зээлд орж ирэхэд хамгийн төвөгтэй байдлыг үүсгэж байна. Эдгээр нөхцөл байдлыг үүсгэж буй шалтгаан нь үнэт цаасны компаниуд болон дэд бүтцийн байгууллагуудын үр ашиггүй техникийн болон программ хангамжийн системийн асуудал юм.

Техник технологи өндөр хөгжсөн өнөөгийн нийгэмд хөрөнгө оруулагчид шат дамжлага ихтэй, үр ашиггүй, зардал өндөртэй, цаг хугацаа их зарцуулсан, хэрэглэгчдэд хүндрэл учруулсан санхүүгийн үйлчилгээг хүртэхээс зайлсхийдэг болоод байна.

Цаашид хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар үнэт цаасны компаниудын үйл ажиллагааг үр ашигтай болгох, гар ажиллагааг багасгах, хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд оролцох шат дамжлага болон зардлыг багасгах шаардлагатай байна. Иймд финтект суурилсан санхүүгийн үйлчилгээг үр ашигтай бөгөөд хэрэглэгчдэд ээлтэй болгох, зардал, цаг хугацаа хэмнэсэн технологийн дэвшлийг даруй нэвтрүүлэх, зохицуулалтын орчныг

уян хатан болгох, төрийн бодлогыг тодорхой болгох нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих чухал асуудлын нэг болоод байна.

Хөгжингүй орнуудад олон нийтээс цахим технологи ашиглан санхүүжилт татахтай холбогдсон харилцааг хамтын санхүүжилт /crowdfunding/-ийн хууль тогтоомжоор зохицуулж байгаа ба Монгол Улсад хувийн компаниудын олон нийт, иргэдээс санхүүжилт татаж байгаа хэлбэр нь дээрх хамтын санхүүжилтийн нэг төрөлд орж байгаа юм. Нөгөөтээгүүр хамтын санхүүжилт нь өндөр эрсдэлтэй санхүүгийн үйл ажиллагаанд хамаарч байгаа тул цахим технологийг ашиглан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага тулгарч байна.

5/ Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дунджаар 6 сар, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаасаа бүртгүүлж зөвшөөрөл авахад хуулийн хугацаагаар ажлын 20 хоног зарцуулах ёстой боловч нэмэлт материал бүрдүүлэлт, түүнийг хянах хугацааг оруулаад дахин 6 сар хүртэл хугацаа зарцуулдаг байна.

Ийнхүү үнэт цаасыг олон нийтэд санал болох явц нь нэг жил хүртэлх хугацаа шаардахаас гадна зохицуулагч байгууллага болон арилжаа эрхлэгч байгууллага хоорондын үйл ажиллагааны давхардал нь үнэт цаас гаргагч нарт бичиг баримт, холбогдох материал бүрдүүлэхэд хүндрэл болон цаг хугацааны хувьд тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Иймд хууль эрх зүйн орчинд үнэт цаасыг биржийн болон биржийн бус зах зээл дээр нээлттэй болон хаалттай хэлбэрээр гаргах, түүнийг бүртгэх үйл явцыг хялбаршуулах зохицуулалтыг тодорхой болгох шаардлага тулгарч байна.

6/ Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чухал зохицуулалт нь мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах явдал юм. Гэвч одоо үйлчилж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалт сул байгаа нь хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлийг сонгох итгэлгүй болоход нөлөөлдөг байна.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д 2020 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй 192 компани байгаа ч эдгээр компаниудын 30 хувь нь мэдээллийн ил тод байдал, Монголын хөрөнгийн биржээс шаардсан тайлагналт, компанийн засаглалын шаардлагыг хангаж ажилладаг, үлдсэн 70 гаруй хувь нь тус шаардлагыг хангаж ажилладаггүй байна.

Гэтэл гадаадын улс орнууд олон улсын хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор бүртгэлтэй компаниудыг мэдээллээ тогтмол ил тод болгох, хөрөнгө оруулагчид мэдээлэл авах мэдээллийн нэгдсэн платформд байршуулахыг шаарддаг бөгөөд энэ дагуух хариуцлагыг мөн өндөржүүлсэн байдаг.

Иймд, зохицуулагч байгууллагын зүгээс цаашид үнэт цаасны зах зээлийн хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэн хийх, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг үр ашигтай болгох, хөрөнгө оруулагчдыг хохироохгүй байлгах зохицуулалтыг бий болгох нь чухал байна. Тиймээс санхүүгийн зохицуулагч байгууллагуудад нэвтэрч буй технологид суурилсан эрсдэлийг удирдах, олон улсад нийтлэг хэрэглэгддэг “corporate action” буюу үнэт цаас гаргагчийн зүгээс компанийн бүх төрлийн үнэт цаас эзэмшигчдэд бодит өөрчлөлт бүхий нөлөө үзүүлэх үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг мэдээлэх зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй байна.

Түүнчлэн, зохицуулагч байгууллагын хүний нөөц, санхүүгийн хүчин чадал дутагдалтай байгаа нь хяналт шалгалтыг үр дүнтэй, шуурхай гүйцэтгэхэд эрсдэл учруулж байна. Тиймээс санхүүгийн зохицуулагч байгууллагуудад нэвтэрч буй технологид суурилсан эрсдэлийг удирдах, олон улсад нийтлэг хэрэглэгддэг “компанийн үйлдэл” -ийг мэдээлэх зохицуулалтыг сайжруулах нь зүйтэй байна.

### **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалт нь үнэт цаасыг нийтэд санал болгох, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгчийг зохицуулахад чиглэсэн боловч энэ нь хувьцааны зах зээлийн зохицуулалтад түлхүү анхаарч, хөрөнгийн зах зээлд хамаарах дараах чухал асуудлуудад тодорхой зохицуулалт байхгүй орхигдуулсан байна. Үүнд:

- санхүүгийн бусад хэрэгсэл болох компанийн өрийн хэрэгсэл буюу бондын зах зээлийн нээлттэй болон хаалттай зах зээлийн үйл ажиллагаа;
- үүсмэл зээлийн хэрэгслийн зах зээл;
- хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн төлбөрийн эсрэг нийлүүлэлт;
- дундын зуучлагч тооцооны байгууллага, клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан зэрэг арилжааны дараах дэд бүтцийн асуудлууд;
- мэдээллийн ил тод байдал, компанийн засаглал, хувьцаа эзэмшигчийн эрхийн хэрэгжилт зэрэг.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойллоо.

**Ерөнхий зорилт:** Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор хөрөнгийн зах зээлд шинэлэг технологийн дэвшлийг нэвтрүүлж, дэд бүтцийг олон улсын стандартад нийцүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, урт хугацаат мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохистой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

### **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах

аргачлалын дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын стандартад нийцүүлэх, зохицуулалтын орчныг уян хатан болгох, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх замаар шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, урт хугацаат хөрөнгө оруулалтыг бий болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохистой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийг хөгжлийг дэмжих” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

### *3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:*

Энэ хувилбарын дагуу зах зээлийн харилцааг төрийн бодлоготой уялдуулах, зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулах, зохицуулалт хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг бий болоод байгаа бэрхшээлүүд хэвээр үлдэж, зорилгод хүрэх боломжгүй юм. Тэг хувилбарын дагуу нэмэлт зардал, хөрөнгө гарах шаардлагагүй хэдий ч хөрөнгийн зах зээлд тулгамдаад буй одоогийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

### *3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил өрнүүлэх:*

Асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажил өрнүүлэх нь зорилгыг хангах арга зам биш юм. Тус хуулийг олон нийтэд хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслээр дамжуулан ухуулах нь асуудлыг шийдвэрлэх, зохицуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах, зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулах боломжийг бүрдүүлэхгүй. Энэхүү хувилбарыг хэрэгжүүлэхэд зардал, хөрөнгө их шаардах бөгөөд хөрөнгийн зах зээлд тулгарах асуудлуудыг шийдвэрлэхэд үр дүн өгөхгүй гэж үзэж байна.

### *3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах:*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, зах зээлийн хөгжлийг дэмжихэд дан ганц төрийн оролцоо хангалтгүй тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй. Үүний зэрэгцээ төрөөс зохицуулах нь зардал, хөрөнгө ихээр шаардахаас гадна тулгарч байгаа бэрхшээлийг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй болно.

### *3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх:*

Зах зээлийн харилцааг төрийн бодлоготой уялдуулах, зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулах зэрэг асуудлууд нь хөрөнгө, мөнгө, санхүүгийн хүндрэл, дутагдлаас илүүтэйгээр хуулийн зохицуулалттай холбоотой бүтцийн шинжтэй асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэн зорьж буй үр дүнд хүрэх боломжгүй юм. Төрийн зохицуулалт нэг удаагийн шинжтэй байх магадлалтай тул энэ нь урт хугацаанд хөрөнгийн зах зээлд үүссэн асуудлыг шийдвэрлэхэд төдийлөн ач холбогдолтой байж чадахгүй.

Төрөөс санхүүгийн интервенц хийх аргыг хэрэглэснээр зардал, хөрөнгө зарцуулах боловч зорилгод хүрэх боломжийг бүрдүүлж чадахгүй байна.

### 3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх

Хөрөнгийн зах зээл дээрх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хууль, эрх зүйн өөрчлөлт, хяналт шалгалтын тогтолцоог зөвхөн эрх бүхий байгууллагууд шинэчлэх, өөрчлөх эрхтэй бөгөөд төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр зах зээл дээрх технологи дээр суурилсан санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх гэх мэт үйлчилгээнүүдийг нэвтрүүлж болох ч энэхүү хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэж, зорилгод хүргэх боломжгүй.

### 3.6. Захиргааны шийдвэр гаргах:

Зохицуулагч байгууллагаас журам гаргах эрхтэй боловч тулгарч буй асуудлыг "Захиргааны шийдвэр" буюу Захиргааны ерөнхий хуульд заасан нэг удаагийн эсвэл олон удаагийн тохиолдлыг зохицуулах шинжтэй захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй. Мөн нөгөө талдаа үнэт цаасны зах зээлийн тухай хуульд буй асуудлуудыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлж чадахгүй, хэм хэмжээний хувьд хүчин чадал доогуур акт байх болно, эсхүл хуулиас давсан зохицуулалт хийхэд хүргэнэ.

### 3.6. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулснаар хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх боломжтой, хамгийн үр дүнтэй хувилбар байх юм. Энэ хувилбарыг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний зардал гарах боловч асуудлыг үүсгэж буй гол шалтгаануудыг арилгаж Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зохицуулалтгүй орхигдсон асуудлуудыг шийдвэрлэх, хуулийн хийдлийг нөхөх боломж бүрдэнэ.

Асуудлыг шийдвэрлэх хувилбарыг харьцуулж, тоймлон дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Хувилбарын харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Зохицуулалт хийхийг шаардаж буй асуудлуудыг шийдвэрлэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, серег үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн серег
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарах ба асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, серег үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүн серег

3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжиж өгөх, төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлсэн төлбөрийн баталгааны санг байгуулах зэргээр төрөөс зохицуулалт хийж болох ч үүсээд буй нөхцөл байдлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Энэ асуудал нь хөрөнгө, мөнгө, санхүүгийн хүндрэл, дутагдлаас илүүтэйгээр хуулийн зохицуулалттай холбоотой бүтцийн шинжтэй асуудал тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэн зорьж буй үр дүнд хүрэх боломжгүй юм.	Зардал, хөрөнгө зарцуулах боловч асуудлын шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Холбогдох хуулиар зохицуулж байгаа харилцааг захиргааны шийдвэрээр “өөрөөр зохицуулах” нь зорилгод хүрэх боломжийг олгохгүй ба үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг шийдвэрлэж, зорилгод хүрэх боломжийг бүрдүүлнэ.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

Зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг талын зардал, үр өгөөжийг хувилбар тус бүрээр харьцуулан үзэж, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын стандартад нийцүүлэх, зохицуулалтын орчныг уян хатан болгох, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх замаар шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, урт хугацаат хөрөнгө оруулалтыг бий болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохистой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тогтоох” зорилгыг хангаж чадах хамгийн сайн хувилбар болж байна гэж дүгнэлээ.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ



Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, үүсээд буй асуудлыг шийдвэрлэх, дутагдаж буй зохицуулалтыг бий болгож, хууль, эрх зүйн зөв, тогтвортой орчинг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүний тулд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах зохицуулалтын хувилбарыг сонгосон болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгохтой холбогдуулан дараах хууль зүйн үндэслэлүүдийг дурдаж болохоор байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт 4.3-д “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж заасан. Энэхүү зорилтыг хөгжүүлэх I дүгээр шатанд (2021-2030 он) “Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүн өссөн байна”, II дугаар шатанд (2031-2040 он) “Томоохон хөрөнгийн зах зээл дээр дотоодын бүтээгдэхүүнийг чөлөөтэй арилжаалдаг болсон байна”, III дугаар шатанд (2041-2050 он) “Олон улсад өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлсэн байна” гэсэн үр дүнд хүрэхээр төлөвлөгдсөн байна.
2. Мөн Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 43-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.
3. Түүнчлэн, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний зорилго 2.1-д “Хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчныг шинэчилж, зохицуулагч байгууллагын зохицуулалт, хяналтын чадавхыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгана” гэж, мөн 2.1.1-д “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, шинэ эрх зүйн зохицуулалтыг бий болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заасан нь уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн байх бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасныг үндэслэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төрөл хэлбэрээр боловсруулна.

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

#### **4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Сонгосон хувилбарын хүрээнд тайлангийн 1.1-д заасан “Үнэт цаасны зах зээлийн харилцааг төрийн бодлоготой уялдуулах, зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулах, зохицуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах” асуудлыг шийдвэрлэхээр зорьж буй бөгөөд дээрх асуудлууд нь зах зээлд оролцогч хуулийн этгээдэд хамаарах тусгай зөвшөөрөл, эрх зүйн зохицуулалтыг хөндөх тул хувь хүн, хөрөнгө оруулагчийн хүний эрхэд шууд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Иймд тулгамдаж буй асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь эерэг нөлөөтэй байна.

#### **4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Үнэт цаасны зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулснаар урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх, түүгээр дамжуулж хувийн хэвшил бизнесээ өргөтгөх, эргээд эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хадгалах, улсын төсөвт татварын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Мөн хууль, эрх зүйн орчин сайжирснаар хөрөнгийн зах зээл дэх дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч нарын сонирхол нэмэгдэх, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал сайжрах зэрэг эдийн засагт олон талын эерэг өөрчлөлтүүдийг үзүүлнэ.

#### **4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь үнэт цаасны зах зээлийг дэмжиж, зах зээлийн харилцааг төрийн бодлоготой уялдуулах нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл бизнесийн байгууллагуудад шинэ төрлийн урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэр татах сувгууд бий болж, өртөг нь багасаж, цөөн төрлийн салбараас хамаарах эдийн засгийн хамаарал буурч, эдийн засгийн төрөлжилт нэмэгдэж, ажлын байр, цаашлаад хүн амын орлого өсөх байдлаар нийгэмд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

#### **4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хувилбарын энэхүү зохицуулалтын үед байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд ногоон санхүүжилтийн хөтөлбөрийг үнэт цаасны зах зээлийн бодлогын хүрээнд авч үзэж байна. Цаашид зах зээл хөгжсөнөөр ногоон бонд гаргах хэлбэрээр байгаль орчинд ээлтэй, эко төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бүрэн боломжтой бөгөөд энэ нь байгаль орчинд нөлөөлөх нэгэн шууд бус эерэг нөлөөлөл болох юм.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралтаар харуулав. /Хавсралт-1/.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын зэрэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Үнэт цаасны зах зээлийн харилцааг төрийн бодлоготой уялдуулах, зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулах, зохицуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах, энэ тайланд тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх, өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд хувилбар 6 буюу хууль батлан хэрэгжүүлснээр зорилтыг хангах боломж хамгийн өндөр гэж дүгнэлээ.

### **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Дэлхийн улс орнуудын үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн зохицуулалт нь тухайн улсынхаа эрх зүйн тогтолцоо, санхүүгийн салбарын бүтэц, түүний хөгжлийн түвшнээс хамааран өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг.

Гэсэн хэдий ч дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэх улс орнуудын туршлага, тэдгээрийн хууль, эрх зүйн орчин, өөрчлөлт, шинэчлэлийг даган дуурайх хандлага түгээмэл ба салбар бүрийн хувьд олон улсын байгууллагууд хамтран, нэгдсэн нэг зарчим, стандарт гарган дагаж мөрдөх бодлого баримтлах болсон.

Хөрөнгийн зах зээлийн хувьд гишүүн орнууд Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (International Organization of Securities Organization - IOSCO) болон Олон улсын төлбөр тооцооны банк (Bank for International Settlement-BIS)-аас тусдаа болон хамтран гаргасан санхүүгийн зах зээлийн ерөнхий зарчим болон дэд бүтцийн олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх байдлаар хууль эрх зүйн орчиндоо тусгадаг байна.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага нь 1983 онд дэлхийн үнэт цаас болон фьючерсийн зах зээлийг зохицуулах, үнэт цаасны салбар дахь олон улсын стандартыг тогтоох, зохицуулалтын стандартын хоорондын уялдаа холбоог нэгтгэн хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан. Нийт 100 гаруй орны үнэт цаасны зохицуулагч байгууллагуудын гишүүнчлэлтэй, дэлхийн үнэт цаасны зах зээлийн 95 хувийг зохицуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо тус байгууллагын гишүүнээр 2014 онд А жагсаалтын гишүүн орноор элссэн байна.

Энэ хүрээнд одоо мөрдөгдөж байгаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд батлах үед Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан үнэт

цаасны зах зээлийн зохицуулалтын олон улсын зарчмыг тусгасан. Гэсэн хэдий ч дэд бүтцийн төлбөр тооцооны олон улсын зарчмуудыг хуульд нарийвчлан тусгаагүй байна.

Түүнчлэн манай улс 2018 онд Азийн бондын зах зээлийг хөгжүүлэх, хил дамнасан гүйлгээ, зах зээлийн дэд бүтцийг бий болгох, улмаар эдгээр улсуудын зах зээлд чөлөөтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, бүс нутгийн стандартыг бий болгох зорилгоор ASEAN + 3 Сангийн сайд нарын "Азийн бондын зах зээлийн санаачилга (ABMI-Asian Bond Market Initiative)" үйл ажиллагааны санаачилгад гишүүн бус ажиглагчаар элссэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хүрээнд IOSCO болон "Азийн бондын зах зээлийн санаачилга (ABMI-Asian Bond Market Initiative)" -ын багаас бэлтгэн гаргасан олон улсын стандартуудыг зах зээлд нэвтрүүлэх хүрээнд судлан ажилласан.

Түүнчлэн, Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Олон Улсын Валютын сан, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Азийн хөгжлийн банк, Номура судалгааны институт зэргээс гаргасан Хөрөнгийн зах зээлийн бодлого, судалгааны материал, харьцуулсан судалгаа, уулзалт, хурлуудаар тавигдсан илтгэл, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлэлт, түүний дагуу өгч байсан зөвлөгөөг судалж, зөвшилцсөний үндсэнд хуулийн төслийг боловсруулна.

Тус зах зээл нь өөрийн гэсэн онцлогтой тул эрх зүйн тогтолцоог үл харгалзан хөгжлийн чиг хандлага тодорхойлогч улс орнууд болох Америкийн нэгдсэн улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон зарим европын улсуудын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг үнэт цаасыг олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд Зохицуулагч байгууллага болон хөрөнгийн биржүүд, өөрийгөө зохицуулах байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, үйл явцыг мөн судаллаа.

Дээрх судалгааг зах зээлийн үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдээс ирүүлсэн санал болон бодит байдал, практикт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хэд хэдэн бүлэгт хуваан гүйцэтгэсэн.

## **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тандан судалж, хөрөнгийн зах зээлийг төрийн бодлоготой уялдуулах, санхүүгийн салбарыг тэнцвэртэйгээр хөгжүүлэх, зах зээлд урт хугацаат хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, санхүүжилтийн зардал, шат дамжлагыг бууруулах, зохицуулалт хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд дараах асуудлуудыг дор дурдсан байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг

- өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлох, түүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулах;
2. Мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр бий болгох, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоох, хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг илүү дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлэх;
  3. Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр дэд бүтцийн олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгах;
  4. Хөрөнгийн зах зээл дээр технологийн дэвшилд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, энэ хүрээнд зохицуулалтын туршилтын орчин үүсгэх эрх зүйн орчныг нээлттэй болгохтой уялдуулан зохицуулагч байгууллагын эрхийг хуулийн хүрээнд нэмэгдүүлэх.
  5. Хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг тодорхой болгон тогтоох замаар зах зээл дээрх төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хооронд үүсэж буй чиг үүргийн давхардлыг арилгах;
  6. Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохицуулалтын дүрэм журмыг нэгтгэх, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.

**ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХҮНИЙ ЭРХ, НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ  
(Хүснэгт 1)**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгийн зах зээлийн харилцаанд тэгш, шударга байх зарчмыг баримтлан хуульчилна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй, ялгаварлан гадуурхах, эсхүл аль нэг бүлэгт давуу байдал олгох нөхцөл үүсгэхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцнэ.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо иргэд, аж ахуйн нэгжийг үнэт цаасны арилжаанд оролцох, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зардлыг багасгах, цаг хугацаа хэмнэх боломжоор хангах хувилбарыг сонгосон.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			

	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Зах зээлийн ил тод, шудрага байдал, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирснаар хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах, тэгш шударга байх зарчимд дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Бүрэн нийцнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудал нь холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт нь үнэт цаас худалдах, худалдан авах хөрөнгө оруулагчийн хүсэлтэд тулгуурласан харилцаан дээр явагдах тул хүний эрхийг хязгаарлахгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Зах зээлд оролцогч нь хуулийг санаатайгаар зөрчиж, хөрөнгө оруулагчийг эд хөрөнгийн хохирол учруулах, төлөх ёстой төлбөрийг төлөхгүй зугтах, зайлсхийж байгаа тохиолдолд хэрэглэгдэнэ.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-Дотоод болон гадаадын иргэн, хуулийн этгээдүүд -Зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох брокер, дилер, андеррайтер, арилжаа эрхлэгч байгууллага, төлбөр, тооцооны байгууллага, төлбөр гүйцэтгэгч банк, үнэт цаасны

				хадгаламжийн байгууллага
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлал байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгийн хэмжээ болон тодорхой шалгуурт үндэслэсэн ялгаатай зохицуулалтыг хийж байгаа ч зах зээлд оролцогчдын бүгдийн эрхийг хамгаалсан болон дээшлүүлсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ялгаварлал байхгүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-Дотоод болон гадаадын иргэн, хуулийн этгээдүүд -Зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох брокер, дилер, андеррайтер, арилжаа эрхлэгч байгууллага, төлбөр, тооцооны байгууллага, төлбөр гүйцэтгэгч банк, үнэт цаасны хадгаламжийн байгууллага
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хөндөж буй асуудал нь жендэрийн асуудлыг хөндөхгүй нийтэд тэгш эрх, боломжийг бүрдүүлсэн.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зах зээлд орлолцогчдыг хүйсээр үл ялгаварласан.

**ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 2)



Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй. Олон улсын хөрөнгийн зах зээлийн нийтлэг зарчмын дагуу зах зээлд оролцоно.
		1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Монголд орж ирэх хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх зорилготой зохицуулалтуудыг дэмжсэн.
		1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих, төгрөгийн ерийн хэрэгслийн зах зээлийн хөгжлийг дэмжих замаар дотоодын эдийн засаг гадны нөлөөллөөс авах эрсдэлийг багасгахыг зорьсон.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал		2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал		3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
		3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагч бий болгох, энэ дагуух зохицуулалтыг уян хатан болгосноор аж ахуйн

				нэгжүүдийн хувьд санхүүжилтийн урт хугацаат зардал багатай эх үүсвэр татахад чухал ач холбогдолтой.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн дагуу хөрөнгө оруулагчдад тухай бүр санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах үүрэг хүлээх боловч ингэснээр компанийн захиргааны зардлыг нэмэгдүүлэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт нь үнэт цаас худалдах, худалдан авах үндсэн харилцаан дээр явагдах учир төлбөрийн үүргээ биелүүлээгүй этгээдэд зохих журмын дагуу төлбөрийн үүргийг гүйцэтгэнэ. Хэрэв эс биелүүлэх буюу бусдад хохирол учруулбал хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ. Энэ нь хуулиар тогтоогдсон, хуулийн дагуу зайлшгүй төлөх төлбөрийн үүрэгтэй холбоотой шаардах эрхийг хэрэгжүүлэхэд чиглэх тул хүний өмчлөх эрхийг зөрчөөгүй болно.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, зардлыг багасгах тул хөрөнгө оруулагчид зах зээлд оролцох боломж улам нэмэгдэнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах тул ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зах зээл дээрх санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж буй учир жижиг дунд үйлдвэр болон аль нэг салбар хөгжих боломж улам нэмэгдэнэ.
	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эдийн засаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

9.Төрийн захиргааны байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	тул түүгээр дамжин төсвийн орлого нэмэгдэнэ.  Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Олон улсын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д үнэт цаасны DvP буюу Төлбөрийн эсрэг нийлүүлэлт хэрэгжүүлэгч чиг үүргийг, Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-д Дундын төв тооцооны зохицуулагч байгууллагын чиг үүргүүдийг шинээр бий болгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдал нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ. Хууль батлагдан гарснаар хөрөнгийн зах зээлд оролцох үйл явцыг хялбаршуулж, урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшил бизнесээ өргөтгөх, эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, улсын төсөвт татварын орлогыг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр дагавартай байх юм. Мөн хууль, эрх зүйн зохицуулалтын орчин сайжирснаар дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч нарын сонирхол нэмэгдэх, улмаар гадаадын шууд хөрөнгийн оруулалт нэмэгдэх, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн

				урсгал нэмэгдэх зэрэг эдийн засагт олон талын зэрэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Дотоод болон гадаад хөрөнгө оруулалтын орчин сайжирч, эдийн засаг болон зах зээлийн тогтвортой байдлыг дэмжинэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцэж байгаа.

**НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 3)

Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл		1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Зах зээл дэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, хувийн хэвшилд бизнесээ өргөтгөх чухал боломжууд нээгдэж, ажлын байр нэмэгдэх нөлөөтэй.
		1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх		2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мэдээлэл харилцан солилцох зорилгоор олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжийг суурилуулна.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл харилцан солилцох талаарх чиг үүргийг нэмэгдүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдана.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 4)

Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй



4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид "хуулийн төсөл" гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"<sup>2</sup>-д /цаашид "Аргачлал" гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>3</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Ойлгомжтой байдал;
5. Харилцан уялдаа зэрэг болно.

**Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

### 1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухай хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох

<sup>1</sup> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

<sup>2</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

<sup>3</sup>Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

## **2. Практикт хэрэгжих боломж:**

Хуулийн төсөлд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэл, зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбаршуулж, биржийн болон биржийн бус зах зээлийн ялгааг тодорхойлж, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоонд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон дэд бүтцийн байгууллагуудыг үйл ажиллагаатай холбогдох харилцааг тусгах, өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх үүргийн хүрээг ялгах, сайжруулах, хувьцаат компанийн мэдээллийн ил тод байдал, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Энэхүү зохицуулалтууд нь зохицуулагч байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, дэд бүтцийн байгууллага, үнэт цаасны компаниуд, үнэт цаас гаргагчдын зүгээс хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулах, төлбөр тооцооны зарчимд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны компани, хөрөнгө оруулагчдын хандлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

## **3. Ойлгомжтой байдал:**

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>4</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

## **4. Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг<sup>5</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь нийтэд арилжаалагддаг үнэт цаасны зах зээлийн харилцааг голчлон зохицуулж, санхүүгийн зарим хэрэгслийг биржийн бус зах зээл дээр хаалттай хүрээнд гаргах, баримтжуулах, холбогдох эрхийг бүртгэх, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын ялгааг гаргалгүй орхигдуулсан байгаа зэрэг нь хуулийг амьдралд хэрэгжүүлэхэд бодит хүндрэлүүдийг үүсгэсээр байна.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон бусад

<sup>4</sup>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>5</sup>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

зарим хуулиудтай давхардал, зөрчил, хийдэл үүсгэж тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалтгүй байна.

### **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн нэгдүгээр зүйл, хоёрдугаар зүйл.	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаанд төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор клирингийн гишүүн болон төлбөрийн баталгааны сангийн зохицуулалт, компанийн өрийн хэрэгсэл, үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээлд гаргах, нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэл, зөвшөөрлийн харилцааг хялбаршуулсан зохицуулалт.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

#### **1.Зорилгод хүрэх байдал**

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлийн зохицуулалтын харилцааг ялгаатайгаар тогтоох, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндсийг тогтоож, зохицуулагч байгууллага, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаас гаргагчдын эрх үүрэг, хариуцлагыг сайжруулан, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилтын хүрээнд Монгол Улсын эдийн засгийг хөгжлийг дэмжих зорилготой байна.

Энэ зорилгын хүрээнд дараах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ.

1. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлох, түүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулах;

2. Мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр бий болгох, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоох, хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг илүү дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлэх;

3. Монголын хөрөнгийн зах зээл дээр дэд бүтцийн олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгах;

4. Хөрөнгийн зах зээл дээр технологийн дэвшилд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, энэ хүрээнд зохицуулалтын туршилтын орчин үүсгэх эрх зүйн орчныг нээлттэй болгохтой уялдуулан зохицуулагч байгууллагын эрхийг нэмэгдүүлэх;

5. Хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг сайжруулан тогтоох замаар зах зээл дээрх төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хооронд үүсэж буй чиг үүргийн давхардлыг арилгах;

6. Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохицуулалтын дүрэм журмыг нэгтгэх, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

***Зорилт-1. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох, Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээг өргөтгөж, биржийн болон биржийн бус зах зээлийг ялгаатайгаар тодорхойлох, түүнтэй холбогдсон харилцааг нэмж зохицуулах***

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тус хуулиар зохицуулагдах үнэт цаасны төрөлд шинэ төрлүүд нэмсэн, 3 дугаар зүйлд биржийн болон биржийн бус зах зээлийн нэр томъёоны тодорхойлолтыг ялган тодорхойлж, үнэт цаасны бүртгэлийг ялгаатайгаар тогтоосон байна.

Эндээс үзэхэд тус хуулийн төслөөр нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэл, зөвшөөрлийг хялбаршуулж, хаалттай хүрээнд гаргах үнэт цаас болон нээлттэй хувьцаат компанийн гаргах үнэт цаасны бүртгэлийг хялбаршуулсан журмаар гаргахаар тогтоож, биржийн бус зах зээлтэй холбогдох эрх зүйн үндсийг тодорхойлсон гэж дүгнэж байна.

***Зорилт-2. Мэргэжлийн, урт хугацаат хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр бий болгох, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатай тогтоох, хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг илүү дэмжсэн зохицуулалтыг бүрдүүлэх***

- Хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт тус хуулиар зохицуулагдах хөрөнгө оруулалтын санг хамтын хөрөнгө оруулалтын сан болгож өөрчилсөн, мөн тус хуулийг дагалдан өөрчлөгдөх хуулийн төслөөр Хөрөнгө оруулалтын сангийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг ялгаатайгаар зохицуулсан байна.

***Зорилт-3. Монголын хөрөнгийн зах зээл дээр дэд бүтцийн олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгах***

- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт үнэт цаасны тооцооны үйл ажиллагааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нийцүүлэн клирингийн болгон өөрчилж, мөн олон улсын төлбөр тооцооны зарчим болон төлбөрийн эсрэг нийлүүлэлттэй холбоотойгоор зах зээл дээр шинээр клирингийн гишүүн байгууллага бий болгох, тэдний эрсдэлийг удирдах зорилгоор төлбөрийн баталгааны санг үүсгэх, төлбөр тооцоог эцэслэн гүйцэтгэх зэрэгтэй холбогдсон харилцааны зохицуулалтыг тусгажээ.

***Зорилт-4. Хөрөнгийн зах зээл дээр технологийн дэвшилд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, энэ хүрээнд зохицуулалтын туршилтын орчин үүсгэх эрх зүйн орчныг нээлттэй болгохтой уялдуулан зохицуулагч байгууллагын эрхийг нэмэгдүүлэх***

- Хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны эрх үүрэг дээр үнэт цаасны зах зээлд технологийн дэвшилд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотойгоор зохицуулалтын туршилтын орчин үүсгэх, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх нэмж өгсөн байна.

***Зорилт-5. Хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг сайжруулан тогтоох замаар зах зээл дээрх төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хооронд үүсэж буй чиг үүргийн давхардлыг арилгах***

- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт өөрийгөө зохицуулах байгууллагын төрлийг ялгаатайгаар тогтоож, түүний эрх үүргийн хүрээг өөрчлөн тогтоосноор өөрийгөө зохицуулах байгууллагын үүрэг тодорхой болж, төрийн зохицуулагч байгууллагын зарим үүргийг хөнгөвчлөх зохицуулалтыг тусгажээ.

***Зорилт-6. Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохицуулалтын дүрэм журмыг нэгтгэх, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах***

- Хуулийн төслийн 2 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үүрэг хариуцлага дээр компани бүх төрлийн үнэт цаас эзэмшигчдэд бодит өөрчлөлт бүхий нөлөө үзүүлэх мэдээллийг зохицуулагч байгууллагаас гаргасан журмын дагуу тухай бүр мэдээлэх үүрэг нэмж тусгасан.

**Практикт хэрэгжих боломжтой эсэх:**

Төслийн 1,2,3 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорилгоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Сангийн яамнаас 2019.10.09-ний өдөр Санхүүгийн салбарын бодлого боловсруулагчид, зохицуулагч байгууллага, салбарын мэргэжлийн холбоод болон зах зээлд оролцогчдын төлөөллүүдийн хооронд “Банкнаас бусад санхүүгийн салбарыг тэнцвэртэйгээр хөгжүүлэх, түүний өнөөгийн тулгамдсан асуудлуудыг ярилцах, шийдэл гаргах” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт оролцогчид Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд доорх асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй гэдэг дээр нэгдсэн санал дүгнэлтэд хүрээд байна. Үүнд:

- Засгийн газрын дотоод үнэт цаасыг Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.3-д заасан зориулалт буюу Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих зориулалтаар гаргах, зах зээлийн суурь хүүгийн өгөөжийн муруйг тогтоох;
- Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын систем болон төлбөр тооцооны горимыг олон улсын стандартад нийцүүлэн, төлбөрийн эсрэг нийлүүлэлт, дундын зохицуулагч байгууллага, төлбөрийн баталгааны сан, клирингийн гишүүн, төлбөрийн чадваргүйдлийн удирдлагын зохицуулалтыг холбогдох хууль, эрх зүйн орчинд тусгах;
- Зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчид буюу урт хугацаат хөрөнгө оруулагчид бий болгох, ингэхдээ хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх. Одоо байгаа нөөц боломжоо ашиглан хөрөнгийн зах зээлд урт хугацаат хөрөнгө оруулагчийг бий болгох. Үүнд: Хувийн даатгалын сангийн хөрөнгө, нийгмийн даатгал сангийн хөрөнгө, даатгалын компаниудын нөөц санг хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах сувгийг нээж өгөх;
- Компанийн өрийн хэрэгслийн хаалттай болон нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг хөгжүүлэх, ингэх нь дотоодын хувийн аж ахуйн нэгжүүдэд урт хугацаат хөрөнгө оруулалт татах маш том гарцыг бий болгох юм. Үүнтэй холбогдуулан компанийн зээлжих зэрэглэл тогтоох байгууллага, үйлчилгээг бий болгох;
- Хөрөнгийн зах зээлд оролцох шат дамжлага, шимтгэл хураамжийг бууруулах.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болох брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх болон менежментийн компаниуд, хөрөнгийн биржүүд, төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагууд, кастодиан банкнууд, мэргэжлийн холбоод зэрэг байгууллагуудын төлөөллийг хамруулан “Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох” хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулж, хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн талаар санал солилцсон.

Үүнээс гадна салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагын талаар хамаарал бүхий этгээдүүдээс албан бичгээр санал авсан бөгөөд хэлэлцүүлэг болон албан бичгээр хүлээн авсан саналуудыг нэгтгэн дүгнэвэл, хуулийг шинэчлэн боловсруулах дараах практик шаардлага үүсжээ. Үүнд:

- Зохицуулалттай үйл ажиллагаа, тэдгээрийн онцлог, ялгаа, үйл ажиллагааны хүрээг тодорхой болгох;
- Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудын хариуцах асуудлын хүрээг ялгаатай тогтоох;

- Өрийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах, хязгаарлалтыг багасгах;
- Дэд бүтцийн байгууллагуудын гишүүддээ тавих хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагын харилцан уялдаа, хариуцан хэрэгжүүлэх эрх хэмжээг илүү тодорхой болгох саналуудыг ирүүлсэн.

Үүнээс үзэхэд хөрөнгийн зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлийн харилцааг ялгаатайгаар тогтоох, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндсийг тогтоож, зохицуулагч байгууллага, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаас гаргагчдын эрх үүрэг, хариуцлагыг сайжруулан, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад зохих өөрчлөлтийг хийх нь зүйтэй гэж дүгнэв.

### **3. Ойлгомжтой эсэх**

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалд санал авахаар Засгийн газрын бүх гишүүд /13 яамд/-ээс санал авах тухай албан бичгийг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын хамтаар хавсарган хүргүүлж, санал авсан.

Яамдаас ирүүлсэн саналаас хуулийн төслийн үзэл баримтлалын ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад хуулийн төсөлд холбогдох саналыг тусган оруулсан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хөрөнгийн зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлийн харилцааг ялгаатайгаар тогтоох, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндсийг тогтоож, зохицуулагч байгууллага, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаас гаргагчдын эрх үүрэг, хариуцлагыг сайжруулан, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн суурь зохицуулалтыг агуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дугаар зүйлд зааснаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн 5 зүйлтэй хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Хуулийн төсөлд холбогдох мэргэжлийн холбоо, дэд бүтцийн байгууллага, үнэт цаасны компаниудаас ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн



томъёоллын ойлгомжтой байдал, логик уялдааг сайжруулах тал дээр ирүүлсэн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

#### 4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал

Тус шалгуурын хүрээнд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд олон улсын төлбөр тооцооны төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчим нэвтрүүлэх, түүний зохицуулалтыг сонгож авсан.

Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ын хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний 2.2.4-т “Арилжааны төлбөр тооцооны системийн олон улсын стандартад нийцсэн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, өргөжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ” гэж тусгасан. Мөн Сангийн яам 2017 онд нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (цаашид ЕСБХБ гэх )-тай хамтран “Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн үнэлгээ”-ний төслийг хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд богино хугацаанд нэн тэргүүнд яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээний зөвлөмжийг өгсөн. Энэ нь нэгдүгээрт, “Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах”, хоёрдугаарт, “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд Олон улсын төлбөр тооцооны суурь зарчим болох DvP/T+2 буюу Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ Төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 дахь өдөрт гүйцэтгэх” зарчмыг нэвтрүүлэх зөвлөмж юм.

Үүнтэй холбогдуулан энэ хуульд хамрагдах ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц заалтыг доорх хүснэгтээр авч үзье.

	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Хөрөнгө оруулагчид (гадаадын болон дотоодын иргэн, хуулийн этгээд)	<p>Хөрөнгө оруулагчдын эрх ашигт эергээр нөлөөлнө.</p> <p>1. Одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчинд үнэт цаас (хувьцаа, бонд) өмчлөгчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт муу байна. Хөрөнгө оруулагчид үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд оруулсан хөрөнгө оруулалтаа хэрхэн нэхэмжлэх талаар зохицуулалт тодорхойгүй байгаагаас энэ зах зээлд орох итгэл төрдөггүй байна.</p> <p>2. Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор хуульд оруулах өөрчлөлт нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтсон стандартын дагуу тогтмол авах давуу тал үүснэ.</p> <p>3. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/T+2</p>

		<p>горим” олон улсын зарчим нэвтэрснээр үнэт цаасны арилжаанд оролцохдоо өмнө нь төлбөрөө урьдчилж байршуулдаг байсан бол одоо эрсдэлийн маржингийн тодорхой хувийг урьдчилж үлдсэн төлбөрийг арилжаа явагдсанаас хойш 2 хоногийн дараа байршуулдаг болох юм. Энэ нь хөрөнгө оруулагчид мөнгөн хөрөнгөө олон хоног нэг дансанд үр ашиггүй байршуулж мөнгөний үнэ цэнийг алдагдуулах эрсдэлээс сэргийлж төлбөрөө төлсөн даруйдаа үнэт цаасаа өмчлөх давуу эрхийг олгох юм.</p>
2	Үнэт цаас гаргагч	<p>1. Компанийн биржийн зах зээл дээр үнэт цаасыг олон нийтэд нээлттэй гаргах, түүнийг зохицуулагч байгууллага болон арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг хялбаршуулсан. Ингэснээр үнэт цаас гаргагч хувьцаагаа олон нийтэд санал болгоход цаг хугацаа хэмнэх, шат шатны зөвшөөрөл зохицуулагч байгууллагаас авах, түүний хүнд суртал арилах зэрэг ач холбогдолтой юм.</p> <p>2. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр биржийн болон биржийн бус зах зээлийн тодорхой бус зохицуулалтын орчныг сайжруулах ба ингэснээр үнэт цаас гаргагч өөрсдийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн зах зээл, хөрөнгө оруулагчдын бүлэг, үнэт цаасны төрлөө сонгох өргөн боломж нээгдэх юм.</p> <p>3. Хуулийн төсөлд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах үүднээс мэдээллийн ил тод байдлыг зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагын дагуу мэдээлж байх үүргийг оруулж өгсөн. Энэхүү зохицуулалт орсноор хувьцаат компаниуд болон үнэт цаас гаргагч хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх, үүргээ биелүүлдэггүй үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахгүй байх зэрэг сонголт хийнэ. Ингэснээр цаашид хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн үнэт цаас гаргагч нь бага хүүтэйгээр санхүүжилт татах итгэлцэл зах</p>

		зээл дээр үүсэх, зах зээл хөгжих чухал ач холбогдолтой юм.
3	<p>Зах зээл дээр зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд</p> <p>(брокер, дилер, андеррайтер, арилжаа эрхлэгч, арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэгч, арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэгч, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч, төлбөр мэргэжлийн холбоод гэх мэт...)</p>	<p>1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд "Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/Т+2 горим" олон улсын зарчим нэвтрэхтэй холбоотойгоор үнэт цаасны арилжаанд оролцоход хөрөнгө оруулагч мөнгөн төлбөрийг 100 хувь урьдчилж байршуулдаг байсан системийг хална. Ингэснээр үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 өдрийн дараа гүйцэтгэхтэй холбоотойгоор дэд бүтцийн байгууллагууд болох үнэт цаасны тооцооны, төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, үнэт цаасны брокерын компаниудад харилцагчдын төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, үүнтэй холбоотойгоор зах зээлд төлбөрийн баталгааны сан байгуулах зэрэг нэмэлт үүргүүд үнэт цаасны компаниуд болон тооцоо эрхлэх байгууллага, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орох юм.</p> <p>2. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг үр ашигтай болгох, арилжаа эрхлэгч байгууллага болон зохицуулагч байгууллагын бүртгэлийн үйл ажиллагааг үр ашигтай давхардалгүй болгох хүрээнд үнэт цаас гаргах үйл ажиллагааг хялбаршуулж байгаатай холбогдуулан арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны амжилттай болсон. Байдалд хяналт хийх, дүгнэлт гаргах, мөн зах зээлийг урвуулан ашиглах, хөрөнгө оруулагчдыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ болох арилжаа зогсоох чиг үүргийг арилжаа эрхлэх байгууллагад шинээр өгөхтэй холбогдуулан тэдний үүрэг, хариуцлага нэмэгдэх.</p> <p>3. Одоо мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь биржийн зах зээлийн үйл ажиллагааг голчлон зохицуулж байгаатай холбогдуулан биржийн бус зах зээлийн харилцаа, түүн дээр гарах бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих эрх зүйн</p>

	зохицуулалт дутагдаж байсан. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр биржийн болон биржийн бус зах зээлийн зохицуулалтын ялгааг гаргаж өгсөнтэй холбогдуулан зохицуулалттай этгээдүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд цаашид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломж шинээр нээгдэж байгаа болно.
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:**

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад хуулиас иш татсан байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 9 хуулийн төслийг боловсруулсан байна.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Зөрчилтэй зохицуулалт илэрснийг өмнө дурдсан.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм	Хяналтаар төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх зохицуулалт илрээгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тогтоогоогүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.

	зохицуулалт тусгасан эсэх;		
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо зөрчилдөөгүй байх бөгөөд үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

### **4.1. Үнэлэлт, дүгнэлт**

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгын дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>6</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх үйл ажиллагааг дэмжин, нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэл, зөвшөөрлийг хялбаршуулж, төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн горимыг нэвтрүүлэх, түүнтэй холбогдсон харилцааг шинээр зохицуулж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжих чиглэлд тодорхой зохицуулалт тусган боловсруулжээ.

Төсөлд тусгасан зарим шинэ харилцаа нь Монгол Улсад анх удаа хуульчлагдаж байгаа тул холбогдох бусад хуулиудын уялдаа холбоог хангах, мөн зохицуулагч байгууллагын батлах дүрэм, журмууд нь хуультай уялдан боловсруулахад анхаарах нь чухал юм.

Мөн хуулийн зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөж биржийн болон биржийн бус зах зээлийг томьёолсон нь шинэчлэлийн мөн чанарыг илэрхийлнэ.

### **4.2. Зөвлөмж**

Улс орны эдийн засгийн хөгжил нь хувийн хэвшлийн бизнесийн тэлэлт, хөгжилтэй шууд хамааралтай тул хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг илүү нээлттэй, зохистой болгож өгөх нь эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм. Иймд салбарын хууль эрх зүй судлаач эрдэмтэд өөрсдийн санал дүгнэлтийг гаргах нь хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой гэсэн зөвлөмжийг өгч байна.

<sup>6</sup>Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### **Хууль**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013

Зөрчлийн тухай хууль 2016

### **Бусад**

Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зардлын тооцоог хийлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилт нь хөрөнгийн зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлийн харилцааг ялгаатайгаар тогтоох, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндсийг тогтоож, зохицуулагч байгууллага, дэд бүтцийн байгууллага, мэргэжлийн байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаас гаргагчдын эрх үүрэг, хариуцлагыг сайжруулан, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах болно. Энэхүү тооцоололд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллага, үнэт цаасны компани, хөрөнгө оруулагчид хуулийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд болон татварын албаны зардлыг тооцсон болно.

### Нэг. Хуулийн этгээдийн зардлыг тооцох

Хуулийн этгээдийн зардлыг Аргачлалд зааснаар дараах байдлаар тооцов. Үүнд:

#### 1.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төсөлд заасны дагуу хуулийн этгээд буюу үнэт цаасны компани нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Клирингийн гишүүн нь төлбөр тооцоог дараа төлбөрт горимоор гүйцэтгэхтэй холбоотойгоор үнэт цаасны арилжаанд оролцохдоо харилцагчдын захиалгын 30 хувийг барьцаа хэлбэрээр клирингийн төвд шилжүүлнэ;
- Клирингийн гишүүд нь төлбөрийн баталгааны санд улирал бүр хураамж төлнө.

#### 1.2.зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо үнэт цаасны компаниудын 2021 онд хөрөнгийн биржээр дамжуулан хийсэн арилжааны дүнгийн үзүүлэлтэд үндэслэж хийсэн. Клирингийн гишүүний үнэт цаасны арилжаанд оролцох барьцааг тооцох ажилтны сарын дундаж зардлыг 1 000 000 төгрөг байна гэж төсөөлөв. Ажиллах хугацааг энэ аргачлалын “хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар”-т заасны дагуу дор үзүүлсэн хүснэгтээр тооцон үзэхэд дараах байдалтай байна:

№	Ерөнхий үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Клирингийн гишүүний үүрэгтэй танилцах, судлах	10.0	12.0	15.0
2	Харилцагчтай байгуулах гэрээний төсөл боловсруулах	10.0	12.0	15.0



3	Үнэт цаасны мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны системийн шаардлагыг тодорхойлох	60.0	72.0	90.0
4	Үнэт цаасны компаниудын систем дээрх хөгжүүлэлт	60.0	72.0	90.0
5	Мэдээлэл, өгөгдөхүүнийг боловсруулах	30.0	36.0	45.0
6	Алдааг засах	30.0	36.0	45.0
7	Тоо баримтыг боловсруулах	10.0	12.0	15.0
8	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	10.0	12.0	15.0
9	Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
10	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
11	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	10.0	12.0	15.0
12	Олшруулах, архивлах, тараах	5.0	6.0	7.5
13	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	5.0	6.0	7.5
14	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	-	-	-
15	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	-	-	-
16	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	-	-	-
	<b>Нийт</b>	<b>240.0</b>	<b>288.0</b>	<b>360.0</b>

Сард 168 ажлын цаг, улиралд 504 ажлын цаг байна гэж үзэж (тайланг улиралд нэг удаа татварын албанд хүргүүлнэ), холбогдох тооцоог хийв.

Ажлын хөлс нэг цагт =  $1\ 000\ 000/168 = 5\ 952.4$  төгрөг

Зардал (тус бүрийн)=Хугацаа × Ажлын хөлс =  $5\ 952.4 * 4$  цаг = 23 809.5 төгрөг болно.

### 1.3.тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт = тохиолдлын тоо \* давтамжийн тоо

Тохиолдлын тоо = 66 (клирингийн тооцоолол) \* 4 (улирал бүр) = 264

### 1.4.нийт зардлыг тооцох

Нийт зардал = зардал \* тоон үзүүлэлт =  $23\ 809.52$  төгрөг \* 264 = 6 285 713.2 төгрөг (жилд)

**Хууль хэрэгжиж эхэлснээр үнэт цаасны клирингийн төв нь үнэт цаасны компаниудын арилжааг арилжаа тус бүрээр бүс цэвэршүүлсэн дүнгээр хийх түл арилжааны тоо болон шимтгэлийн зардал буурах ач холбогдолтой.**

### 1.5.хялбарчлах боломж

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлтэй холбоотойгоор хуулийн этгээдийн зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгууруудаар тодорхойлж үзлээ. Үүнд:

- **хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:** Хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцооны системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ дараа төлбөрт горимд шилжихтэй холбоотойгоор клирингийн төв болон түүний гишүүн байгууллагуудыг үүсгэнэ. Ингэснээр хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд оролцох шат дамжлага болон зардал шимтгэл буурах өндөр ач холбогдолтой тул хамрагдах үнэт цаасны компаниуд буюу хуулийн этгээдийн тоог бууруулах боломжгүй юм;
- **мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** Хөрөнгийн биржийн арилжаа нь өдөр бүр 10:00-13:00 цагийн хооронд явагдах бөгөөд хөрөнгө оруулагчид тэр хэрээр өдөр бүр арилжаанд оролцох, нөгөө талаас үнэт цаасны компаниуд болон дэд бүтцийн байгууллагууд арилжааны тасралтгүй найдвартай байдлыг ханган ажиллах үндсэн үүргүүдийг хүлээдэг. Иймд арилжааны тохиолдол бүрд боловсруулах мэдээллийн агуулдаг болон давтамжийг бууруулах боломжгүй боловч мэдээллийг бэлтгэх системийг автоматжуулснаар хуулийн этгээдийн зардлыг хэмнэх бүрэн боломжтой юм;
- **шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** хуулийн этгээдэд шинээр хүлээх үүргийг 100 хувь автоматжуулах боломжтой бөгөөд үнэт цаасны компанийн зүгээс харилцагчдын эрсдэлийг үнэлэх ажлыг урьд өмнө гүйцэтгэж байсан үүрэгтэй нэгтгэх боломжтой юм;
- **мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Хуулийн этгээдийн бэлтгэх мэдээлэл болон мэдээлэл солилцох үйл ажиллагаа бүгд цахимаар гүйцэтгэгдэх болно;
- **мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:** Мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоо нь төрийн зохицуулагч байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо болон дэд бүтцийн 3 байгууллага тул багасгах боломжгүй;
- **нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх:** Харилцагчид болон дэд бүтцийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох, хүргэх тул нэг цэгийн үйлчилгээ бий болгох шаардлагагүй.

#### **1.6.нэмэлт зардлыг тооцох**

Хууль хэрэгжиж эхэлснээр үнэт цаасны клирингийн төв нь үнэт цаасны компаниудын арилжааг арилжаа тус бүрээр бус цэвэршүүлсэн дүнгээр хийх тул арилжааны тоо болон шимтгэлийн зардал буурах ач холбогдолтой.

#### **Хоёр. Иргэний зардлыг тооцох**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэний зардал гарахгүй бөгөөд арилжаанд оролцох шат дамжлага, шимтгэл улам бүр буурна.

#### **2.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн дагуу хувь хүн дараах үүргийг гүйцэтгэнэ:

- үнэт цаасны компаниудтай харилцагчийн гэрээ анхлан байгуулахдаа харилцагчийн эрсдэлийг үнэлүүлэх зорилгоор өөрийн банкны дансны хуулгыг хүргүүлнэ.

## 2.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо иргэдийн үнэт цаасны компанитай харилцахад үүсдэг харилцаанд үндэслэж хийсэн бөгөөд дараах хугацааг зарцуулна гэж төсөөлөв.

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Үнэт цаасны компанийн гэрээтэй танилцах	10.0	12.0	15.0
2	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас)	-	-	-
3	Маягт, өргөдөл, гэрээ бөглөх	10.0	15.0	20.0
4	Мэдээллээ холбогдох газарт илгээх	1.0	1.2	1.5
5	Төлбөр хийх	1.0	1.2	1.5
	Нийт	22.0	29.4	38

## 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

$$1 = 1 \text{ (гэрээ хийх тоо)} \times 1 \text{ (давтамж)}$$

## 2.4.нийт дүнг тооцож гаргах;

Ачаалал=Цаг хугацаа × Тоон үзүүлэлт

$$0,3 \text{ цаг} = 0,3 \text{ цаг} \times 1 \text{ гэрээ}$$

Нийт зардал= ачаалал × зардал =  $0,3 * 5 952.4$  (цагийн хөлсний өмнөх жишгийг баримтлав) = 1 785.7 төгрөг

## 2.5.хялбарчлах боломжийг шалгах

Хувь хүний гаргах зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгуураар тодорхойлов. Үүнд:

- **хамрагдах иргэний тоог багасгах боломж байгаа эсэх:** хөрөнгийн зах зээл нь хөрөнгө оруулагчдын хүсэл, сонирхол дээр тулгуурлан явагддаг тул хуулийн хэрэгжилтэд хамрагдах иргэдийн тоог зохицуулах, бууруулах боломжгүй юм;
- **мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхэлснээр үнэт цаасны компаниудын төлбөр тооцооны системийг автоматжуулах үйл ажиллагаа явагдан мэдээллийн давтамжийг автоматжуулах багасгах боломжтой юм;
- **шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** шинээр үүсгэх үүрэг нь урьд байсан үүргийг улам хялбаршуулсан тул нэгтгэх нь зохисгүй юм;

- **мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхэлснээр үнэт цаасны компаниудын үйлчилгээ, үйл ажиллагаа автомат системээр явагдан мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой юм;

## **2.6.нэмэлт зардлыг тооцох**

Хууль хэрэгжиж эхэлснээр хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох шат, дамжлага, зардал буурна.

## **Гурав. Төрийн байгууллагын зардлыг тооцох**

Төрийн өмчит хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд хуулийн дагуу зохих өөрчлөлтийг одоо байгаа нөөц бололцооны хүрээнд зохицуулан ажиллах ба нэмэлт зардал гарахгүй болно.

### **3.1.байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох:**

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иуд нь хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь үнэт цаасны клирингийн төв болж үнэт цаасны клирингийн гишүүн байгууллагын клирингийг цэвэршүүлсэн дүнгээр тооцоолно.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компани нь үнэт цаасны төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.

### **3.2.ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох**

Одоогийн байдлаар байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК дээр 39 ажилчид, Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК дээр 13 ажилчид байгаа үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааг эрхлэн ажиллаж байна. Энэхүү мэдээлэлд үндэслэн хуулийг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсон болно.

Хуулийн төсөлд Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь клирингийн гишүүдийн эрсдэлийг удирдах зорилгоор төлбөрийн баталгааны сан байгуулан түүнийг удирдахаар тусгасан бөгөөд сангийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлбөрийн баталгааны сангийн удирдах хороог холбогдох байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулах юм.

### **3.3.гарах зардлыг урьдчилан тооцох;**

Эдгээр дэд бүтцийн байгууллагууд хуулийг хэрэгжүүлэхдээ хүний нөөцийн дотоод зохион байгуулалт хийж, бусад материаллаг зардлыг нэмэхгүй одоогийн хэмжээнд барьж ажиллах боломжтой.

### **3.4.зардлыг нэгтгэн тооцох**

Нийт зардал = (хүний нөөцийн зардал + бусад зардал) × хүний нөөцийн хэрэгцээ = 6 285 713.2 төгрөг+1 785.7 төгрөг төгрөг = 6 287 498.9 төгрөг.


### **3.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах**

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд олон улсын төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, үүнтэй холбогдох харилцааны зохицуулалтыг тусгасан. Үүнээс үүдэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх зардал одоогийн хэмжээнээс буурна.


# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН, ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА, САНАЛЫН ТОВЬЁГ

- I. Хууль санаачлагч хуулийн төслийг өөрийн цахим хуудсанд байршуулж санал авсан тухай


Хууль тогтоомжийн тухай хуулийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд 2021 оны 5 дугаар сарын 24-ны өдөр байршуулж олон нийтээс санал авсан. Ийнхүү санал авхад Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан хуулийн төсөлд иргэн Түвшинтөрөөс цахим хуудсанд 1 саналыг албан ёсоор ирүүлснийг саналын товьёг хэсэгт тусгав.



## Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөлд нэмэлт, оорчлолт оруулах тухай хуулийн төгөл



БИРЭМ ТУХАЙ	ЗЭВЖЛҮҮЛЭЛТЭЙ САНАА	МЭДЭЭ, МЭДЭЭГЭЙ	ХЭМЛЭЛТ, ШАГААЛ	МЭГЭВ УГААЛАЙ ТӨМӨД	СУДАЛГАА ТӨМ	ӨЗГӨШЛӨГ	ИГТЭД БАРДАЛ	ТАВЬ ГҮСЛЭХ	ХӨЛӨӨ БАРХ
ХУУЛЬ "УРМЫН ӨСӨЛД САНАА АВАХ									1304
									1304
									1304
									1304
									1304
									1304
									1304
									1304
									1304
									1304



Байгууллага/ Нэр	Огноо	Санал	Саналыг тусгасан байдал
Иргэн Түвшинтөр	2021.06.06	24 дүгээр зүйлийн 24.1.13 дахь заалтын "хөрөнгө оруулалтын менежментийн" гэсний өмнө "хамтын" гэж оруулах саналыг гаргаж байна. Үндэслэл: Хуулийн төслийн 24.1.12 дахь өөрчлөлт маш чухал	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагалдах



	<p>өөрчлөлт бөгөөд хувийн ХОС-ийн үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаанд хамааруулдаггүй ОУ-ын жишгийг дагасан, хувийн ХОС-ийн үйл ажиллагааг сэргээхэд маш чухал зохицуулалтын дэмжлэг болохоор байна. Хуулийн дээрх өөрчлөлттэй адилаар олон нийтээс санхүүжилт татаж байгаа хамтын сангийн ХОМК-ийн бүртгэл, зохицуулалт болон зөвхөн хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татаж байгаа хувийн сангийн ХОМК-ийн бүртгэл, зохицуулалт мөн ялгаатай байдаг олон улсын зохицуулалтын жишгийг дагасан өөрчлөлтийг оруулах шаардлагатай гэж үзэж байна. Иймд хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.13 дахь заалтын "хөрөнгө оруулалтын менежментийн" гэсний өмнө "хамтын" гэж оруулах саналыг гаргаж байна. Тайлбар: Хувийн ХОС-ийн ХОМК-ны үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаанд хамааруулахгүйгээр зөвхөн Хороонд бүртгүүлснээр хувийн ХОС үүсгэн байгуулах боломжийг олгох нь ХОС хөгжсөн АНУ, Хятад зэрэг улсуудын хувийн ХОС-ын зохицуулалттай нийцэж ОУ-ын зохицуулалтын жишигт хүрэхээр байна. АНУ, Хятад зэрэг хувийн ХОС өндөр хөгжсөн улсуудад хувийн сангийн менежерийг бүртгэхэд хамтын сангийн менежер тавьдаг шаардлага, шалгуурыг тавьдаггүй тусад бүртгэж зохицуулдаг. Учир нь хувийн сангийн менежер нь зөвхөн хаалттай хүрээнд, эрсдэлээ үүрэх чадвартай мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татаж үйл ажиллагаа явуулдаг учир олон нийтээс хөрөнгө татаж үйл ажиллагаа явуулдаг хамтын сангийн менежер шиг хатуу шалгуур тавилгүй зах зээлийнх нь өөрийн эрэлт нийлүүлэлтийн зарчмаар</p>	<p>хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт боловсруулагдсан. Одоо мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг нийтлэг байдлаар зохицуулсан байгаа тул хувийн хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагаа явуулахад зохицуулалтын маш олон шаардлага олон нийтээс хөрөнгө оруулалт татдаг хамтын хөрөнгө оруулалтын сантай адил байгаа нь дарамт болж байна. Иймд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн</p>
--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

		<p>зохицуулсан байдаг. Одоогийн СЗХ-ны хувийн ХОС-ын зохицуулалт нь энэхүү хувийн болон хамтын сангийн зохицуулалтын ялгааг ойлголгүй, хувийн болон нээлттэй сангийн үйл ажиллагааг ижил нэг төрлийн санхүүгийн үйл ажиллагаа мэтээр ойлгон зохицуулсан нь хувийн ХОС хөгжихөд маш том саад болсоор ирсэн билээ. Ингэж хувийн болон хамтын сангийн ХОМК-нд ижил шаардлага, шалгуур тавьж байгаа нь хувийн компанийн гаргаж байгаа хаалттай бонд болон биржид бүртгэлтэй нээлттэй компанийн олон нийтэд гаргаж байгаа нээлттэй бондыг бүртгэхэд нэг ижил шалгуур тавьж байгаа яг ижил зүйл юм. Хэрвээ хаалттай бондод хувьцаат компанийн гаргаж байгаа нээлттэй бондтой адил шаардлага, шалгуур тавих юм бол бондын зах зээл, хөрөнгийн зах зээл ямар байдалд орох байсныг Та бүхэн бодож үзэж хаалттай сангийн ХОМК-ийн зохицуулалтыг олон улсын жишигт хүргэж салбарын хөгжил, улсын эдийн засаг, хувийн хэвшлийн хөгжлөө дэмжинэ гэдэгт итгэж байна. Саналыг тусган авч салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Баярлалаа.</p>	<p>зохицуулалтыг ялгаатайгаар зохицуулж өөрчилхөөс гадна гэрээний үндсэн дээр хувийн хөрөнгө оруулалтын санг байгуулах зохицуулалтыг нэмж тусгасан. Харин хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувьд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг удирдах байгууллага тул хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын менежментийн компани гэж ялгах боломжгүй бөгөөд энэ тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгө эрсдэлд орох аюултай тул саналын тусгах боломжгүй байна.</p>
--	--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

II. Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан тухай

## Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын бодлогыг тодорхойлох хэлэлцүүлэг

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад дагалдах хуулиудад нэмэлт өөрчлөлт орох тухай хуулийн төслүүдийг хөрөнгийн зах зээлийн бодлого боловсруулагч Сангийн яамны зүгээс зохицуулагч байгууллагатай хамтран нийт зах зээлд оролцогчдын дунд 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Сангийн яамны Түшээ танхимд хэлэлцүүлэг зохион байгуулж хуулийн төслүүдэд санал авч нэгтгэн боловсруулан ажилласан.

Хэлэлцүүлгийн үеэр дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал
2. Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга
3. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн талаар
4. Үнэт цаасны зах зээлийн хөгжилд Засгийн газрын үнэт цаасны оруулах хувь нэмэр

ХУУЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛ, ҮР ДҮН

Хуулийн хэлэлцүүлгийн үр дүнд оролцогчдоос хууль эрх зүйн орчныг тогтвортой уян хатан байлгах, Хороо болон Биржийн давхардсан хяналтын тогтолцоог хялбарчлах, гэрээний үндсэн дээр байгуулагдах хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг бий болгох, арилжааны шимтгэл хураамжийг багасгах, дэд бүтцийн системүүдийг төрийн зүгээс нэгдсэн бодлогоор зохицуулах болон зах зээл дээр бий болгох шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хөшүүргийг хэрэгжүүлэх зэрэг саналууд гарсан бөгөөд зарим саналыг хуулийн төсөлд болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулахаар төлөвлөн ажиллаж



буй Санхүүгийн салбарыг хөгжүүлэх 2022-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

	Байгууллага/ Нэр	Огноо	Санал	Саналыг тусгасан байдал
1	Мандал хамтын хөрөнгө оруулалтын сан-Ганзориг	2022.10.07	Хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангуудын зохицуулалтыг ялгаатайгаар зохицуулах саналтай байна. Зохицуулалтууд ямар явж байгаа вэ?	Санал дараах байдлаар тусгагдсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

				<p>тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт боловсруулагдсан. Одоо мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг нийтлэг байдлаар зохицуулсан байгаа тул хувийн хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагаа явуулахад зохицуулалтын маш олон шаардлага олон нийтээс хөрөнгө оруулалт татдаг хамтын хөрөнгө оруулалтын сантай адил байгаа нь дарамт болж байна. Иймд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хамтын болон хувийн хөрөнгө</p>
--	--	--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

				<p>оруулалтын сангийн зохицуулалтыг ялгаатайгаар зохицуулж өөрчилхөөс гадна гэрээний үндсэн дээр хувийн хөрөнгө оруулалтын санг байгуулах зохицуулалтыг нэмж тусгасан.</p>
2	<p>Үнэт цаасны компанийн төлөөлөл</p>	2022.10.07	<p>ҮЦЗЗТХ 36.17. Номинал дансны зөвшөөрөл Хорооноос өгдөгийг болиулах саналтай байгаа Хяналтаа хийгээд явуулах саналтай байна Клирингийн байгууллагаар дамжуулж хянамаар байна</p>	<p>Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 383 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг баталсан. Зохицуулалттай этгээд нь үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх тохиолдолд Хорооноос зөвшөөрөл авах шаардлагатай байсныг өөрчлөн, холбогдох шаардлагыг хангасан зохицуулалттай этгээд тус үйлчилгээг үзүүлэх боломжтой</p>

				байдлаар тус журмын шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулсан.
3	Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-ийн төлөөлөл	2022.10.07	Арилжаа эрхлэх байгууллагууд шимтгэлээ өөрөө тогтоох боловч Хороо дээд хэмжээг тогтоодог- Энийг болиулж болох уу?	Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй байхаар тогтоосон. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд төрийн зохицуулагч байгууллагын хувьд зохицуулалттай үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн үйлчилгээни шимтгэл хураамжийн хэмжээ өндөр гэж үзсэн тохиолдолд бууруулах чиглэл өгөх бүрэн эрхтэй байдаг бөгөөд Хорооноос арилжаа эрхлэх байгууллагын шимтгэл хураамжийн дээд хэмжээг

				тогтоодоггүй болно.
4	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	43.5 Барьцаа гэдгийг маржин дэнчин болгох	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд барьцаа гэсэн нэршлээр ашиглагдаж байна. Энэхүү барьцааны шаардлага нь үнэт цаасны зах зээлд компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд гаргах тохиолдолд шаарддаг.
5	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	Хорооны улсын байцаагчийн эрх үүргийг тодорхой зааж хэрэгжүүлмээр байна-Ганц компани арилжаа зогсоож байна - хэрэгжихгүй байна	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 85 дугаар зүйлд Хорооны улсын байцаагчийн бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд тус хуулиар олгогдсон бүрэн эрхийн дагуу Хорооны улсын байцаагчид хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.
6	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг энэ хуультай нийцүүлмээр байна	Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн



				<p>хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Сангийн яамны зүгээс Уул уурхайн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах үед Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай нийцүүлэн боловсруулах саналыг тухай бүр хүргүүлэн ажилласан тул Уул уурхайн биржийн тухай хууль нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай нийцсэн болно.</p>
7	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	ТӨК-ийн хувьчлал дээр урт хуцацааны төлөвлөгөөг тодорхой болгомоор байна- Төр байнга дийлэнх хувьцаа эзэмшигч байхымуу	<p>Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд УИХ-ын 2022.04.29-ний өдрийн 16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг баталсан.</p> <p>Улмаар Засгийн газраас 2022.06.29-ний өдрийн хуралдаанаар 2022-2023 онд</p>

				<p>биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалтад "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Үндэсний давхар даатгал" ХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ болон бусад нэр бүхий 20 АЗЗА багтсан.</p> <p>Энэхүү УИХ, Засгийн газрын зүгээс шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд санаачлан хэрэгжүүлж буй төрийн өмчит хуулийн этгээдийн хувьчлал нь нэг талаас төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, ашигт ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулж, улсын төсөвт учрах дарамтыг бууруулахаас</p>
--	--	--	--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

				<p>гадна нөгөө талаас дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.</p> <p>Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийн дагуу төрийн өмчит 25 компанийн 34 хүртэлх хувийг олон нийтэд санал болгон худалдаж нээлттэй компани болгохоор тусгасан талаар өмнө дурдсан.</p> <p>Тэгвэл энэхүү бодлого, шийдвэрүүдийн хүрээнд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь төрийн өмчит бусад компаниудыг түүчээлэн хамгийн эхэнд нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмж гаргах хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 690 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.</p> <p>"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь хувьцааныхаа</p>
--	--	--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

				анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан.
8	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	Долларын бонд гаргаж болохгүй юу зохицуулалт нээх боломж байна уу?	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д "Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно" гэж заасан байдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос дотоодын зах зээлд долларын бонд гаргахыг бодлогын хувьд

				дэмжин ажилладаг бөгөөд Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан тохиолдолд доллараар илэрхийлэгдсэн бондыг бүртгэх боломжтой.
9	Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөл	2022.10.07	Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулах талаар	Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрх хэмжээний хүрээнд жижиг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан, удирдлагуудад шаардлага хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг

				хяналт, зохицуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг тухай бүр авч хэрэгжүүлж байна.
10	Үнэт цаасны компанийн төлөөлөл	2022.10.07	Гадаадын хөрөнгө оруулагчдын суутган татварын асуудлыг цэгцлэх шаардлагатай байгаа. Энэ асуудал тусгагдсан уу?	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан хуульд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн татварын асуудлыг сайжруулах талаар заалтуудыг тусгасан.